



**Arlington Public Schools**  
**ДУНД СУРГУУЛИЙН**  
**СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**  
**2022-2023**

**GUNSTON**  
**ДУНД СУРГУУЛЬ**  
2700 South Lang Street  
Arlington, VA 22206  
(703) 228-6900

**KENMORE**  
**ДУНД СУРГУУЛЬ**  
200 South Carlin Springs Road  
Arlington, VA 22204  
(703) 228-6800

**DOROTHY HAMM**  
**ДУНД СУРГУУЛЬ**  
4100 Vacation Lane  
Arlington, VA 22207  
(703) 228-2910

**SWANSON**  
**ДУНД СУРГУУЛЬ**  
5800 North Washington Blvd.  
Arlington, VA 22205  
(703) 228-5500

**THOMAS JEFFERSON**  
**ДУНД СУРГУУЛЬ**  
125 South Old Glebe Road  
Arlington, VA 22204  
(703) 228-5900

**WILLIAMSBURG**  
**ДУНД СУРГУУЛЬ**  
3600 North Harrison Street  
Arlington, VA 22207  
(703) 228-6200

የመካከለኛ ደረጃ ት / ቤት የጥናት ፕሮግራም በእንግሊዝኛ ጽ / ቤቶች በሁሉም የአርሊንግተን የህዝብ ትምህርት ቤቶች ውስጥ ይገኛል  
ወይም ድር ጣቢያው ላይ: [www.apsva.us](http://www.apsva.us)

العامة Arlington برنامج الدراسات للمدرسة المتوسطة متاح أيضًا باللغة الإنجليزية في مكاتب التوجيه في جميع مدارس  
[www.apsva.us](http://www.apsva.us) أو على الموقع الإلكتروني

Дунд сургуулийн сургалтын хөтөлбөрийг Арлингтон хотын бүх сургуулиудын холбогдох байгууллагуудаас англи хэл дээр авах боломжтой буюу энэ вэбсайтаар орж авна үү: [www.apsva.us](http://www.apsva.us)

The Middle School Program of Studies is also available in English in guidance offices at all Arlington Public Schools or on the website: [www.apsva.us](http://www.apsva.us)

**ARLINGTON MIDDLE SCHOOL СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР  
АГУУЛГА**

Сургалтын ерөнхий захирал Bridget Loft-ын захидал.....	3
Оршил.....	5
Зорилгын тухай .....	5
Оюуны хөгжил .....	5
Үндсэн хичээлийн хөтөлбөр .....	5
Танин мэдэхүйн/Сонгон суралцах хөтөлбөр.....	6
Хичээлээс гадуурх хөтөлбөр (Act II).....	6
Хүүхэд бүрт тохируулах.....	6
Гүнзгийрүүлсэн хичээлүүдэд бэлтгэх нь .....	7
Бэлтгэл хийхээс чөлөөлөх .....	7
Сургалтын сурган хүмүүжүүлэх чиглэл .....	8
6-р ангийн хичээлийн үндсэн хөтөлбөр.....	9
7-р ангийн хичээлийн үндсэн хөтөлбөр.....	15
8-р ангийн хичээлийн үндсэн хөтөлбөр.....	25
Нэмэлт хичээл/хөтөлбөр	
Gunston дунд сургууль.....	37
Испани хэлний дадлагын хөтөлбөр болон Дунд сургуулийн Монтессори хөтөлбөр	
Thomas Jefferson Middle School.....	39
Олон улсын бакалаврын дунд сургуулийн хөтөлбөр	
Kenmore дунд сургууль.....	41
Урлаг ба харилцааны технологи төвтэй хөтөлбөр	
Swanson дунд сургууль .....	45
Тусгай сурагчид	
Тусгай боловсролын үйлчилгээ авах сурагчид .....	46
Англи хэл сурагчийн (АХС) үйлчилгээ авах сурагчид.....	46
Гоц авьяастай сурагчдад үзүүлэх үйлчилгээг авах сурагчид.....	47
Номын сангийн үйлчилгээ .....	47
Сургуулиас гадуурх тамирчны хөтөлбөр.....	47
Нийгэм сэтгэл зүйн өсөлт.....	48
Багш зөвлөхийн хөтөлбөр .....	48
Сурагчдад үзүүлэх үйлчилгээний хэлтэс .....	48
Тусгай боловсролын газар.....	48
Гэртээ байх чөлөө авах заавар .....	49
Сурагчдын үйл ажиллагаа .....	49
Гэр/сургуулийн хамтын ажиллагаа ба харилцаа .....	49
Дунд сургуулийн стандарт шалгалтууд.....	50
Дунд сургуульд ахлах сургуулийн кредит авах хичээлүүд.....	50
Ахлах сургуулийн боломжууд.....	51
Санал болгож буй математикийн хичээлийн зам.....	52
Дэлхийн хэлнүүд сургалтын дараалал .....	54
Ахлах сургууль төгсөхөд тавигдах шаардлага .....	





2022 оны 1-р сар

Хүндэт Арлингтоны гэр бүлүүд ээ,

Дунд сургуульд тавтай морил! Таныг дунд сургуулийн хичээлийн хуваарь дарааллыг төлөвлөх явцдаа, энэхүү баримт бичгийг өөрийн лавлагаа, хөтөч болгон ашиглана гэж бид найдаж байна. Энэхүү Сургалтын хөтөлбөр нь сурагчид болон эцэг эхчүүдэд сургуулиар өгч буй сургалтууд болон үйлчилгээнүүдийн талаар ерөнхий болон нарийн тодорхой мэдээллийн аль алиныг нь хүргэх болно. Бид товч бөгөөд тодорхой байхын тулд дунд сургуулийн олон онцлогийн талаар тойм бэлтгэн тухай бүрийн зорилтуудыг тайлбарласан. Та дараах хаягаар дунд сургуулийн зөвлөх үйлчилгээнд холбогдон ихэнх сэдвээр илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой:

Dorothy Hamm Дунд сургууль	703/ 228 - 2910
Gunston Дунд сургууль	703/ 228 - 6909
Jefferson Дунд сургууль	703/ 228 - 5908
Kenmore Дунд сургууль	703/ 228 - 6798
Swanson Дунд сургууль	703/ 228 - 5508
Williamsburg Дунд сургууль	703/ 228 - 5445

Сурагчид өөрсдийн сонирхлыг даган, мэдлэг туршлагаа тэлэхийн хэрээр маш олон боломж сонголтуудтай байх болно. Сурагчид, эцэг эхчүүд болон зөвлөх багш нар хамтран дунд сургуулийн гурван жилийн төлөвлөлтийг хийж, зохих өөрчлөлтүүдийг явцын дунд хийх нь зүйтэй. Сурагчдын урт хугацааны зорилтууд болон тэдний сонирхол, мөн түүнчлэн төгсөхөд тавигдах шаардлага зэрэг нь таныг шийдвэр гаргахад туслах хөтөч болно. 2022-23 оны Сургалтын хөтөлбөр нь төлөвлөх болон ирээдүйг харах үйл явцад дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн сургуулийнхаа Зөвлөх үйлчилгээний оффистой хамтран ажилласнаар танай хүүхэд авах боломжтой олон дэмжлэгийг олж мэдэхэд тустай.

Сурагчдын тодорхой хэрэгцээг хангах өвөрмөц чиглэлийг баримталсан тусгай хөтөлбөрүүдийг хэд хэдэн дунд сургуульд мөн нэвтрүүлсэн байдаг. Бусад бүх хичээлүүд бүх таван дунд сургуульд орж байгаа.

Таныг чиглүүлэх өдөрлөг, Хичээлийн шинэ жилийн үдэшлэг болон бусад хуваарьт арга хэмжээгээр дамжуулан сургуультайгаа харилцаа холбоотой байхыг уриалж байна. Түүнчлэн та өөрийн хүүхдийн зөвлөх рүү залгаж, ганцаарчилсан уулзалтын цаг авах боломжтой.

Таны хүүхэд дунд сургуульд суралцах жилүүдэд зориулсан олон боломжуудыг та бүрэн ашиглана гэж бид найдаж байна.

Хүндэтгэн ёсолсон,

Bridget Loft

Орлогч тэргүүн, Сургалтын ерөнхий захирал



## **ДУНД СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

### **УДИРТГАЛ**

Арлингтоны дунд сургууль сурагч тус бүрийн оюуны, биеийн, нийгмийн болон сэтгэл зүйн өсөлтийг дэмжих зорилго бүхий зохион байгуулалттай. Энэхүү сургалтын хөтөлбөр нь дунд сургуулиудын хичээлийн хөтөлбөр, үйлчилгээ болон үйл ажиллагааг 6, 7 болон 8-р ангийн сурагчдад зориулан чиглэл тус бүрээр тусгасан болно.

Дотоодын стандартуудын зэрэгцээ, Виржиния Мужийн Боловсролын Зөвлөл болон Коллеж, Сургуулиудын Өмнөдийн Холбоо хамтран чанартай боловсролын суурь тавихад чиглэсэн магадлан итгэмжилсэн стандартыг бий болгосон. Магадлан итгэмжилсэн стандартууд нь сургуулиудад өөрсдийн сурагчдын хэрэгцээ, сонирхол болон зорилго тэмүүллийг хангах сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх оролдлогыг дэмжсэн удирдамж, чиглэл болдог. Магадлан итгэмжилсэн стандартуудыг дараах зорилтуудыг хангах зорилгоор боловсруулсан:

1. Сургуулиуд өндөр чанартай боловсролын хөтөлбөрийг бүх сурагчдад зориулж хэрэгжүүлэхийг эрмэлзэх.
2. Сургалтын хөтөлбөрийг тасралтгүй үнэлж дүгнэн, сайжруулдаг байх.
3. Олон нийтийн итгэлийг хүлээх
4. Сургалтын бусад байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдөх.

### **ЗОРИЛГЫН ТУХАЙ**

Арлингтоны дунд сургуулиуд арваас арван дөрвөн настай өсвөр насныханд тасралтгүй суралцах, нийгэмших, сэтгэл зүйн өсөлт болон бие бялдрын эрүүл байдлыг хангах хүүхэд-төвтэй сургалтын арга хэлбэрийг баримтална. Дунд сургууль нь багш, ажилтан, эцэг эх, олон нийт болон сурагчдын идэвхтэй дэмжлэг оролцоотойгоор харилцан хүндэтгэж ойлголцсон, олон янзын хүмүүс болон олон үндэстнийг хүндэтгэсэн орчныг бүрдүүлнэ.

Бага ангиас дунд, дундаас ахлах ангид шилжих жилүүдэд нь сурах, өсөж хөгжих эрх тэгш орчныг 6-8-р ангиудын өсвөр насныханд Арлингтоны дунд сургуулиуд бүрдүүлнэ. Хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, ажилтны хөгжлийг хангахад дунд сургуулийн сурагчдын оюун, нийгэм, сэтгэл зүй болон бие бялдрын өсөлт гол цөм нь байна. Тэнхим хооронд багш нар баг болж ажиллах, хуваарийн уян хатан байдал, багшийн зөвлөх хөтөлбөрүүд, танин мэдэхүйн боломжууд, сургуулийн дараах өргөн хүрээний үйл ажиллагаанууд нь дунд сургуулийн салшгүй чухал хэсэг байна. Анхаарал халамжтай орчинд үр дүнтэйгээр, цогцоор авсан сургалтаар дамжуулан сурагчид тунгаан бодогч, бүтээлч, нийгэмд хувь нэмрээ оруулдаг гишүүд болох болно.

### **ОЮУНЫ ХӨГЖИЛ**

Боловсролын анхдагч үүрэг бол сурагчдад зориулан ажилтан, албан хаагчдын бэлтгэн чиглүүлсэн суралцах үйл ажиллагаагаар дамжуулан оюуны хөгжлийг дэмжих юм. Дунд сургуульд 6, 7 болон 8-р ангийн сурагчид тодорхой хуваарийн дагуу үндсэн академик хичээлүүдийг (Англи хэл, математик, шинжлэх ухаан, нийгмийн ухаан, 6-р ангид унших бичиг) суралцаж, өдрийн үлдсэн хугацаанд үндсэн бус хичээл болон танин мэдэхүйн/сонгон суралцах хөтөлбөрүүдэд хамрагдана.

### **ҮНДСЭН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

Сурагчид үндсэн хичээлд зориулан групп эсхүл багуудад хуваарилагдана. Ингэснээр ойролцоогоор нэг түвшний тавиас нэг зуун хорин таван сурагчид үндсэн хичээл заадаг хоёроос таван багшид хуваарилагдан нэг баг болно. Эдгээр багш нар багийн төлөвлөлтийн үеэр уулзалт хийх замаар хамтран ажиллаж, сурагчдын заавар чиглэл авах хэрэгцээ, удахгүй болох үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг хэлэлцэн, судлах хичээлийн хэрэгцээнд тулгуурлан хуваарийг гаргаж, нэгдсэн хөтөлбөрийг боловсруулна. Багш нарын багууд шаардлагатай тохиолдолд тухайлбал төсөл хэрэгжүүлэх, ижил ур чадварын заавар, холбогдох онол эсхүл тодорхой сэдвийн хүрээнд өөр хичээлийн сэдвүүдийг нэгтгэн хичээл хоорондын уялдаа холбоог онцолсон суралцах орчныг бүрдүүлнэ. Түүнчлэн багууд

мэргэжил сонголтын боловсролын үйл ажиллагааг үндсэн хичээлд тусгаж өгнө. Хэдийгээр сурагчид тодорхой нэг баг, багш нарт хуваарилагдах боловч зарим нэг зааварчлах үйл ажиллагааны явцад сурагчдыг дахин хуваарилж болно. Багш нар тухайн сурагчийн хэрэгцээ болон ахиц дэвшилд үндэслэж дахин хуваарилалтын шийдвэрийг багийн уулзалтын үеэр гаргана. Тодорхой нэг ур чадварыг нь сайжруулах шаардлагатай сурагчдад үндсэн хичээлийн цагаар эсхүл өөр бусад хичээл/хөтөлбөрөөр давтлага өгнө.

## **ТАНИН МЭДЭХҮЙН/СОНГОН СУРАЛЦАХ ХӨТӨЛБӨР**

Дунд сургуульд танин мэдэхүйн/сонгон суралцах хичээлээр дамжуулах төрөл бүрийн суралцах орчин нөхцөлийг бий болгодог. Эдгээр хичээлээр дамжуулан мэргэшсэн ажилтнууд болон дунд сургуулийн тусгай байгууламжийн тусламжтайгаар сурагчид шинэ сонирхол хөгжүүлэх, шинэ авьяас нээх боломжтой. Сонгон суралцах хичээлийг хангалттай тооны сурагчид элсэн орсон тохиолдолд заана. Танин мэдэхүйн болон сонгон суралцах хичээл нь уулзалтын хуваарь болон хамрах агуулгын хувьд харилцан адилгүй байна.

Сургалтын хөтөлбөрт орсон бүх хичээлүүдэд сурагч хамрагдах хүсэлт гаргах боломжтой. Хичээлийн хуваарийг эцсийн байдлаар гаргахдаа сурагчийн сонирхол болон төсвийг харгалзан үзэж 15-с бага сурагчидтай сургалтыг явуулахгүй байж болно. Иймд сонгох хичээлийг мөн харгалзаж үзсэний үндсэн дээр зохих хуваарыг гаргана. Хуваарь давхцаж байгаа бол өөр хичээл сонгох шаардлагатай болж болзошгүй. Харьяалах сургуульд нь хүссэн хичээл нь цуцлагдсан тохиолдолд сурагчид өөрийн дүүрэг дэх өөр сургуульд орон тоо байгаа бол тэнд хамрагдах боломжтой. Эцэг эх нь хүргэж өгч, авах шаардлага гарч болзошгүй. Хичээл цуцлагдсан эсвэл аливаа давхцал үүссэн тохиолдолд сурагчдын сонирхол, хэрэгцээг хангах бүхий л оролдлогыг хийх болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас эсхүл онлайн сургалтаар зааж болно.

## **ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ХӨТӨЛБӨР (АСТ II)**

Аст II нь хичээлийн цаг дууссаны дараа сурагчид нэмэлт сонгох хичээл авах боломжийг олгоно. Аст II-ын хүрээнд явуулж буй хичээлүүд нь Сургалтын хөтөлбөр дэх сонгон суралцах хичээлүүд бөгөөд сурагчийн сонирхол болон хуваариас хамаарч сургууль бүрд харилцан адилгүй байна. Хичээлүүд өөр хуваариудаар (жишээ нь: 7 хоногийн 2 өдөр ба илүү урт цагаар эсвэл бусад нэмэлт хувилбаруудтайгаар) үдээс өмнөх хичээлүүдийн адил нарийн тодорхой заагдана. Заавал суух ёстой бөгөөд дүнгээр үнэлэгдэнэ. Тээвэрлэлтийн хувьд одоо мөрдөж буй оройн цагийн хуваарийн дагуу автобусаар үйлчилнэ.

Аст II-ын ангиудад хамрагдах хүсэлтээ илэрхийлэх боломжуудыг эрж хайх буюу өөрийн түвшний ангийг хариуцсан зөвлөхтэй улирал бүр танай сургуульд авах боломжтой Аст II-ын боломжуудын талаар ярилцаарай.

## **ХҮҮХЭД БҮРТ ТОХИРУУЛАХ**

Тохируулан зааж сургах гэж хүүхэд бүр ижил арга замаар сурдаггүй гэсэн итгэл үнэмшилд суурилж заах, сургах арга барилыг хэлнэ. Энэ нь дараахад суурилдаг:

- Бэлэн байдал (сурагчийн өмнөх мэдлэг, ойлголт, ур чадвар эзэмшсэн байдал)
- Сонирхол (сурагчийн илүү ихийг мэдэхийг хүсэхэд хүргэх “дэгээ” сониуч байдал болон сонирхол эрмэлзэл)
- Суралцах шинж чанар (сурагч хэрхэн сурахыг илүүд үздэг болох)

Заавар чиглэлийг ялгахдаа багш нар дараах үр дүнд хүргэх төрөл бүрийн заах арга хэлбэрийг төлөвлөн хэрэгжүүлдэг:

- Сурагчийн бэлэн байдал, сонирхол болон/эсхүл суралцах шинж чанарыг үнэлэх
- Нарийн төвөгтэй даалгаврын хувьд сурагчийн амжилтыг дэмжих зорилгоор сурагчийн суралцах зорилгыг нэн тэргүүнд тавих
- Агуулга (сурагч юу сурах), үйл явц (сурагч ямар үйл ажиллагаагаар суралцаж буй), эсхүл бүтээгдэхүүн (сурагч юу сурсан болохыг үзүүлэх)

Төрөл бүрийн түвшний сурагчид багш зөвлөх, эрүүл мэнд болон бие бялдрын боловсрол, сонгон суралцах болон танин мэдэхүйн хичээлүүдэд хуваарилагдана. Төрөл бүрийн түвшний сурагчид үндсэн хичээлийн сэдвүүдээр

заавар чиглэл авах багуудад хуваарилагдана. Багш нар тохируулан зааж сургах байдлаар сургалтаа хийх ба үүнд өөрчлөгдөх сургалтын бүлгүүд багтаж болно.

Заавар чиглэл өгч сургах төрөл бүрийн арга барил, өмнөх үнэлэлт дүгнэлт өгөх стандартуудын дагуу авсан шалгалтуудын дүн, тодорхой сэдвээр авсан сорилууд, өнөөгийн болон өмнөх ангиудад үзүүлсэн тухайн сурагчийн амжилт, сурагчийн талаарх багшийн өөрийн мэдлэг, үнэлгээ зэргийг харгалзаж багш нар уян хатан бүлэгт сурагчийг хэрхэн хуваарилах тухай шийдвэр гаргана.

## **ГҮНЗГИЙРҮҮЛСЭН ХИЧЭЭЛҮҮДЭД БЭЛТГЭХ НЬ**

Арлингтоны улсын сургуулиуд бүх сурагчдыг ахисан түвшний хичээлүүдэд элсэн, амжилттай суралцахыг уриалдаг. Ахисан түвшний хичээлд амжилттай суралцсанаар сурагчдад өөрөөрөө бахархах сэтгэл төрж, өөртөө итгэх итгэл нэмэгдэж, суралцах ур чадвар нь сайжирч, дараа дараагийн ахисан түвшний хичээлүүдэд болон сургуулиас цааш амьдралдаа илүү амжилт гаргах суурь тавигдана. Гэхдээ ахисан түвшний хичээлд элсэн орох хүсэлтэй байх нь цорын ганц шалгуур биш юм. Суурь мэдлэг, чадвар сайн байх шаардлагатай бөгөөд үүнээс ахисан түвшний ангид амжилттай суралцах эсэх хамаарна.

Иймд сурагчид бүх хичээлд шамдан суралцаж, амжилттай суралцах суурийг сайн тавих нь чухал юм. Үүнд үр дүнтэй суралцах арга барилаа сайжруулах, даалгаврыг заасан хугацаанд биелүүлэх, тусламж дэмжлэг авдаг байх буюу шаардлагатай үед нэмэлт цаг зарцуулах болон ахисан түвшний сургалтын үндэс болох суурь сургалтуудад амжилттай суралцах багтана. Аливаа хичээлийн хамгийн доод шаардлагыг хангаад зогсохгүй, даалгаврыг илүү сайн хийхийг хичээх буюу бусад хөгжүүлэх, ур чадвар нэмэгдүүлэх сургалтуудад оролцохыг хичээж чармайж суралцах гэдэгт ойлгоно. Ахисан түвшний хичээлүүдэд орж, амжилттай сурахын тулд эдгээр ур чадваруудыг олж авах, хөгжүүлэх, ахиулахын төлөө сурагчид, эцэг эхчүүдийн зүгээс багш, зөвлөхүүдтэй ойр нягт хамтарч ажиллах хэрэгтэй юм. Бүх 6-р ангийн сурагчид, зөвлөхүүд болон эцэг эхчүүдтэйгээ хамтарсан зөвлөгөөнөөр Зургаан жилийн хичээлийн төлөвлөгөө гаргаж, жил бүр түүнийгээ шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Уг Зургаан жилийн төлөвлөгөө нь сурагчид 9-р ангид орох үед дөрвөн жилийн төлөвлөгөөгөөр солигдох бөгөөд энэ нь мөн адил ахлах сургуулийн жил бүр шинэчлэгдэнэ.

Сурагчийн сонгосон хичээл буюу сонгосон зүйл нь илүү баяжуулсан буюу түргэвчилсэн агуулгатай бөгөөд “ахисан түвшний” эсхүл “гүнзгийрүүлсэн” хичээл гэж тодорхойлсон бол түүнийг ахисан түвшний хичээл гэж үзнэ. Жишээлбэл, 8-р ангийн геометрийг ахисан түвшний хичээл гэж үзэх хэдий ч 10-р ангийн геометрийг ахисан гэж үзэхгүй. Дунд сургуульд байхдаа Дэлхийн хэл, Алгебр I, Геометр зэрэг ахлах сургуулийн кредит цуглуулах боломжтой хичээлүүдийг зарим сурагчид авах бол дунд сургуулийн сурагчдын хувьд ахисан түвшний хичээл гэж үзнэ (8-р ангийн сурагчид бүгдээрээ ахлах сургуулийн кредит Газарзүйн хичээлээр авах бол ахисан түвшний хичээл гэж үзэхгүй). Эдгээр хичээлүүд нь ахлах сургуульд авах хичээлүүдийг тодорхойлох нөхцөл болно. Доорх хүснэгтэд дунд сургуульдаа эрчимжүүлсэн хичээлүүд сонгосон нь тухайн сурагч ахлах сургуульд авах хичээлүүдийн сонголт, боломжуудад хэрхэн нөлөөлж болохыг хоёр жишээгээр харуулна.

Хичээл:	Үр нөлөө:
Алгебр I	Математикийн хичээлийг Алгебр I, Геометр, Алгебр II гэсэн дараалалтай үзнэ. Ахлах сургуульд шинжлэх ухааны эрчимжүүлсэн хичээлүүд авах сонирхолтой сурагчид 10-р ангидаа гүнзгийрүүлсэн химийн хичээл авна. (Ахисан түвшний хичээлүүд нь сурагчид ахлах сургуульд байх хугацаандаа коллежийн кредит цуглуулах боломж бүрдүүлнэ.) Алгебра II бол Гүнзгийрүүлсэн химийн хичээлд тавих хавсарсан шаардлага юм. Түүнчлэн Алгебр I нь ахлах сургуулийн хичээл учир 8-р ангидаа Алгебр I-ийг амжилттай суралцсан байх нь эрт төгсөх кредит авах боломжийг тухайн сурагчид олгоно.
Испани хэл I ба II	Испани хэл II хичээлийг 9-р ангид авснаар сурагч 10, 11, 12-р ангидаа Испани хэл III, IV болон V хичээлийг үзэх боломжтой. Өөр нэг хувилбар нь тухайн сурагч ахлах сургуульдаа хоёр жилийн хугацаанд өөр хэл суралцах боломжтой. Коллежид тэнцэхэд чухалд тооцогддог Ахисан сургалтын дипломыг авахын тулд нэг хэлийг гурван жил эсхүл хоёр өөр хэлийг тус бүр хоёр жил үзсэн байх шаардлагатай болохыг анхаарна уу.



## БЭЛТГЭЛ ХИЙХЭЭС ЧӨЛӨӨЛӨХ

Дунд сургууль эхлэх үед сурагчид ахисан шатны хичээлд бүртгүүлж болно. Ахисан шатны хичээлд суухын тулд бэлтгэл хичээл хийх ёстой байж болно. Ахисан шатны хичээлд амжилттай суухад ямар мэдлэг чадвар шаардлагатай талаар сурагч, эцэг эхчүүд мэдэж авахад бэлтгэл хичээл тусална. Бэлтгэл хичээлд суух шаардлагыг хангаагүй байсан ч эцэг эхчүүд хүүхдээ ахисан шатны хичээлүүдэд бүртгүүлж боловч бэлтгэл хичээлд суух хэрэгтэй гэж зөвлөмж байна. Эцэг эхчүүд сургуулийн ажилтан, ялангуяа өөрийн хүүхдийн зөвлөхтэй энэ талаар хэлэлцэж, зөвлөлдөх нь зүйтэй. Ийнхүү санал солилцох нь тухайн сурагчийн амжилт гаргах магадлалыг нэмэгдүүлж, тэдгээр хичээлд тавигдах шаардлагыг эцэг эхчүүдэд ойлгуулна. Хэрэв аливаа эцэг эх тухайн сурагчид анхнаасаа санал болгоогүй хичээлд сурагчийг элсүүлэхээр шийдвэл тухайн эцэг эх энэ шийдвэрийнхээ талаар сургуулийн хичээлийн жил дуусахаас өмнө эсхүл тухайн хичээлд бүртгэгдсэн тухай мэдэгдэл хүлээн авмагц сургуулийн ажилтанд мэдэгдэх нь зүйтэй.

### СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ БАГТСАН ХИЧЭЭЛҮҮД

Сурагчид дунд сургуулийн анги тус бүрт сурах ёстой гол ур чадвар, агуулгыг дараах хуудаст зааж өгөв. Сурагчид мөн тусгай хичээлүүдэд бүртгүүлж болно. **Энэхүү жагсаалт нь сурагчдад заах, сурагчид сурах ёстой зүйлийн бүрэн жагсаалт биш гэдгийг анхаарна уу.** Анги тус бүрийн зорилго, хөтөлбөрийн тодорхойлолттой бүрэн танилцах хүсэлтэй эцэг эхчүүд орон нутгийн болон мужийн сургалтын хөтөлбөрийн хөтөч болон сургууль тус бүрээс авах боломжтой танилцуулгыг үзэж, сургалт хариуцсан эрхлэгчтэй холбоо барина уу.

УРЛАГИЙН БОЛОВСРОЛ, Pam Farrell, Эрхлэгч .....	703-228-6169
БИЗНЕС МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, КОМПЬЮТЕРЫН ШИНЖЛЭХ УХААН, МАРКЕТИНГ, ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ, ГЭР БҮЛ, ХЭРЭГЛЭГЧИЙН ШИНЖЛЭХ УХААН, Phyllis Gandy, Эрхлэгч.....	703-228-7213
МЭРГЭЖИЛ, ТЕХНИКИЙН, НАСАНД ХҮРЭГЧДИЙН БОЛОВСРОЛ, Kris Martini, Захирал .....	703-228-7207
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ, Sarah Putnam, Захирал.....	703-228-2879
АНГЛИ ХЭЛ, СОЁЛ, Lori Silver, Эрхлэгч.....	703-228-8045
АНГЛИ ХЭЛ СУРАЛЦАГЧИД, Sam Klein, Эрхлэгч .....	703-228-6091
ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, Cheryl McCullough, Эрхлэгч .....	703-228-6160
ЭРҮҮЛ МЭНД, БИЕ БЯЛДРЫН БОЛОВСРОЛ, Deborah DeFranco, Эрхлэгч.....	703-228-6165
МАТЕМАТИК, Shannan Ellis, Эрхлэгч.....	703-228-6135
ШИНЖЛЭХ УХААН, Dat Le, Эрхлэгч.....	703-228-6166
НИЙГМИЙН УХААН, Kerri Hirsch, Эрхлэгч .....	703-228-6140
ДУНД СУРГУУЛИЙН БОЛОВСРОЛ, Tyrone Byrd, Захирал .....	703-228-7222
ТУСГАЙ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ, Heather Rothenbuescher, Захирлын үүрэг гүйцэтгэгч.....	703-228-6055
ДЭЛХИЙН ХЭЛНҮҮД, Elisabeth Harrington, Эрхлэгч .....	703-228-6097

## **6-Р АНГИЙН ХИЧЭЭЛИЙН ҮНДСЭН ХӨТӨЛБӨР**

6-р ангийн сурагчид үндсэн хичээлийн цагаар дараах хичээлийг суралцана. Сурагчид хичээлийн сэдэв бүрээр шаардлагатай хэмжээгээр сурсанаа сэргээж, цааш баяжуулна. (Тохируулан зааж сургахтай холбоотой мэдээллийг 6-р хуудаснаас харна уу.)

*Тайлбар: 15-с бага тооны сурагч бүртгүүлсэн бол сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзсанаар хичээлийг заахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

### **АНГЛИ ХЭЛ, СОЁЛ**

#### **6-р ангийн Англи хэл (11109)**

Бүх дунд сургуулиудад Англи хэл, соёлын хөтөлбөр нь Виржиниягийн Англи хэл суралцах стандартуудад заасан дөрвөн чиглэлийн хүрээнд голлон анхаарна: харилцаа болон олон хэлбэрийн бичиг үсэг тайлал, унших, бичих болон судлах. Эдгээр чиглэлээр ур чадвартай байх нь сурагчийн ахисан түвшинд тунгаан бодоход нөлөөлж, хичээлдээ болон хичээлээс гадуур амжилтад хүргэхэд хөтөлнө. Сургалтын хөтөлбөр нь ойлгуулах, чухал асуултуудыг хөндөхөд чиглэсэн үзэл баримтлал, аргачлалд тулгуурлана.

- Унших хэсэгт бодит түүх, зөгнөл түүхийг харьцуулахад голлон анхаарна. Уран зохиолын хувьд сурагчид гол сэдвийг тодорхойлох, дүрслэлд ашигласан хэл зүйд дүн шинжилгээ хийх зэргээр хүүрнэн өгүүлэх бүтцийн элементүүдийг олж танина. Бодит баримтаг зохиолыг уншихдаа аль нэг талыг бариагүй дүгнэлт хийх, зохиол дахь текст нотолгоог ашиглан таамаг дэвшүүлэх зэрэгт ач холбогдол өгнө.
- Сурагчид үгийн эх сурвалжийг судалж эхлэх бөгөөд үгсийн сангаа үргэлжлүүлэн нэмэгдүүлнэ.
- Сурагчид хүүрнэл өгүүллэг, сэтгэгдэл бичлэг голчилсон хэлбэрээр төрөл бүрийн зохион бичлэгүүд төлөвлөж, төсөл бичиж, засаж найруулж, хянан тохиолдуулна.
- Сурагчид бие даан болон багаар олон хэлбэрийн илтгэл танилцуулна. Төрөл бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн форматад буй мэдээллийг сурагчид тайлбарлана.
- Сурагчид багийн ажилд хувь нэмэр оруулахын зэрэгцээ, удирдан явуулна.
- Сурагч судалгааны ажилдаа зориулж хайлт хийж, үнэлэлт дүгнэлт өгч, тохирох эх сурвалжийг сонгож, анхдагч болон хоёрдогч

эх сурвалжаас эшлэл авч сурна. Бусдын бүтээлийг хулгайлах талаарх ойлголт, түүний үр дагаврыг онцлон танилцуулна.

#### **6-р ангийн Унших бичиг**

##### **Бүтэн жил (11106)**

##### **Улирал (11108)**

*Улирлаар судлах хичээлийн бэлтгэл. Өмнөх уншлагын шалгалт дээр өндөр оноо авсан байх.*

Бүтэн жилийн турш Унших чадварын хичээлд суухыг зургаадугаар ангийн бүх сурагчдад зөвлөж байна. Энэ нь бага ангид тавих унших чадварын шаардлагаас дунд сургуулийн шаардлагыг хангахад шилжихэд сурагчдад дэмжлэг болно. Уг хичээл нь Харилцаа ба Олон хэлбэрийн бичиг үсэг тайлал, Унших чадварт тавих Виржиния мужийн стандартад анхаарах болно. 6-р ангийн Унших чадварын хичээлээр багш нар унших арга зүйн дараах зүйлд анхаарал хандуулна: унших үйл явц, үгийн үндэс гаралд анхаарсан үгийн баялаг, баримтаг болон уран зохиолыг хэрхэн судлах тухай. Үр дүнтэй уншигчид уншихын өмнө, унших явцад болон дараа нь утгыг нь ойлгохын тулд стратеги ашигладаг болохыг сурагчдад ойлгуулна. Сурагчид бусад агуулгыг судлан суралцахад унших чадварыг арга хэрэгсэл болгон ашиглана. Ойлгон унших стратегийг тодорхой зааж, тэдгээрийг хэрхэн хэрэглэхийг удирдан чиглүүлж, бие дааж уншуулах—үүнд номын клубүүд болон сонирхлоороо таалан унших—зэрэг нь мөн энэ хичээлийн үндсэн чухал элементүүд юм.

Улирлаар судлах боломж нь зарим сургуульд байхгүй болохыг анхаарна уу. Учир нь үүнийг Дэлхийн хэлний (Франц, Испани, Латин, Испани), чөлөөтэй ярьж чаддаг хүмүүст зориулсан Испани хэл эсхүл Шилжилтийн Испани хэлний анхан шатны хичээлүүдтэй хослуулах зорилгоор боловсруулсан. Улирлаар судлах боломжийг сонгон суралцаж буй сурагчид уншлагын шалгалтаар өндөр оноо авсан байх ёстой. Улирлаар судлах боломжийг судлах нь зөв эсэх талаар өөрийн багш болон зөвлөхтэйгөө зөвлөлдөнө үү.

#### **6-р ангийн Унших чадварын хичээл**

##### **Бүтэн жил (11102)**

##### **Улирал (11101)**

6-р ангийн Унших чадварын хичээлийг ангийн түвшнээс доош түвшинд уншиж, дунд сургуульд орж буй сурагчид авахыг зөвлөж байна. Энэ хичээлд багш нар тухайн сурагчид заах арга барилыг үнэлгээний өгөгдөл ашиглаж сонгоно. Сурагчдыг уншихад улам дуртай болгохын зэрэгцээ тухайн ангийн түвшинд хүргэж унших, ойлгох чадваруудыг суулгахад хичээлийн зорилго оршино. Уг хичээл нь Харилцаа ба Олон хэлбэрийн бичиг үсэг тайлал, Унших чадварт тавих Виржиния мужийн стандарт, Унших бичих

чадварыг системтэй дадлагажуулахад анхаарах болно. 6-р ангийн Унших чадварын хичээлийн үеэр багш нар дараах зүйлд анхаарна: насан турш унших дур сонирхолтой болгох, уншаад ойлгох арга эзэмших, уншигчийн хэв маягтай болох, үг унших ба үг хэллэгийг ойлгоход ялгаатай заах аргазүйг ашиглах, уран зохиолын болон уран зохиолын бус номоос суралцах. Тус хичээлийн салшгүй хэсэг нь номын клуб, өөрөө сонирхож унших байна.

## **ЭРҮҮЛ МЭНД БОЛОН БИЕ БЯЛДРЫН БОЛОВСРОЛ**

### **6-р ангийн Эрүүл мэнд болон бие бялдрын боловсрол (17110)**

6-р ангийн бүх сурагчид эрүүл мэнд болон бие бялдрын боловсролын хөтөлбөрт хамрагдана.

Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр нь эрүүл амьдралын хэв маягийг эзэмшихэд сурагчид мэдэх, ойлгох, хийх хэрэгцээ шаардлагыг онцолно. Заах арга зүйд өсвөр насныхны эрүүл мэнд, шийдвэр гаргах чадвар болон үр дагаврыг тусгана. Сурагчид үеийнхний дарамт шахалт, хувь хүний ялгаа болон үзэл бодлыг хүндэтгэх талаар ойлгож авна. Сурагчид нүүр тулсан болон онлайн харилцааны ур чадварт суралцана. Судлах сэдвүүдэд сэтгэл зүйн, сэтгэл мэдрэлийн, нийгмийн болон орчны эрүүл мэнд, аюулгүй байдал болон онцгой байдалд бэлэн байх, харилцаа, мансууруулах бодисын хэрэглээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гэр бүлийн амьдралын боловсрол зэрэг багтана. Биеийн тамирын хичээлийн хөтөлбөр хүний биеийн анатомийн мэдлэгт суурилж, биеийн хөгжлийг сайжруулахад чиглэнэ. Сурагчид хамтаар болон жижиг бүлгээр биеийн тамирын янз бүрийн дасгалуудыг хийж, хөдөлгөөний ур чадварт суралцана. Сурагчид эрч хүчээ тэнцвэртэй байлгах, хоол хүнс, биеийн эрүүл мэндийн талаар ойлгож, тайлбарладаг болно.

## **МАТЕМАТИК**

### **Математик 6 (13110)**

Математик 6 нь зургаадугаар ангийн сурагчдад зориулсан агуулгыг үндэс суурь сайтай заах голлох хичээл юм.

6-р ангийн стандарт нь бага сургуульд анхаарал хандуулж байсан бүхэл тооны арифметик үйлдлээс алгебрын суурьд шилжих шилжилт юм.

Сурагчид дараах ойлголтыг авна:

1. Тоо ба тооны тухай ойлголт
2. Тооцоолох ба тоймлох
3. Хэмжигдэхүүн ба геометр
4. Магадлал ба статистик
5. Хэв маяг, хэлбэр, функц ба алгебр

Түүнчлэн стандарт агуулга нь математик суралцахтай холбоотой дараах үйл явцын зорилгыг дэмжихэд чиглэгдсэн: Асуудал шийдвэрлэх, харилцаа, холбоо, төлөөлөл ба учир шалтгаан.

6-р ангийн математикийн хичээлийн Виржиния мужийн стандартуудыг (SOL) хангах агуулгын зарим тодорхой жишээг дурдвал:

- Бутархай, аравт, болон хувь зэргийг ашигласан үйлдэл, түүнчлэн төлөөлөх загвар болон өгүүлбэртэй бодлогууд.
- Бутархай, холимог тоо болон аравт бутархай ашигласан олон үйлдэлт бодит амьдрал дээрх өгүүлбэртэй бодлогууд.
- Бүхэл тооны загварууд болон үйлдлийн дараалал зэрэг бүхэл тоон үйлдлүүд.
- Бялуу хэлбэртэй, дугуй, дугуй график зэргийг ойлгож, таньж мэдэх.
- Тэнцвэрийн цэг, төвийн хүч зэргийг хэмжих.
- Пропорциональ харилцаа, түүнийг үгээр тайлбарлах, хувь хэмжээ, харьцааны хүснэгт болон график мөн хамаарна.
- Тэнцэтгэл болон үл тэнцэтгэл.

### **6-р ангийнханд зориулсан алгебрын бэлтгэл**

#### **Бүтэн жил (13128)**

6-р ангийнханд зориулсан Алгебрын бэлтгэл (6/7/8) нь 6, 7, 8-р ангийн Виржиния мужийн суралцах стандарт дахь дунд сургуулийн математикийн агуулгыг үндэс суурьтай, системтэй суралцах хичээл юм. Уг гүнзгийрүүлсэн сургалтад гүнзгийрүүлсэн Алгебр I болон геометрийн хичээлүүдийг үзэхийн өмнө эзэмших шаардлагатай бүх агуулгыг багтаасан.

Сурагчид алгебрын бэлтгэлд дараах сэдвээр ойлголттой болно:

1. Тоо ба тооны тухай ойлголт
2. Тооцоолох ба тоймлох
3. Хэмжигдэхүүн ба Геометр
4. Магадлал ба статистик
5. Хэв маяг, хэлбэр, функц ба алгебр

Түүнчлэн стандарт агуулга нь математик суралцахтай холбоотой дараах үйл явцын зорилгыг дэмжихэд чиглэгдсэн: Асуудал шийдвэрлэх, харилцаа, холбоо, төлөөлөл ба учир шалтгаан.

Энэхүү хичээлийн агуулга дахь илүү тодорхой жишээнээс дурдвал:

- Бутархай, аравт, болон хувь зэргийг ашигласан үйлдэл, түүнчлэн төлөөлөх загвар болон өгүүлбэртэй бодлогууд.
- Бутархай, холимог тоо болон аравт бутархай ашигласан олон үйлдэлт бодит амьдрал дээрх өгүүлбэртэй бодлогууд.

- Бүхэл тооны загварууд болон үйлдлийн дараалал зэрэг бүхэл тоон үйлдлүүд.
- Бялуу хэлбэртэй, дугуй, дугуй график зэргийг ойлгож, таньж мэдэх.
- Тэнцвэрийн цэг, төвийн хүч зэргийг хэмжих.
- Пропорциональ харилцаа, түүнийг үгээр тайлбарлах, хувь хэмжээ, хувь хэмжээний хүснэгт болон график мөн хамаарна.
- Системийн тоог ангилах, тооцоолох зэргийг оролцуулсан бодит тооны систем.
- Эерэг болон сөрөг зэрэгт дэвшүүлэгч, үйлдлийн дараалал.
- Рациональ тоо, пропорциональ учир шалтгаан ба ижил төстэй байдал зэргийг багтаасан бодит олон бодлогуудыг бодох.
- Өөрчлөлтийн хувь хэмжээний налуу.
- Пропорциональ харилцан хамаарал болон шулуун график, бусад бодит өгүүлбэртэй бодлогыг графиктай холбоотой нэмэлт харилцан хамаарлууд.
- Хэрэглэгчийн хэрэглээтэй холбоотой бодит бодлогууд.
- Дөрвөн талт.
- Өнцгийн хамааралд үндэслэн мэдэгдэхгүй байгаа өнцгийг хэмжиж олох.
- Төрөл бүрийн дүрсний талбай, эзлэхүүнийг олох бодит бодлогууд, түүнчлэн өөрчлөгдөж буй шинж чанартай холбоотой тодорхойлолт, дүн шинжилгээ.
- Тусах, ойх, тэлэх зэрэг өөрчлөлтүүдийг хэрэглэж сурах.
- Хэд хэдэн талын харагдах байдлаас гурван хэмжээст загварыг бий болгох.
- Пифагорын онолыг хэрэглэж, баталгаажуулах.
- Нийлмэл дүрсний тайлбай, периметрийг олох.
- Харилцан хамааралтай болон хамааралгүй үйл явдлын магадлалыг харьцуулан, магадлалыг тооцоолох.
- Төлөөлүүлэх, ажиглалт хийх, таамаг дэвшүүлэх, хайрцаг плот, тархалт плот болон гистограм зэрэг төрөл бүрийн график ашиглан мэдээллийн өгөгдөлд дүн шинжилгээ хийх.
- Алгебрын илэрхийллийг хялбарчлах, бодох.
- Домэйн, хязгаар, хамааралтай болон хамааралгүй хувьсагчид.
- Налууг тодорхойлж, тайлбарлах, өгөгдөл, график эсхүл тэгшитгэл, өгөгдсөн функцийг огтлолцол олох, үгэн тайлбар хийх, хүснэгт, тэгшитгэл болон график.
- Олон үйлдэлт илэрхийлэл бодох, нэг талдаа эсхүл хоёр талдаа хувьсагчтай бодлого бодох, бодит амьдралын жишээнд түүнийг хэрэглэхэд анхаарна.

## БАЙГАЛИЙН УХААН

### 6-р ангийн байгалийн ухаан (14105)

6-р ангид сурагчид нарны аймаг дахь дэлхийн байрлалаас эхлээд дэлхий дээрх ус, эрчим хүч, агаар болон экосистемийн харилцан үйлчлэл зэрэг манай дэлхийн шинж чанаруудыг танин мэдэх болно. Түүнчлэн шинжлэх ухааны мөн чанарын талаарх сурагчийн ойлголтыг нэмэгдүүлэхэд 6-р ангийн стандартаар үргэлжлүүлэн анхаарах болно. Шинжлэх ухаанч хандлага гэдэг нь ажиглалт, туршилт, загвар, нотолгоо ба системчилсэн ажиллагааг ашиглан байгалийн үзэгдлийг тайлбарлах явдал юм. Шинжлэх ухааны мөн чанар гэдэгт шинжлэх ухааны тайлбар нь логик сэтгэлгээнд суурилсан; нотолгооноос хамааралтай; ажиглалт, таамаглал болон туршилтын нотолгоотой нийцэх; учир шалтгаантай шүүмжлэлд нээлттэй; шинжлэх ухааны шинэ нотолгоо гарахад сайжрах болон өөрчлөгдөх боломжтой байдаг гэсэн ойлголтууд багтана. Байгалийн юмс үзэгдэлд тайлбар өгч, аливаа үйл ажиллагаанаас гарч болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглах боломжтой хэдий ч *бүх асуултад хариулах боломжгүй гэдгээр шинжлэх ухааны мөн чанар илэрнэ*. Сурагчид шинжлэх ухааны болон инженерчлэлийн ойлголтыг дараах арга замаар үзүүлэх болно: асуулт асуух, асуудал тодорхойлох, төлөвлөх, судалгаа явуулах (олон улсын хэмжих нэгж - СИ ашиглан), тайлбарлах, дүн шинжилгээ хийх, өгөгдлийг үнэлэх, дүгнэлт болон тайлбар боловсруулах ба шүүмжлэх, загвар бүтээх болон ашиглах, мэдээлэл олж авах, үнэлж дүгнэх, бусдад илэрхийлэх.

Сурагчид дараах зүйлсийг судалж ойлгох болно:

- нарны аймаг өөрийн бүтэц зохион байгуулалттай бөгөөд нарны аймаг дахь төрөл бүрийн биет харилцан үйлчилдэг,
- нар, дэлхий болон сар хоорондоо харилцдаг,
- эрчим хүчний үндсэн эх үүсвэрүүд байдаг бөгөөд эрчим хүчийг хувиргаж болдог,
- бүх биет атомоос бүтдэг,
- ус өвөрмөц физик шинж чанартай бөгөөд байгалийн болон хүний бүтээсэн орчинд гүйцэтгэх үүрэгтэй.
- агаар шинж чанартай ба дэлхийн давхарга өөрийн бүтэц зохион байгуулалттай бөгөөд динамик шинж чанартай,
- усны хагалбарт газар болон ус гол үүрэг гүйцэтгэнэ, мөн
- хүмүүс орчиндоо нөлөө үзүүлдэг ба хувь хүн бүр эрчим хүч, орчны чиглэлээрх төрийн бодлогод нөлөөлж чадна.

## НИЙГЭМ СУДЛАЛ

### Өнөөг хүртэлх АНУ-ын ерөнхийлөгчид (12354)

Сурагчид Америкийн Нэгдсэн Улсын түүхийг тодорхой сэдвийн хүрээнд хугацаа, орон зайг дамнан

судлах болно. Сурагчид өнгөрснийг ойлгож авахын тулд анхдагч болон хоёрдогч хүүрнэлийг нягтлах түүхийг тунгаан бодох ур чадварыг ашиглана. Тус хичээлийн агуулга нь он цагийн турш дахь Америкийн Нэгдсэн Улсын газар зүйд төвлөрөхийн зэрэгцээ эрэл хайгуул, тэлэлт, хувьсгал ба шинэчлэл, эдийн засгийн харилцаа болон үзэл суртлын зөрчилдөөн болон ахиц дэвшил зэрэг сэдэвчилсэн хэлбэрээр явагдана. Эдгээр сэдвийн хүрээнд өрнөсөн харилцаагаар дамжуулан гол үйл явдал болон хүмүүсийн талаар судална. Энэ нь сурагчдад он цагийн дарааллын талаарх ойлголтын зэрэгцээ ирээдүйн үйл явдалд өнөөгийн шийдвэр хэрхэн нөлөөлдөг тухай ойлголтыг өгнө.

Дараах үндсэн сэдвүүдийг сурагчид ойлгож авах болно:

Сурагчид дараах ур чадварт суралцана

- Түүхэн болон газарзүйн дүн шинжилгээ хийх ур чадвараа хөгжүүлэх.
- Газрын зураг, бөмбөрцөг, фото зураг, зураг, комикс зураг болон хүснэгт ашиглах.
- Эртний соёлууд Хойд Америкт хэрхэн хөгжсөн талаар судлах.
- Европчууд хэрхэн Хойд Америк болон Баруун Африкийг судалсан тухай тайлбарлах.
- Колонийн үеийн Америкт холбогдох хүчин зүйлсийг тодорхойлох.
- Америкийн хувьсгалын учир шалтгаан, үр дүнг шинжлэх.
- 1801-1861 онуудад баруун зүгт хийсэн Америкийн өргөтгөл болон шинэчлэлийг судлах.
- Иргэний дайны учир шалтгаан, гол үйл явдлууд, үр нөлөөг ойлгох.
- Иргэний дайны дараа сэргээн босголтын үр дүнд амьдрал хэрхэн өөрчлөгдсөнийг тайлбарлах.
- Арван есдүгээр зууны сүүлээс Дэлхийн II дайныг дуустал Америкийн Нэгдсэн Улсын гүйцэтгэх үүрэг хэрхэн өөрчлөгдөж буйг тайлбарлах.
- Хорин нэгдүгээр зууны нийгмийн, эдийн засгийн болон технологийн өөрчлөлтийг судлах.
- Дэлхийн II дайнд Америк оролцох болсон гол учир шалтгаан, үр нөлөөг тодорхойлох.
- Хорьдугаар зууны сүүлийн хагаст дотоод гарсан гол асуудлуудыг судлах, тухайлбал иргэний эрхийн хөдөлгөөн.

## **6-р АНГИЙН ТАНИН МЭДЭХҮЙН ХӨТӨЛБӨР Бүтэн жил (19000)**

Дунд сургуулийн түвшинд заадаг төрөл бүрийн сонгон суралцах хичээлээс туршиж үзэх боломжийг

6-р ангийн сурагчдад олгохын тулд “Танин мэдэхүйн хүрдийг” бүтээсэн. “Танин мэдэхүйн хүрд” дэх сурагчид дүрслэх урлаг, дадлагын урлаг болон/эсхүл хэлний чиглэлийн хичээлүүдийг тойрч судлах болно. Сурагчдын бүлгүүд тэдгээр төрөл бүрийн ангиудаар зочилж үздэг. Ямар хичээл багтах эсэх нь тухай сургуулийн хуваариас хамаарна. Хичээлийн дараах АСТ II хөтөлбөрийн хүрээнд багтсан сонгон суралцах хичээлүүдэд сурагчид мөн хамрагдах боломжтой. (6-р хуудсыг харна уу.)

Хөгжмийн зэмсэг сонгон суралцаж буй 6-р ангийн сурагчид болон Зааварчилгаатай сургалтад хамрагдах шаардлагатай сурагчид эсхүл өөр ур чадвар хөгжүүлэх хичээл авах сурагчид “Танин мэдэхүйн хүрдний” оронд тэдгээр хичээлүүддээ өдөр бүр оролцоно.

## **УРЛАГИЙН БОЛОВСРОЛ**

Дүрслэх урлаг, хөгжим, театрын урлагийн хичээлүүд нь туршиж үзэх замаар урлаг, хийсвэр сэтгэлгээнд суралцахад чиглэдэг. Урлагийн хичээлээр сурагчид хандлага, сахилга батаа дээшлүүлж, дүрслэх урлаг, хөгжим, жүжгийн бүтээлд холбогдох ур чадвараа хөгжүүлж, сайжруулдаг.

### **“Хоор дуу 6”**

Сурагчид дараахад суралцана:

- Сайн аялгуу гаргахын тулд биеийн зөв байрлал, амьсгалын зөв хяналт, ам зөв барихад суралцах.
- Зөв өнгө, хэмнэл, хугацаа, түлхүүр, хэмнэл болон илэрхийлэх тэмдэглэгээ зэргээр хөгжим унших үндсэн ойлголттой болох ба холбогдох хөгжмийн тоглолтыг зөв ойлгох.
- Диатоник өнгөний систем ашиглан зөв өнгө гаргах, чуулганд өөрийн хэсгийг зөв барих чадвар хөгжүүлэх.
- 1-ээс 2 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгууг ая бүтээх.
- Удирдаачийн зааврыг ойлгож, биелүүлэх.
- Зохих тоглолт, үзүүлбэрийг хийх замаар сурснаа харуулах.

### **Жүжгийн урлаг судлал**

Сурагчид дараахад суралцана:

- Үр дүнтэй харилцаж сурах. албан болон албан бус харилцааны арга техникүүд.
- Зохиолыг нь бичсэн үзэгдлийг боловсруулж, шүүмж өгөх.
- Драм/жүжгийн сэдэв олох, судлах.
- Зохиолын баатар бий болгоход зохиол ашиглах, санаа эрэлхийлэх, үйл явдлын гинжин хэлхээ үүсгэх.
- Үзэгчдэд нөлөө үзүүлэх жүжгийн арга барилуудыг ойлгож авах, хийж үйлдэх.

- Дүрд тоглох замаар өөрийгөө болон бусдыг ойлгох чадвараа сайжруулах.

### **Дүрслэх урлаг судлал**

Сурагчид дараахад суралцана:

- Зургийн элементүүд болон дизайны зарчмуудыг хоёр болон гурван хэмжээст урлагийн бүтээлд ашиглах.
- Урлагийн бүтээлдээ төрөл бүрийн арга техник, материал ашиглах.
- Өөрийн санаа бодлыг урлагаар илэрхийлэхийн зэрэгцээ урлагийн сэтгэлгээгээр асуудал шийдэх.
- Будах, зураг зурах, холимог арга хэрэгсэл болон төрөл бүрийн арга техник ашигласан хөшөө баримал хийх зэргийг туршиж үзэх.
- Өөрийн зураг болон урлагийн бүтээлдээ шугаман дүрслэл ашиглах.

### **БИЗНЕС БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ**

#### **Бизнес, мэдээллийн технологи судлал**

Сурагчид компьютерийн гар хэрэглэх, код бичих, бичил компьютерын аппликейшнүүд, мэргэжил судлал зэргийг үзнэ. Сурагчид зөв шивэх арга техникт суралцана. Үүнд товшиж шивэх арга, хурд, оновчтой байдал, зохион байгуулалтын ур чадвар, найруулга, хэл зүй болон төхөөрөмжийг зөв зохистой ашиглах болон арчлах багтана. *Хичээлийн агуулгад Виржиниягийн Боловсролын газрын Технологийн стандартыг оруулж өгсөн.*

Сурагчид дараахад суралцана:

- Дижитал технологийн бүрэлдэхүүн хэсэг болон эдгээрийг асуудал шийдэхэд бизнесийн болон хувийн хэрэглээний зориулалтаар ашиглах талаар суралцана.
- “Товших-техник” аргыг ашиглан шивэх ур чадвараа харуулах.
- Баримт бичиг үйлдэж, төрөл бүрийн төсөл боловсруулах, үүнд хичээлийн болон хувийн ур чадвараа бэхжүүлэх STEM мөн хамаарна.
- Хэрэглүүр зохион бүтээхийн тулд код бичих (компьютер програмчлал) зарчмыг сурах.

### **АНГЛИ ХЭЛ**

#### **Сэтгүүл зүй судлал**

Энэхүү хичээлээр сурагчид сонин эсхүл аудио/видео мэдээний нэвтрүүлэг хийнэ. Өөрсдийн бүтээлээр дамжуулан сурагчид сонин гаргах, нэвтрүүлэг хийх зорилгоор бичиж, найруулах чадвар эзэмшинэ.

Сурагчид дараахад суралцана:

- Сэтгүүл зүйн хэв маягуудыг сурч, ашиглах.
- Хэвлэмэл ба/эсхүл телевизийн нэвтрүүлгийг агуулга, техникийн чанараар нь шинжлэж, дүгнэх.
- Сурталчилгаа, олон нийтийн зар, мэдээ, олон нийтийн үйлчилгээний зар, зар сурталчилгаа

зэрэг бичвэрийг нийтлэл, онцлох нийтлэл, биеийн тамир ба/эсвэл нэвтрүүлэгт зориулж бичих.

- Хянах, засварлах, зураг, хуулбар, онцлох өгүүлбэр зэргийг байрлуулах, үсэг өрөх, эцсийн бүтээгдэхүүн гаргах зэрэг сэтгүүл зүйн холбогдолтой төрөл бүрийн ажил хийж үзэх.

### **ГЭР БҮЛ БОЛОН ХЭРЭГЛЭГЧИЙН ШИНЖЛЭХ УХААН**

#### **Гэр бүл болон хэрэглэгчийн шинжлэх ухаан судлал**

Гэр бүл болон хэрэглэгчийн шинжлэх ухааны судлалаар сурагчдыг 21-р зууны шаардлагад бэлтгэнэ. Энэ хичээл нь хувь хүн, гэр бүл, ажил мэргэжил, нийтийн дүрэм журам болон хариуцлага зэргийг ойлгож сурахад чиглэнэ.

Сурагчид дараах зүйлд анхаарал хандуулна:

- Хувь хүний өсөлт
- Зорилго тодорхойлох
- Гэр бүлийг бэхжүүлэх
- Хувийн аюулгүй байдал болон эрүүл мэндийн талаарх ойлголт
- Хадгалах болон зарцуулах дадал
- Хувцас арчилгаа
- Хоол бэлтгэх
- Бусадтай эерэг болон халамжтай харилцаа үүсгэх

Заах арга зүй нь тохиромжтой үед шинжлэх ухаан, технологи, инженерчлэл болон математик (STEM)-ийн онолууд ашиглана.

### **ДЭЛХИЙН ХЭЛ**

Дэлхийн хэлний хичээлүүдийг хэл болон соёлын танилцуулга болгон 6-р ангид ордог. 7-р ангид аливаа хэлний I түвшний хичээлд эдгээр танин мэдэхүйн хичээлүүдэд суусан байх шаардлага тавихгүй. Гэхдээ, эдгээрт суусан байхыг зөвлөдөг.

### **Франц болон/эсхүл Испани хэл судлал**

Сурагчид тухайн хэлний талаар ойлголт авч, дараах үндсэн харилцааны ур чадварыг эзэмшинэ: ойлгох, асуух, өөрийн тухай асуултад хариулах, цээжилсэн үг хэллэгийг ашиглан бусадтай харилцах, мэндчилгээ, өнгө, тоо болон хоол зэрэгтэй холбоотой үг хэллэгийг ойлгож, ашиглах.

### **Латин хэл судлал**

Сурагчид Латин хэлтэй болон Ромчуудын амьдралтай танилцана. Хэлний талаарх үндсэн онолуудыг танилцуулж, сурагчид Латин хэлний үгс сурч эхэлнэ. Латин хэлнээс үүссэн үгэнд онцгой анхаарал хандуулна.

## ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ

### Технологи судлал

Сурагчид эхлээд бүх технологийн үндсэн элементүүдийг, тухайлбал, процесс, эрчим хүч, мэдээлэл болон хүмүүсийг судална. Тэд дөрөв хүртэл технологийн системийг судална, тухайлбал, биотехнологи, эрчим хүч, барилга, тээвэр, харилцаа холбоо болон үйлдвэрлэл. Эцэс нь тэд технологийн нийгэм, байгаль орчин болон соёлд үзүүлэх нөлөө, үр дагавар ба шийдвэрийн тухай авч үзнэ.

Сурагчид дараахад суралцана:

- Асуудал шийдвэрлэх үйл явцыг тайлбарлаж, ашиглаж сурах.
- Төсөл боловсруулах болон хэмжих арга хэрэгслийг сонгож, ашиглах.
- Технологийн боловсролын лабораторид байгаа багаж, машин, тоног төхөөрөмжийг таньж тогтоож, ашиглах.
- Лаборатори дахь гар болон цахилгаан багаж ашиглах явцад аюулгүй ажиллагааны зөв дадлыг хэрэгжүүлэх.
- Лаборатори дахь багаж, машин тус бүрийн хэрэглээг ойлгох.
- Хялбар, энгийн заавар төлөвлөгөөг авч үзэж, өгсөн мэдээллийг ойлгож, ажилбарыг хийж дуусгах.
- Багаж хэрэгсэл, материал, математик, шинжлэх ухааныг ашиглаж асуудал шийдвэрлэх.
- Үзүүлэнгийн зорилгоор эсхүл тээвэр, үйлдвэрлэл, харилцаа холбоотой хамааралтай өрсөлдөөнт арга хэмжээнд зориулан модуль эсхүл төсөл бэлтгэх.

## 6-р АНГИ УЛИРАЛ ЭСХҮЛ ЖИЛИЙН ТУРШ ҮНДСЭН БУС АНГИУД

### УРЛАГИЙН БОЛОВСРОЛ

#### Хөгжмийн зэмсэг

Анги тус бүрийн зорилтыг доор зааж өгсөн бөгөөд эдгээр зорилтоос гадуур өөр бусад зорилтууд байж болно. Сургууль тус бүрд сурагчийн чуулга өөрийн гэсэн онцлог нэртэй байж болно.

#### Анхан шатны дуу хөгжим, Төгөлдөр хуур дарах Улирал (19252)

Улирлаар судлах уг хичээлээр сурагчдад төгөлдөр хуурын үндсэн ур чадваруудыг заана. Сурагчид хөгжим тоглох анхан шатны түвшний SOL-ыг хангахын зэрэгцээ цөөн хэдэн өөр стандартуудыг мөн хангана. Сурагчид төгөлдөр хуур эсхүл даралтат хөгжим худалдаж авах шаардлагагүй. Сургуулиас цахилгаан даралтат хөгжим өгөх бөгөөд энэ нь сургуульдаа үлдэнэ.

Сурагчид дараах ур чадварт суралцана

- Төгөлдөр хуурын үндсэн ур чадварт суралцах.

- Хялбар ая, аялгуу уншиж, тоглож сурах.
- Хөгжмийн нот, тэмдэглэгээ уншиж, тоглож сурах.
- Хэд хэдэн төрлийн ритмийг ялгаж, тоглож сурах.
- Гишгүүр ашиглах үндсэн техникт суралцах.

*Анхан шатны хамтлаг*, Бүтэн жил

Үлээвэр цохиур хөгжим (19233), Woodwinds (19234)

Сурагчид дараахад суралцана:

- Хөгжмийн зэмсгийг зөв зохистой арчилж, зөв барьж сурах.
- Зөв тоглох техник үзүүлж, зөв аялгуу гаргах.
- Зөв өнгө, хэмнэл, хугацаа, түлхүүр, хэмнэл болон илэрхийлэх тэмдэглэгээ зэргээр хөгжим унших үндсэн ойлголттой болох ба холбогдох хөгжмийн тоглолтыг зөв ойлгох.
- Нэг октав дээр тоглох ур чадвар эзэмших буюу анхан шатны онолын эхлэл (цохиур хөгжим) тавьж, эдгээр ур чадварыг чуулгын нэгэн гишүүний хувьд ашиглана.
- Хөглөгч ашиглан хөгжмийн зэмсэг хөглөж сурах.
- 1-ээс 2 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Чуулгын хөгжмийн тайван хэмнэлээр метроном ашиглан болон удирдаачийн удирдлага доор тоглоно.
- Зохих тоглолт, үзүүлбэрийг хийх замаар сурснаа харуулах.

*Дунд шатны хамтлаг*, Хичээлийн бүтэн жилд (19201) сурагчид дараахад суралцана:

- Дунд шатны хамтлагийн шалгуурыг хангасан чадвартай бол элсэн орно.
- Хөгжмийн тэмдэглэгээ, нийлмэл метр, хуваагдал, түлхүүрийн тэмдэглэгээ болон хэд хэдэн нэмэлтэй зэрэг нотыг ойлгож, хариу үйлдэл хийх.
- Нэг хагас октав дээр тоглох ур чадвар эзэмших буюу анхан шатны онолын эхлэл (цохиур хөгжим) тавьж, эдгээр ур чадварыг чуулгын нэгэн гишүүний хувьд ашиглана.
- Сонсголоороо хөгжмийн зэмсэг хөглөж сурна.
- 2-оос 4 хэмжигдэхүүн урттай хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Хурд, дуудлага, хэв маягийн өөрчлөлт оруулан удирдаж буй удирдаачид хариу үйлдэл хийх.
- I ангийн уран зохиол, түүний дотор зохимжтой бол ганцаарчилсан тоглолт хийх зэргээр сурсан мэдсэнээ тоглолт, үзүүлбэрээр харуулах.
- Концертын зохиолоос хоёр анги доогуур түвшинд хараагаар унших.

*Анхан шатны оркестр*, Хичээлийн бүтэн жилд (19237) сурагчид дараахад суралцана:

- Хөгжмийн зэмсэг болон нумыг зөв зохистой арчилж, зөв барьж сурна.

- Зөв техниктэй тоглож буйг харуулах, зөв аяыг гаргах, үүнд пиззикато дуу гаргах, нумыг хөрөөдөх үндсэн техник зэрэг нь орно.
- Зөв өнгө, хэмнэл, хугацаа, түлхүүр, хэмнэл болон илэрхийлэх тэмдэглэгээ зэргээр хөгжим унших үндсэн ойлголттой болох ба холбогдох хөгжмийн тоглолтыг зөв ойлгох.
- Нээлттэй чавхдас дээр (нэгдүгээр байрлалд) нэг октав болон давхар зогсолт тоглох ур чадвар эзэмших, эдгээр чадварыг чуулгын гишүүний хувьд ашиглах.
- Хөглөгч ашиглан хөгжмийн зэмсэг хөглөж сурах.
- 1-ээс 2 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Метроном ашиглан тогтсон хэмнэлээс тоглох, мөн удирдаачийн хөдөлгөөнөөр тоглох.
- Зохих тоглолт, үзүүлбэрийг хийх замаар сурснаа харуулах.

**Дунд шатны оркестр,** Хичээлийн бүтэн жилд (19242) сурагчид дараахад суралцана:

- Дунд шатны оркестрын шалгуурыг хангасан чадвартай бол элсэн орно.
- Хөгжмийн тэмдэглэгээ, үүний дотор төрөл бүрээр хийлдэж, хуурдах арга техник ашиглах, нийлмэл метр, хуваагдал болон хоёр диеттэй түлхүүрийн тэмдэглэгээг хүртэл ойлгож, тоглох.
- Нэг хагас октав дээр өргөтгөл ашиглан, нумын жин, хурд, хүрэлцээг тохируулан тоглох чадвартай болох; эдгээр чадварыг чуулгын нэг гишүүний хувьд ашиглаж харуулах.
- Сонсголоороо хөгжмийн зэмсэг хөглөж сурна.
- 2-оос 4 хэмжигдэхүүн урттай хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Хурд, дуудлага, хэв маягийн өөрчлөлт оруулан удирдаж буй удирдаачийн удирдлагыг дагах.
- Тоглолт болон үзүүлбэрүүд хийх замаар сурснаа харуулах, холбогдох тохиолдолд гоцлол тоглолт хийх.
- Концертын зохиолоос хоёр анги доогуур түвшинд хараагаар унших.

### **Жүжгийн урлаг**

**Бүтэн жил (11391)**

**Улирал (11392)**

Сурагчид дараахад суралцана:

- Сонгон шалгаруулалт, дасгал сургуулилалт, техникийн продакшн зэрэг жүжгийн тогтсон процесст оролцоно.
- Тоглолтод зориулж, сэтгэл хөдөлгөсөн зохиолыг шинжилж, үнэлнэ.
- Зохиолын баатрыг биеийн, сэтгэл зүйн болон нийгмийн талаас нь бүтээнэ.
- Захирлууд болон жүжигчдийн үүрэг, хариуцлагыг ойлгож, тэдгээрт тоглоно.

- Жүжгийн бүтээлд менежментийн гүйцэтгэх үүргийг ойлгож мэднэ.
- Бусадтай хамтран ажиллахдаа урлагийн бүтээлч сахилга батыг хөгжүүлж, ашиглана.

### **Дүрслэх урлаг I**

**Бүтэн жил (19040)**

**Улирал (19041)**

Сурагчид дараахад суралцана:

- Урлагийн бүтээл бүтээхийн тулд дизайны зарчмууд болон зургийн элементүүдийг ашиглах.
- Төрөл бүрийн арга техник болон үйл явцыг ашиглан гурван хэмжээст бүтээл бүтээх.
- Төрөл бүрийн урлагийн бүтээлд өөрийн хувийн тайлбар хийх, шүүмж өгөх.
- Зургийн нэр томьёо ашиглан урлагийн эцсийн бүтээлийг шинжилж, шүүмжлэх.
- Урлагийн бүтээл хийхдээ ёс зүйтэй шийдвэр гаргах, түүнийг тайлбарлах.

### **Дуу хөгжим**

Анги тус бүрийн зорилтыг доор зааж өгсөн бөгөөд эдгээр зорилтоос гадуур өөр бусад зорилтууд байж болно. Сургууль тус бүрд сурагчийн чуулга өөрийн гэсэн онцлог нэртэй байж болно.

**Анхан шатны хоор,** Бүтэн жил (19261)

Тухайн улиралд (19264) сурагчид дараахад суралцана:

- Сайн аялгуу гаргахын тулд биеийн зөв байрлал, амьсгалын зөв хяналт, ам зөв барихад суралцах.
- Зөв өнгө, хэмнэл, хугацаа, түлхүүр, хэмнэл болон илэрхийлэх тэмдэглэгээ зэргээр хөгжим унших үндсэн ойлголттой болох ба холбогдох хөгжмийн тоглолтыг зөв ойлгох.
- Диатоник өнгөний систем ашиглан зөв өнгө гаргах, чуулганд өөрийн хэсгийг зөв барих чадвар хөгжүүлэх.
- 1-ээс 2 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Удирдаачид хариу үйлдэл үзүүлэх.
- Зохих тоглолт, үзүүлбэрийг хийх замаар сурснаа харуулах.

### **МАТЕМАТИК**

**Тооны стратеги**

**Бүтэн жил (13116)**

**Улирал (13121)**

Стратегийн хичээл нь сонгон суралцах хичээл бөгөөд математикийн хичээлд хоцролттой байгаа сурагчдад зориулагдсан. Стратегийн хичээлээр сурагчид суурь мэдлэгээ бэхжүүлж, өгөгдлийг ойлгох аргачлалд суралцаж, үндсэн хичээлийн агуулгыг сайтар ойлгоход суралцана.



## ТУСГАЙ БОЛОВСРОЛ

### Заах арга зүй, Бүтэн жил (10028)

*Урьдчилсан шаардлага: Сурагчийг тусгай боловсролын үйлчилгээнд хамруулах шаардлагатай гэж дүгнэлт гарсан байх шаардлагатай*

Тусгайлсан боловсролын хөтөлбөр (IEP)-ийн дагуу тухайн сурагчид тусгайлан зориулж хичээл орох ба сурагчид олгох ерөнхий боловсролын шаардлагыг хангахад чиглэнэ. Түүнчлэн сонсох, бичих, зохион байгуулах болон ерөнхий суралцах чадварт онцгой анхаарал хандуулна.

### Нийгэмших чадвар, Бүтэн жил (10023)

*Урьдчилсан шаардлага: Сурагчийг тусгай боловсролын үйлчилгээнд хамруулах шаардлагатай гэж дүгнэлт гарсан байх шаардлагатай*

Нийгэмших чадварын хичээлээр дунд сургуулийн сурагч бусадтай зохистой нийгмийн харилцаанд ороход шаардлагатай ур чадварыг олж авч, дадлага хийх боломжтой. Бусадтай харилцах, өөр өнцгөөс харах, өөрийгөө дайчлах, багаар ажиллах, стресс болон бухимдлаа дарах аргачлал, нийгмийн харилцааны “бичигдээгүй хуулиуд” зэргийг суралцах ур чадварт багтаана. Хувийн зохион байгуулалт, өөрийгөө өмгөөлөх, хамгаалах зэрэг ур чадварууд мөн багтана.

## СУРАГЧИЙН ДЭМЖЛЭГ

### Үндсэн хичээлийн нэмэлт

#### Бүтэн жил (11129)

##### Улирал (11128)

Хувийн зохион байгуулалт, тэмдэглэл хөтлөх, шалгалт өгөх болон сурагч илүү их амжилт олоход туслах бусад арга барилуудыг заах ерөнхий сургалтад энэ хичээл нь зориулагдсан.

Сурагчид дараахад суралцана:

- Хичээл давтах цагаа төлөвлөх.
- Сонсох чадвараа сайжруулах арга барилд суралцах.
- Хичээл, сурлагын талаарх одоогийн хандлагадаа дүгнэлт хийж, юу илүү чухал болохыг тодорхойлж, зорилго тавьж, эерэг хандлага бий болгох.
- Уншиж ойлгох, санаж тогтооход суралцах арга барил, дадал чадварыг хэрэглэх.

## ДЭЛХИЙН ХЭЛ

### Анхан шатны Испани хэл (15501)

#### Улирлын хичээл

Сурагчид тухайн хэлний талаар ойлголт авч, дараах үндсэн харилцааны ур чадварыг эзэмшинэ: ойлгох, асуух, өөрийн тухай асуултад хариулах, цээжилсэн үг хэллэгийг ашиглан бусадтай харилцах, мэндчилгээ, өнгө, тоо болон хоол зэрэгтэй холбоотой үг хэллэгийг ойлгож, ашиглах. Хичээлээр сурагчид ахлах ангид

кредит авах хичээлд суухаас өмнө бэлтгэл болгож тухайн хэлний талаар ойлголт авна. Сурагчид ахлах сургуульд сонгосон хэлээ амжилттай сурах боломжийг олгохын тулд холбогдох хэлний талаар суурь ойлголтыг өгөх болно.

### Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл, 6-р анги (15503)

#### Улирлын хичээл

*Урьдчилсан шаардлага: Багшийн тодорхойлсноор Испани хэлээр чөлөөтэй ярьж чаддаг байх.*

Энэ хичээл нь Испани төрөлх хэлтэй эсхүл Испани хэлээр төрөлх хэл шигээ ярьдаг боловч уншиж, бичих чадвар хангалттай эзэмшээгүй сурагчдад зориулагдсан. Сурагчид унших, бичих, ярих харилцааны ур чадвар эзэмшиж, Испани хэл зүйн дүрмийг сурч эхлэх болно. Сурагчид Испани хэл соёлын өнцгөөс харах, илэрхийлэх хэлбэрийн талаар илүү сайн ойлголттой болно.

Сурагчид дараахад суралцана:

- Албан бус харилцан яриа, хэлэлцүүлэгт оролцох.
- Бүлгийн болон ангийн дунд үг хэлж, илтгэл тавих.
- Уншсан зүйлийнхээ гол санаа болон дагалдах утгыг таньж олох.
- Богино хэмжээний дүгнэлт бичих.
- Испани хэл соёлын нөлөөг судлах.

## 7-Р АНГИЙН ҮНДСЭН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

7-р ангийн сурагчид дараах сэдвийг хичээлийн үндсэн цагаар суралцана. Сурагчид хичээлийн сэдэв бүрээр шаардлагатай хэмжээгээр сурсанаа сэргээж, цааш баяжуулна. (Тохируулан зааж сургахтай холбоотой мэдээллийг 6-р хуудаснаас харна уу.)

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

## АНГЛИ ХЭЛ, СОЁЛ

### 7-р ангийн Англи хэл (11110)

Бүх дунд сургуулиудад Англи хэл, соёлын хөтөлбөр нь Виржиниягийн Англи хэл суралцах стандартуудад заасан дөрвөн чиглэлийн хүрээнд голлон анхаарна: харилцаа болон олон хэлбэрийн бичиг үсэг тайлал, унших, бичих болон судлах. Эдгээр чиглэлээр ур чадвартай байх нь сурагчийн ахисан түвшинд тунгаан бодоход нөлөөлж, хичээлдээ болон хичээлээс гадуур амжилтад хүргэхэд хөтөлнө. Сургалтын хөтөлбөр нь

ойлгуулах, чухал асуултуудыг хөндөхөд чиглэсэн үзэл баримтлал, аргачлалд тулгуурлана.

- Уран зохиол болон баримтат зохиолыг харьцуулах хэлбэрээр уншсанаа ойлгох чадварт үргэлжлүүлэн анхаарах болно. Уран зохиолын хувьд сурагчид зохиолчийн бичлэгийн хэв маягт анхааран төрөл бүрийн жанрын элементүүдийг олж тогтооно. Баримтат зохиол дээр илүү их анхаарал хандуулах бөгөөд сурагчид эх сурвалж, байр суурь болон тухайн зохиолын зорилгыг тодорхойлно.
- Сурагчид үгийн гарал үүсэл, үндсийг судалж, далд утгыг олж тогтоох дасгалаа үргэлжүүлнэ.
- Сурагчид таних мэдэх өгүүллэг, уриалан дуудах бичлэг голчилсон хэлбэрээр төрөл бүрийн зохион бичлэгүүд төлөвлөж, төсөл бичиж, засаж найруулж, хянан тохиолдуулна. Сурагчид гол санаа, өнгө ая, болон дуу хоолойг уншигчдад болон зорилгодоо тохируулан өөрчлөх, сайжруулах бичлэгүүд хийнэ.
- Сурагчид бие даан болон багаар олон хэлбэрийн илтгэл үргэлжлүүлэн хийнэ. Төрөл бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн форматад буй мэдээллийг тайлбарлана.
- Сурагчид хамтран зөвшилцөж ажиллаж, хувь нэмэр оруулагч буюу зохион байгуулагчийн хувьд хамтын хариуцлагыг үүрч, хамтарч ажиллахад суралцана.
- Сурагч эш татах, дүгнэлт хийх, судалгааны үр дүнг өөрийн үгээр найруулан бичих зэрэгт судалгааны арга техник ашиглана. Бусдын бүтээлийг хулгайлах талаарх ойлголт, түүний үр дагаврыг онцлон танилцуулна.

## **ЭРҮҮЛ МЭНД БОЛОН БИЕ БЯЛДРЫН БОЛОВСРОЛ**

### **7-р анги Эрүүл мэнд болон бие бялдрын боловсрол (17120)**

7-р ангийн бүх сурагчид эрүүл мэнд болон бие бялдрын боловсролын хөтөлбөрт хамрагдана. Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр нь эрүүл амьдралын хэв маягийг эзэмшихэд сурагчид мэдэх, ойлгох, хийх хэрэгцээ шаардлагыг онцолно. Эрүүл мэндийн боловсролын заах арга зүй нь эрсдэлтэй үйлдлийг орлон эерэг арга замуудыг танилцуулна. Сурагчид үеийнхний дарамт шахалтыг эсэргүүцэж, стрессээ удирдан зохицуулах чадварт суралцана. Судлах сэдвүүдэд сэтгэл зүйн, сэтгэл мэдрэлийн, нийгмийн болон орчны эрүүл мэнд, аюулгүй байдал болон онцгой байдалд бэлэн байх, харилцаа, мансууруулах бодисын хэрэглээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гэр бүлийн амьдралын боловсрол

зэрэг багтана. Биеийн тамирын хичээлийн хөтөлбөрөөр сурагчид сурсан мэдлэг, чадвараа ашиглах шаардлагатай төрөл бүрийн дасгалуудыг сурна. Сурагчид динамик болон урьдчилан тааварлах боломжгүй тоглолтын нөхцөл байдалд хөдөлгөөн хийж үзүүлнэ. Сурагчид зорилгоо тодорхойлох замаар өөрсдийн гүйцэтгэлд шинжилгээ хийж, хувийн бие бялдрын төлөвлөгөө гаргана. Биеийн тамир эрүүл мэнд, ялангуяа таргалалт болон стресст хэр нөлөөтэй болох талаар сурагчид ойлголт авна.

## **МАТЕМАТИК**

### **Математик 7 (13111)**

Математик 7 нь долоодугаар ангийн сурагчдад зориулсан математикийн агуулгыг эрчимжүүлсэн хичээл юм.

7-р ангид алгебр үзэхээс өмнөх бэлтгэл сургалтад үргэлжлүүлэн анхаарна. Энэ нь наймдугаар анги болон ахлах сургуульд сурагчид амжилт гаргах зайлшгүй суурь болно.

Сурагчид дараах ойлголтыг авна:

1. Тоо ба тооны тухай ойлголт
2. Тооцоолох ба тоймлох
3. Хэмжилт
4. Магадлал ба статистик
5. Хэв маяг, хэлбэр, функц ба алгебр

Түүнчлэн стандарт агуулга нь математик суралцахтай холбоотой дараах үйл явцын зорилгыг дэмжихэд чиглэгдсэн: Асуудал шийдвэрлэх, харилцаа, холбоо, төлөөлөл ба учир шалтгаан.

7-р ангийн математикийн хичээлийн Виржиния мужийн стандартыг (SOL) хангах агуулгын зарим тодорхой жишээг дурдвал:

- Эерэг болон сөрөг зэрэгт дэвшүүлэгч, үйлдлийн дараалал.
- Рациональ тоо, пропорциональ учир шалтгаан, ижил төстэй байдал зэргийг багтаасан бодит олон бодлогуудыг бодох.
- Төрөл бүрийн дүрсний гадаргуун талбай болон эзлэхүүнийг тодорхойлох бодит бодлогууд.
- Дөрвөн талт.
- Хувиргалтууд.
- Хистограм болон бусад графикууд.
- Өөрчлөлтийн хувь хэмжээний налуу.
- Пропорциональ харилцан хамаарал болон шулуун графиктай холбоотой нэмэлт харилцан хамаарлууд.
- Үгэн тайлбар, хүснэгт, тэнцэтгэл болон график ашиглан пропорциональ харилцан хамаарлыг холбох.
- Алгебрын илэрхийлэл бодох.
- Бодит асуудалд суурилсан хоёр үйлдэлтэй шугаман тэнцэтгэл болон үл тэнцэтгэл бодох.

## 7-р ангийнханд зориулсан алгебрын бэлтгэл (13109)

7-р ангийн Алгебрын бэлтгэл нь 7 болон 8-р ангийн математикийн хичээлийн Виржиния мужийн стандарт дахь Алгебрын бэлтгэл сэдвүүдийг эрчимжүүлсэн байдлаар судлах хичээл юм. Стандартууд нь сурагчид 8-р ангид болон ахлах сургуулийн математикт Алгебр I эсхүл гүнзгийрүүлсэн Алгебр I хичээлүүдэд амжилттай суралцахад шаардлагатай суурийг эзэмшихэд анхаарал хандуулна.

Сурагчид дараах ойлголтыг авна:

1. Тоо ба тооны тухай ойлголт
2. Тооцоолох ба тоймлох
3. Хэмжилт
4. Магадлал ба статистик
5. Хэв маяг, хэлбэр, функц ба алгебр

Түүнчлэн стандарт агуулга нь математик суралцахтай холбоотой дараах үйл явцын зорилгыг дэмжихэд чиглэгдсэн: Асуудал шийдвэрлэх, харилцаа, холбоо, төлөөлөл ба учир шалтгаан.

Энэхүү хичээлийн агуулга дахь илүү тодорхой жишээнээс дурдвал:

- Системийн тоог ангилах, тооцоолох зэргийг оролцуулсан бодит тооны систем.
- Эерэг болон сөрөг зэрэгт дэвшүүлэгч, үйлдлийн дараалал.
- Рациональ тоо, пропорциональ учир шалтгаан, ижил төстэй байдал зэргийг багтаасан бодит олон бодлогуудыг бодох.
- Өөрчлөлтийн хувь хэмжээний налуу.
- Пропорциональ харилцан хамаарал болон шулуун графиктай холбоотой нэмэлт харилцан хамаарлууд.
- Хэрэглэгчийн хэрэглээтэй холбоотой бодит бодлогууд.
- Дөрвөн талт
- Өнцгийн хамааралд үндэслэн мэдэгдэхгүй байгаа өнцгийг хэмжиж олох.
- Төрөл бүрийн дүрсний талбай, эзлэхүүнийг олох бодит бодлогууд, түүнчлэн өөрчлөгдөж буй шинж чанартай холбоотой тодорхойлолт, дүн шинжилгээ.
- Тусах, ойх, тэлэх зэрэг өөрчлөлтүүдийг хэрэглэж сурах.
- Дээд/доод, хажуугийн болон урд/ард талаас харагдах зургийг ашиглан гурван хэмжээст загвар бүтээх.
- Пифагорын онолыг хэрэглэж, баталгаажуулах.
- Нийлмэл дүрсний тайлбай, периметрийг олох.
- Харилцан хамааралтай болон хамааралгүй үйл явдлын магадлалыг харьцуулан, магадлалыг тооцоолох.

- Төлөөлүүлэх, ажиглалт хийх, таамаг дэвшүүлэх, хайрцаг плот, тархалт плот болон гистограм зэрэг төрөл бүрийн график ашиглан мэдээллийн өгөгдөлд дүн шинжилгээ хийх.
- Алгебрын илэрхийллийг хялбарчлах, бодох.
- Функцэд харилцан хамаарал байгаа эсэхийг тодорхойлох, домэйн, хязгаар, хамаарал бүхий болон хамааралгүй хувьсагчийг тодорхойлох.
- Налууг тодорхойлж, тайлбарлах, өгөгдөл, график эсхүл тэгшитгэл нь өгөгдсөн функцийн огтлолцол олох, үгэн тайлбар хийх, хүснэгт, тэгшитгэл болон график.
- Олон үйлдэлт илэрхийлэл бодох, нэг талдаа эсхүл хоёр талдаа хувьсагчтай бодлого бодох, бодит амьдралын жишээнд түүнийг хэрэглэхэд анхаарна.

## Алгебр I, гүнзгийрүүлсэн (13140)

Гүнзгийрүүлсэн Алгебр I нь үндсэн хичээл бөгөөд 6, 7 болон 8-р ангийн математикийн хичээлийн Виржиния мужийн сургалтын стандартуудыг хангасан бөгөөд цаашид нэмэлтээр ахисан түвшний сэдэв судлах хүсэлтэй ДС-ийн бүх сурагчдад зориулсан эрчимжүүлсэн математикийн хичээл юм. Гүнзгийрүүлсэн Алгебр I хичээлээр сурагчид дараах ойлголтыг авах болно:

1. Илэрхийлэл болон үйлдлүүд
2. Тэнцэтгэл болон үл тэнцэтгэл
3. Функцүүд
4. Статистик

Түүнчлэн стандарт агуулга нь математик суралцахтай холбоотой дараах үйл явцын зорилгыг дэмжихэд чиглэгдсэн: Асуудал шийдвэрлэх, харилцаа, холбоо, төлөөлөл ба учир шалтгаан.

Алгебр I хичээлийг судлах Виржиния мужийн стандартыг (SOL) хангах агуулгын зарим тодорхой жишээг дурдвал:

- Үгээр илэрхийлсэн тоон нөхцөл байдлыг алгебр хэлбэрээр төлөөлүүлж, илэрхийллийг бодох.
- Зэрэгт дэвшүүлэх, үйлдэл болон үржүүлэх хуулиудыг ашиглан полином үйлдлүүдийг гүйцэтгэх.
- Квадрат болон куб зэрэгт дэвшүүлснийг хялбарчлах.
- Шугаман, квадрат болон илэрхий зэрэг нэг хувьсагчтай олон үйлдэлт тэнцэтгэлийг алгебрын аргаар бодох, бодит асуудал шийдэхэд анхаарал хандуулах.
- Хоёр хувьсагчтай хоёр шугаман тэнцэтгэлийн системийг графикийн аргаар болон алгебрын аргаар бодох.
- Хоёр хувьсагчтай үл тэнцэтгэлийн хариуг графикаар илэрхийлэх, үүнд үл тэнцэтгэлийн системийг хамааруулна.

- Налууг олох, тэнцэтгэлийг бичих, хоёр хувьсагчид шугаман тэнцэтгэлийн графикийг зурах.
- Шугаман болон квадрат функцуудыг графикийн болон алгебрын аргаар судлан, шинжлэх.
- Бодит нөхцөл байдал дахь өгөгдлийн иж бүрдэл өгөгдсөн тохиолдолд шууд эсхүл урвуу хувьсал байгаа эсэхийг тодорхойлж, тэдгээрийг алгебрын болон графикийн аргаар илэрхийлэх.
- Бодит хариу өгөгдсөн тохиолдолд өгөгдлийг цуглуулж, шинжлэх, тохирох муруйн тэнцэтгэлийг тодорхойлж, шугаман болон квадрат функцийг таамаг дэвшүүлэх.

Гүнзгийрүүлсэн Алгебр I хичээлээр сурагчид дээрх сэдвүүдийг илүү гүнзгийрүүлэн суралцах болно. Түүнчлэн, сурагчид дараах нэмэлт сэдвүүдэд суралцах болно:

- Үнэмлэхүй тоо бүхий тэнцэтгэл болон үл тэнцэтгэл
- Язгуур илэрхийлэл болон тэнцэтгэл
- Рациональ илэрхийлэл болон тэнцэтгэл
- Графикийн болон алгебрын аргаар квадрат функцтэй илүү их ажиллах
- Нэмэлт функцуудыг судлах
- Илтгэгч зэргээр өсөлт ба буурал
- Пифагорын онол
- Зай ба голч цэг
- Сэлгэлт, комбинаци, нийлмэл үйл явдлууд, асуулга болон түүвэр зэрэг магадлал.

Стандарт агуулга нь математик суралцахтай холбоотой дараах үйл явцын зорилгыг дэмжихэд чиглэгдсэн: Асуудал шийдвэрлэх, харилцаа, холбоо, төлөөлөл ба учир шалтгаан.

*Тайлбар: Энэ хичээлээр ахлах сургуулийн кредит олгогдох бөгөөд арлах сургууль төгсөхөд тавигдах шаардлагыг хангаж, ахлах сургуулийн голч дүнд нөлөөлж, ахлах сургуулийн дүнгийн жагсаалтад бичигдэнэ. Ахлах сургуулийн кредитийн талаарх 56-р хуудас, APS PIP I-11.6.30 зэргийг харж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.*

## **БАЙГАЛИЙН УХААН**

### **7-р ангийн Амьдралын шинжлэх ухаан (14115)**

7-р ангийн Амьдралын шинжлэх ухаан хичээлээр сурагчид амьд ертөнцийн өөрчлөлт, цикл, хэв шинж болон харилцааны талаар судлах болно. Түүнчлэн, Амьдралын шинжлэх ухааны стандарт нь шинжлэх ухааны мөн чанарын талаарх сурагчийн ойлголтыг нэмэгдүүлэхэд үргэлжлүүлэн анхаарах болно. Шинжлэх ухаанч хандлага гэдэг нь ажиглалт, туршилт, загвар, нотолгоо ба системчилсэн ажиллагааг ашиглан байгалийн үзэгдлийг тайлбарлах явдал юм. Шинжлэх ухааны мөн чанар гэдэгт шинжлэх ухааны тайлбарууд нь логик сэтгэлгээнд суурилсан, нотолгооноос хамааралтай, ажиглалт, таамаглал болон туршилтын нотолгоотой нийцэх, учир шалтгаантай шүүмжлэлд нээлттэй, шинжлэх

ухааны шинэ нотолгоо гарахад сайжрах болон өөрчлөгдөх боломжтой байдаг гэсэн ойлголтууд багтана. Шинжлэх ухааны мөн чанар нь байгалийн юмс үзэгдлийн тайлбарыг өгөх бөгөөд аливаа үйл ажиллагаанаас гарч болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглах боломжтой хэдий ч *бүх асуултад хариулах бол боломжгүй юм*. Сурагчид шинжлэх ухааны болон инженерчлэлийн ойлголтыг дараах арга замаар үзүүлэх болно: асуулт асуух, асуудал тодорхойлох, төлөвлөх, судалгаа явуулах (олон улсын хэмжих нэгж СИ ашиглан), тайлбарлах, дүн шинжилгээ хийх, өгөгдлийг үнэлэх, дүгнэлт болон тайлбар боловсруулах ба шүүмжлэх, загвар бүтээх болон ашиглах, мэдээлэл олж авах, үнэлж дүгнэх, бусдад илэрхийлэх. Сурагчид ижил сонирхлын хүрээнд төсөл боловсруулах баг дотор ажиллах замаар бие даасан төсөлдөө бэлдэж болно.

Сурагчид дараах зүйлсийг судалж ойлгох болно:

- эсийн онолд заасны дагуу бүх амьд юмс амьдралын үйл явцад дэмжлэг үзүүлдэг нэг буюу түүнээс дээш эсээс бүтдэг,
- амьд юмст тодорхой үе шат бүхий бүтэц зохион байгуулалт бий,
- амьдралд чухал ач холбогдолтой эрчим хүч шилжилтийн химийн үйл явц байдаг,
- амьд болон амьд бус хүчин зүйлс экосистемд нөлөөлж байдаг,
- биологийн төрөл зүйлүүд хоорондоо харилцан үйлчилдэг бөгөөд харилцан хамааралтай,
- аливаа организм экосистемд дасан зохицох замаар амьд үлддэг,
- экосистем, төрөл зүйл, популяци болон организм нь динамик бөгөөд цаг хугацааны явцад өөрчлөгдөж байдаг,
- экосистемийн динамик болон хүний үйл ажиллагаа хоорондоо харилцаа хамааралтай,
- организмууд гений төлжиж, гений мэдээллээ шинэ хойч үедээ шилжүүлдэг,
- организмын популяци цаг хугацааны явцад өөрчлөгдөж болно.

## **НИЙГЭМ СУДЛАЛ**

### **Нийгмийн ухаан, эдийн засаг (12355)**

Нийгмийн ухаан, эдийн засаг хичээлээр сурагчид үүрэг хариуцлага, эрх, иргэний үүрэг болон үйл ажиллагааг Америкийн Нэгдсэн Улсын улс төрийн болон эдийн засгийн системийн хүрээнд судална. Эрэл хайгуулд суурилсан арга барилаар сурагчид орон нутгийн, мужийн болон улсын Засгийн газруудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг судална. Сурагчид өөрсдийн мэдлэг, ур чадварыг ашиглан Засгийн газар болон эдийн засаг хоорондын харилцааг ойлгож авч дүн шинжилгээ хийнэ. Сурагчид сурч мэдсэн зүйлсээ ашиглан мэдээлэлтэй

бөгөөд хариуцлагатай иргэн байхын утга учрыг ойлгож авах болно.

Сурагчид дараахад суралцана:

- Газрын зураг, бөмбөрцөг, фото зураг, зураг, комикс зураг болон хүснэгт ашиглах.
- Түүхэн, иргэний эрхийн болон газар зүйн шинжилгээ хийх ур чадвараа харуулна.
- Америкийн үндсэн хуульт засгийн газрын суурь ойлголтыг авах.
- Иргэншил, иргэний эрх, үүрэг, хариуцлагыг ойлгох.
- Иргэний амьдралд бодлоготойгоор, үр дүнтэйгээр оролцоход туслах хувь хүний зан чанар, шинжийг илэрхийлэх.  
Орон нутгийн, мужийн болон улсын хэмжээний засгийн газрын улс төрийн үйл явцыг ойлгох.
- Улсын, мужийн болон орон нутгийн түвшинд Америкийн үндсэн хуульт засгийн газрыг ойлгох.
- Виржиния мужийн үндсэн хууль болон Америкийн Нэгдсэн Улсын үндсэн хуулиар байгуулсан шүүх системийг ойлгох.
- Орон нутгийн, мужийн болон улсын түвшинд төрийн бодлогыг хэрхэн боловсруулдаг талаар ойлгох.
- Америкийн Нэгдсэн Улсын эдийн засаг, зах зээл дээр шийдвэр хэрхэн гардаг тухай болон эдийн засаг дахь төрийн оролцоог ойлгох.
- Хувийн санхүү болон карьерын боломжуудыг ойлгох.

*Иргэний эрх, эдийн засгийн онолд суралцсан байдлын стандартын үнэлгээ шалгалтыг 7-р ангийн төгсгөлд авна.*

## **7-Р АНГИЙН СОНГОН СУРАЛЦАХ БОЛОН ҮНДСЭН БУС ХИЧЭЭЛҮҮД**

7-р ангийн сурагчид төрөл бүрийн хичээлээс сонгон суралцах боломжтой. Аль хичээлүүдийг хослуулж, хавсрах боломжтой эсэх нь тухай сургуулийн хуваариас хамаарна. Хичээлийн дараах АСТ II хөтөлбөрийн хүрээнд багтсан сонгон суралцах хичээлүүдэд сурагчид мөн хамрагдах боломжтой. (6-р хуудсыг харна уу)

### **УРЛАГИЙН БОЛОВСРОЛ**

#### **Гитар, бүтэн жил (19246)**

##### **Улирал (19245)**

Сурагчид дараахад суралцана:

- Хөгжмийн зэмсгийг зөв зохистой арчилж, зөв барьж сурах.
- Зөв тоглох техникт суралцаж, зөв ая тоглох.
- Хөглөгч ашиглан хөгжмийн зэмсэг хөглөж сурах.
- Гитарын үндсэн ойлголт авч, хөгжмийн стандарт тэмдэглэгээг уншиж сурах.

- Ноотны анхдагч барилтууд, ая тоглох.
- Баруун гарын үндсэн техник болон аялгуут хэв маягаар тоглох.
- Тоглолт хийх замаар сурснаа харуулах, ингэхдээ цөөхүүл эсхүл гитарын чуулгатай хамтарч тоглох.

Сурагчид сурах бичиг болон акустик (ардын эсхүл сонгодог) гитар худалдаж авах ёстой. Сургуулийн эзэмшлийн цөөн тооны хөгжмөөс түрээслэн хэрэглэх боломжтой.

### **Анхан шатны дуу хөгжим, Төгөлдөр хуур дарах Улирал (19252)**

Улирлаар судлах уг хичээлээр сурагчдад төгөлдөр хуурын үндсэн ур чадваруудыг заана. Сурагчид хөгжим тоглох анхан шатны түвшний SOL-ыг хангахын зэрэгцээ цөөн хэдэн өөр стандартуудыг мөн хангана. Сурагчдаас төгөлдөр хуур эсхүл даралтат хөгжим авахыг шаардахгүй. Сургуулиас цахилгаан даралтат хөгжим өгөх бөгөөд энэ нь сургуульдаа үлдэнэ.

Сурагчид дараах ур чадварт суралцана

- Төгөлдөр хуурын үндсэн ур чадварт суралцах.
- Хялбар ая, аялгуу уншиж, тоглож сурах.
- Хөгжмийн нот, тэмдэглэгээ уншиж, тоглож сурах.
- Хэд хэдэн төрлийн ритмийг ялгаж, тоглож сурах.
- Гишгүүр ашиглах үндсэн техникт суралцах.

### **Хөгжмийн зэмсэг**

Анги тус бүрийн зорилтыг доор зааж өгсөн бөгөөд эдгээр зорилтоос гадуур өөр бусад зорилтууд байж болно. Сургууль тус бүрд сурагчийн чуулга өөрийн гэсэн онцлог нэртэй байж болно.

*Анхан шатны хамтлаг, Бүтэн жил (19232) ангид сурагчид:*

- Хөгжмийн зэмсгийг зөв зохистой арчилж, зөв барьж сурах.
- Зөв тоглох техник үзүүлж, зөв аялгуу гаргах.
- Зөв өнгө, хэмнэл, хугацаа, түлхүүр, хэмнэл болон илэрхийлэх тэмдэглэгээ зэргээр хөгжим унших үндсэн ойлголттой болох ба холбогдох хөгжмийн тоглолтыг зөв ойлгох.
- Нэг октав дээр тоглох ур чадвар эзэмших буюу анхан шатны онолын эхлэл (цохиур хөгжим) тавьж, эдгээр ур чадварыг чуулгын нэгэн гишүүний хувьд ашиглана.
- Хөглөгч ашиглан хөгжмийн зэмсэг хөглөж сурах.
- 1-ээс 2 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Чуулгын хөгжмийн тайван хэмнэлээр метроном ашиглан болон удирдаачийн удирдлага доор тоглоно.
- Зохих тоглолт, үзүүлбэрийг хийх замаар сурснаа харуулах.

**Дунд шатны хамтлаг**, Хичээлийн бүтэн жилд(19201) сурагчид дараахад суралцана:

- 7-р ангийн анхан шатны хамтлаг хичээлээр олж авсан ур чадвартай бол элсэн орох эсхүл дунд шатны хамтлагийн шалгуурыг хангасан байх.
- Хөгжмийн тэмдэглэгээ, нийлмэл метр, хуваагдал, түлхүүрийн тэмдэглэгээ болон хэд хэдэн нэмэлттэй зэрэг нотыг ойлгож, хариу үйлдэл хийх.
- Нэг хагас октав дээр тоглох ур чадвар эзэмших буюу анхан шатны онолын эхлэл (цохиур хөгжим) тавьж, эдгээр ур чадварыг чуулгын нэгэн гишүүний хувьд ашиглана.
- Сонсголоороо хөгжмийн зэмсэг хөглөж сурна.
- 2-оос 4 хэмжигдэхүүн урттай хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Хурд, дуудлага, хэв маягийн өөрчлөлт оруулан удирдаж буй удирдаачид хариу үйлдэл хийх.
- I ангийн уран зохиол, түүний дотор зохимжтой бол ганцаарчилсан тоглолт хийх зэргээр сурсан мэдсэнээ тоглолт, үзүүлбэрээр харуулах.
- Концертын зохиолоос хоёр анги доогуур түвшинд хараагаар унших.

**Ахисан шатны хамтлаг**, Хичээлийн бүтэн жилд (19228) сурагчид дараахад суралцана:

- 7-р дунд анхан шатны хамтлаг хичээлээр олсон ур чадвартайгаар элсэн орох.
- Хөгжмийн тэмдэглэгээ, түүний дотод бусад хуваагдал (гурвал, хослол, буурал) болон бусад хэл дээрт илэрхийлэл тэмдгүүдийг ойлгож, хариу үйлдэл хийх.
- Нэг хагас октав дээр тоглох ур чадвар эзэмших буюу зарчмыг иж бүрнээр (цохиур хөгжим) ойлгож, чуулгын нэгэн гишүүний хувьд эдгээр ур чадварыг хоршил болон тэнцвэрт мэдрэмжтэйгээр ашиглана.
- Түлхүүрийн тэмдэглэгээг таньж тогтоон холбогдох хэмжээст 4 хүртэлх диез эсхүл бемоль түлхүүрийн тэмдэглэгээтэй тоглоно.
- 2-оос 4 хэмжигдэхүүн урттай хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- I болон II ангийн уран зохиол, түүний дотор зохимжтой бол ганцаарчилсан тоглолт хийх зэргээр сурсан мэдсэнээ тоглолт, үзүүлбэрээр харуулах.
- Концертын зохиолоос хоёр анги доогуур түвшинд хараагаар унших.

**Анхан шатны оркестрт**, Хичээлийн бүтэн жилд (19237) сурагчид дараахад суралцана:

- Хөгжмийн зэмсэг болон нумыг зөв зохистой арчилж, зөв барьж сурна.
- Зөв техниктэй тоглож буйг харуулах, зөв аяыг гаргах, үүнд пиззикато дуу гаргах, нумыг хөрөөдөх үндсэн техник зэрэг нь орно.

- Зөв өнгө, хэмнэл, хугацаа, түлхүүр, хэмнэл болон илэрхийлэх тэмдэглэгээ зэргээр хөгжим унших үндсэн ойлголттой болох ба холбогдох хөгжмийн тоглолтыг зөв ойлгох.
- Нээлттэй чавхдас дээр (нэгдүгээр байрлалд) нэг октав болон давхар зогсолт тоглох ур чадвар эзэмших, эдгээр чадварыг чуулгын гишүүний хувьд ашиглах.
- Хөглөгч ашиглан хөгжмийн зэмсэг хөглөж сурах.
- 1-ээс 2 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Метроном ашиглан тогтсон хэмнэлээс тоглох, мөн удирдаачийн хөдөлгөөнөөр тоглох.
- Зохих тоглолт, үзүүлбэрийг хийх замаар сурснаа харуулах.

**Дунд шатны оркестр**, Хичээлийн бүтэн жилд (19242) сурагчид дараахад суралцана:

- 7-р ангийн анхан шатны оркестр хичээлээр олсон ур чадвартайгаар элсэн орох буюу дунд шатны оркестрын шалгуурыг хангасан байна.
- Хөгжмийн тэмдэглэгээ, үүний дотор төрөл бүрээр хийлдэж, хуурдах арга техник ашиглах, нийлмэл метр, хуваагдал болон хоёр диезтэй түлхүүрийн тэмдэглэгээг хүртэл ойлгож, тоглох.
- Нэг хагас октав дээр өргөтгөл ашиглан, нумын жин, хурд ба хүрэлцээг тохируулан тоглох чадвартай болох; эдгээр чадварыг чуулгын нэг гишүүний хувьд ашиглаж харуулах.
- Сонсголоороо хөгжмийн зэмсэг хөглөж сурна.
- 2-оос 4 хэмжигдэхүүн урттай хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Хурд, дуудлага, хэв маягийн өөрчлөлт оруулан удирдаж буй удирдаачид хариу үйлдэл хийх.
- Тоглолт, үзүүлбэр хийх замаар сурснаа харуулах, зохимжтой тохиолдолд гоцлол тоглолт хийх.
- Концертын зохиолоос хоёр анги доогуур түвшинд хараагаар унших.

**Ахисан шатны оркестр**, Хичээлийн бүтэн жилд (19243) сурагчид дараахад суралцана:

- 7-р дунд анхан шатны оркестр хичээлээр олсон ур чадвартайгаар элсэн орох.
- Хөгжмийн тэмдэглэгээ, түүний дотод бусад хуваагдал (гурвал, хослол, буурал), олон нотуудын нийлбэр болон бусад хэл дээрт илэрхийлэл тэмдгүүдийг ойлгож, хариу үйлдэл хийх.
- Нэг хагас октав дээр тоглох ур чадвар эзэмших, ингэхдээ өргөтгөл ашиглах, түүнчлэн чуулгын нэгэн гишүүний хувьд эдгээр ур чадварыг хоршил болон тэнцвэрт мэдрэмжтэйгээр ашиглана.
- Түлхүүрийн тэмдэглэгээг таньж тогтоон холбогдох хэмжээст 2 хүртэлх диез болон 1 бемоль түлхүүрийн тэмдэглэгээтэй тоглоно.

- 2-оос 4 хэмжигдэхүүн урттай хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Тоглолт, үзүүлбэр хийх замаар сурснаа харуулах, зохимжтой тохиолдолд гоцлол тоглолт хийх.
- Концертын зохиолоос хоёр анги доогуур түвшинд хараагаар унших.

### **Жааз хамтлаг, Бүтэн жил (19239)**

Жаазын блюз, пентатоник болон бобоп төрлүүд, даралт, даралтын тэмдэглэгээнүүд, даралтын өөрчлөлтүүд зэрэг үндсэн элементүүдийг суралцах: тэдгээрт үндэслэл гоцлол тоглох ойлголтыг авах. Томоохон хамтлагт болон/эсхүл жижиг хоршил хэлбэрээр тоглолт хийх.

### **Театрын урлаг**

#### **Бүтэн жил (11391)**

#### **Улирал (11392)**

Сурагчид дараахад суралцана:

- Сонгон шалгаруулалт, дасгал сургуулилалт, техникийн продакшн зэрэг театрын стандарт үйл явцад оролцоно.
- Тоглолтод зориулж, сэтгэл хөдөлгөсөн зохиолыг шинжилж, үнэлнэ.
- Зохиолын баатрыг биеийн, сэтгэл зүйн болон нийгмийн талаас нь бүтээнэ.
- Захирлууд болон жүжигчдийн үүрэг, хариуцлагыг ойлгож, тэдгээрт тоглоно.
- Театрын бүтээлд менежментийн гүйцэтгэх үүргийг ойлгож, таньж тогтооно.
- Бусадтай хамтран ажиллахдаа урлагийн бүтээлч сахилга батыг хөгжүүлж, ашиглана.

### **Дүрслэх урлаг I**

#### **Бүтэн жил (19040)**

#### **Улирал (19041)**

Сурагчид дараахад суралцана:

- Урлагийн бүтээл бүтээхийн тулд дизайны зарчмууд болон зургийн элементүүдийг ашиглах.
- Төрөл бүрийн арга техник болон үйл явцыг ашиглан гурван хэмжээст бүтээл бүтээх.
- Төрөл бүрийн урлагийн бүтээлд өөрийн хувийн тайлбар хийх, шүүмж өгөх.
- Зургийн нэр томьёо ашиглан урлагийн эцсийн бүтээлийг шинжилж, шүүмжлэх.
- Урлагийн бүтээл хийхдээ ёс зүйтэй шийдвэр гаргах, түүнийг тайлбарлах.

### **Дуу хөгжим**

Анги тус бүрийн зорилтыг доор зааж өгсөн бөгөөд эдгээр зорилтоос гадуур өөр бусад зорилтууд байж болно. Сургууль тус бүрд сурагчийн чуулга өөрийн гэсэн онцлог нэртэй байж болно.

*Анхан шатны хоор*, Бүтэн жил (19261) Тухайн улиралд (19264) сурагчид дараахад суралцана:

- Сайн аялгуу гаргахын тулд биеийн зөв байрлал, амьсгалын зөв хяналт, ам зөв барихад суралцах.
- Зөв өнгө, хэмнэл, хугацаа, түлхүүр, хэмнэл болон илэрхийлэх тэмдэглэгээ зэргээр хөгжим унших үндсэн ойлголттой болох ба холбогдох хөгжмийн тоглолтыг зөв ойлгох.
- Диатоник өнгөний систем ашиглан зөв өнгө гаргах, чуулганд өөрийн хэсгийг зөв барих чадвар хөгжүүлэх.
- 1-ээс 2 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Удирдаачид хариу үйлдэл үзүүлэх.
- I эсхүл II ангийн түвшинд зохих тоглолт болон илтгэлүүдийг гүйцэтгэх замаар сурснаа харуулах.

*Дунд шатны хоор*, Бүтэн жил (19274) Тухайн улиралд (19275) сурагчид дараахад суралцана:

- *Анхан шатны хоор* хичээлээр олж авсан ур чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлэх.
- Соль түлхүүрийн нотын тэмдэглэгээг ойлгож хэрэглэх.
- Өсвөр насны дуу хоолойны өөрчлөлтийн талаар сурч, тэдгээр өнгө болон царааны өөрчлөлтөд хэрхэн дасан зохицох талаар мэдэж авах.
- Хоёр болон гурван хэсэг, капелла дуулах үеэр хэрхэн өөрийн хэсгийг бие даан барих чадварт суралцах.
- Нотын барилт дотроо хэрхэн өнгийг зөв сонсож, гаргах чадвараа хөгжүүлэх.
- 2-оос 4 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Удирдаачийн фермат, хурдасгах болон удаашрах хөдөлгөөнийг ойлгож, гүйцэлдүүлэх.
- II болон III ангийн тохирох уран зохиол, түүний дотор зохимжтой бол ганцаарчилсан тоглолт хийх зэргээр сурсан мэдсэнээ тоглолт, үзүүлбэрээр харуулах.
- I түвшинд хараагаар унших.

*Ахисан шатны хоор*, Хичээлийн бүтэн жил (19285) сурагчид дараахад суралцана:

- Соль түлхүүр болон басс түлхүүрийн аль алины нотын тэмдэглэгээг ойлгож дуулна.
- Өргөн цараагаар болон илүү бие даасан байдлаар дуулах чадвараа хөгжүүлж, уг чадварыг чуулгын нэг гишүүний хувьд ашиглан харуулна.
- Гурваас дөрвөн хэсэгт дууны хувьд капеллад нийцүүлэн өнгөө цэвэр гаргах чадвараа хөгжүүлнэ.
- 4-өөс 8 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Хурд, дуудлага, хэв маягийн өөрчлөлт оруулан удирдаж буй удирдаачид хариу үйлдэл хийх.
- III болон IV ангийн тохирох уран зохиол, түүний дотор зохимжтой бол ганцаарчилсан тоглолт хийх

зэргээр сурсан мэдсэнээ тоглолт, үзүүлбэрээр харуулах.

- Концертын зохиолоос хоёр анги доогуур түвшинд хараагаар унших.

## **БИЗНЕС, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ**

### **Дижитал оролтын технологиуд**

#### **Бүтэн жил (16607)**

##### **Улирал (16617)**

Дижитал оролтын технологиуд хичээлээр шинэ тутам гарч ирж буй оролтын төхөөрөмжүүд (тухайлбал, яриа болон гар бичлэг таних программ хангамж, таблет, үүлэн тооцооллын аппликейшнүүд, чихэвч/микрофон, сканер, дижитал зургийн аппарат, хөдөлгөөнт төхөөрөмж, компьютер систем) зэргийг танилцуулж, өдөр тутам ажлын байранд хэрэглэгддэг стандарт хэрэглээ болж буй хэрэгслийг ашиглахад сурагчдыг бэлтгэнэ.

Сурагчид дараахад суралцана:

- Товшин шивэх арга техникээ хөгжүүлэн оновчтой бөгөөд хурдтай шивэх чадвараа сайжруулах.
- Word боловсруулалтын программ хангамж, түүний дотор десктоп эх бэлтгэлийн бүхий л үзүүлэлт, ур чадварыг эзэмших, дадлага хийх.
- Хичээлд зориулан баримт бичиг боловсруулахдаа word боловсруулалтын программ хангамж ашиглах, бичих болон засварлах чадвараа сайжруулах.
- Төрөл бүрийн цахим баримт бичиг үйлдэх, форматлах. Үүнд бизнесийн болон хувийн захидал, дугтуй, тооцоолох хуудас, графикууд, тайлан, улирлын ажил болон тэмдэглэл багтана.
- Төрөл бүрийн ажил мэргэжлийн судалгаа хийж, анкет бэлтгэх болон ярилцлага хийх ур чадвар зэрэг ажлын байранд тэнцэх хувийн ур чадваруудын талаар ойлголт авах.
- Америкийн эдийн засгийн систем дэх бизнес эзэмшил, бизнесийн чиг үүрэг зэрэгтэй танилцах.
- Хувийн санхүүгээ хянах, чек дансныхаа баланс гаргах, төлбөрийн чекийг тайлбарлах, даатгал болон автомашин худалдаж авах, боломжийн нөхцөлтэй орон байр сонгох, хөрөнгө оруулах болон хэрэглэгчийн холбогдолтой бусад ур чадвар.
- Шинэ тутам гарч ирж буй технологийг ажлын байранд ашиглах талаар хэлэлцэх (тухайлбал, дэлгэц дээр бичих, яриа таних, iPad, болон хөдөлгөөнт технологи).

### **Компьютерын програмчлал ДС (16640)**

#### **Бүтэн жил, нэг кредит**

Компьютерын програмчлалын (Код бичих) хичээл нь сурагчдын код бичих, тооцоолон бодох, санхүүгийн болон дижитал мэдлэг, ур чадварыг сайжруулахын зэрэгцээ компьютерын шинжлэх ухааны онол, дизайны ойлголтуудыг өгнө. Сургалтын хөтөлбөрт

Java бүхий Python Alice, Java Scratch, HTML, Java Scripting зэрэг програмчлалын хэл ашиглан код бичих, гар утасны апп болон цахим хуудас хөгжүүлэх багтана. Нэгдсэн цогц төсөл нь “бодит амьдрал дээрх” математик болон санхүүгийн боловсролыг ашиглахад чиглэгдэнэ.

*Тайлбар: Энэ хичээлээр ахлах сургуулийн кредит олгогдох бөгөөд арлах сургууль төгсөхөд тавигдах шаардлагыг хангана. Дэлгэрэнгүй мэдээллийг 56-р хуудаснаас авна уу. “С” эсвэл түүнээс дээш үнэлгээтэй энэ хичээлийг дүүргэсний дараа сурагчид хос бус элсэлттэй Компьютерын програмчлалын гүнзгий эсвэл АР Компьютерын шинжлэх ухааны үндэс хичээл уруу дэвшиж болно.*

## **АНГЛИ ХЭЛ**

### **7-р ангийн Унших чадварын хичээл**

#### **Бүтэн жил (11111)**

##### **Улирал (11113)**

*Багш болон/эсхүл зөвлөхийн санал болгосноор*

7-р ангийн Унших чадварын хичээл нь сурагчид уншиж бичих чадвараа нэмэгдүүлэхэд тусгайлан чиглэсэн заавар авч, нэмэлт цаг зарцуулах сонгох Англи хэлний хичээл юм. Багш нар унших чадварт холбогдох дараах зүйлүүдэд голчлон анхаарна: авиа зүй, авиалбар, түгдрэхгүй унших, үгсийн сан, уншсанаа ойлгох. Эдгээр нэн чухал бүрэлдэхүүн хэсгийн зэрэгцээ үе үе шалгалт авч сурагчийн зорилгот түвшинд хүрэхэд гаргасан ахицыг хэмжинэ. Сурагчид бие даан болон багаараа дараах зорилгоор ажиллана:

- идэвхтэй унших стратегиудыг сурч, дадлага хийх.
- зохион байгуулалттай унших дадлага хийх (илэрхий, кодчилох/код тайлах системтэй үг дээр ажиллах)
- унших болон бичих тэсвэр хатуужил суух, чөлөөтэй эзэмших.
- үгсийн сангаа баяжуулах.
- ойлголтоо нэмэгдүүлэх.
- унших туршлагаа өргөжүүлэх.

### **Сэтгүүл зүй**

#### **Бүтэн жил (11201)**

Энэхүү сонгон суралцах хичээлээр сурагчид сонин эсхүл аудио/видео мэдээний нэвтрүүлэг хийнэ. Өөрсдийн бүтээлээр дамжуулан сурагчид сонин болон нэвтрүүлэг бичих болон найруулах чадвар эзэмшинэ.

Сурагчид дараахад суралцана:

- Сэтгүүл зүйн хэв маягуудыг сурч, ашиглах.
- Хэвлэмэл болон/эсхүл телевизийн нэвтрүүлгийг агуулга болон техникийн чанарын хувьд шинжлэх.
- Спортын, мэдээний, сэтгэгдлийн зэрэг нийтлэлүүд бичих болон/эсхүл сурталчилгаа,



олон нийтийн үйлчилгээний зар, эсхүл мэдээний шоу зэрэг нэвтрүүлэг бэлтгэх.

- Хянах, засварлах, зураг, хуулбар, онцлох өгүүлбэр зэргийг байрлуулах, үсэг өрөх, эцсийн бүтээгдэхүүн гаргах зэрэг сэтгүүл зүйн холбогдолтой төрөл бүрийн ажил хийж үзэх.

### **Хэвлэл мэдээллийн сэтгүүл зүй**

#### **Улирал (11204)**

Уг сонгох хичээлээр сурагчид шинэ төрлийн медиаг ойлгож, тайлбарлаж, ийм төрлийн агуулга бүтээх талаар ойлголттой болно. Үүнд дижитал видео, дижитал фото зураг, дижитал хөгжим, онлайн хэвлэл зэрэг багтана. Түүнчлэн сурагчид харилцаа болон олон хэлбэрийн бичиг үсэг тайллын Виржиниягийн Англи хэл суралцах стандартуудыг судалж, суралцана.

Сурагчид дараахад суралцана:

- Хэвлэл мэдээллийн сэтгүүл зүйн бүх хэлбэрийг агуулга болон техникийн чанарын хувьд шинжилж үзэх.
- Хэвлэл мэдээллийн шинэ агуулгын жишээ бүтээл туурвих.
- Жинхэнэ үзэгчдэд зориулан онлайн бүтээл нийтлэх (тухайлбал: блог, цахим хуудас ашиглан)
- iPads болон боломжтой бусад төхөөрөмж ашиглан дижитал медиа продакшны үндсэн ойлголтуудыг авах.
- Хэвлэл мэдээллийн боловсролын суурийг ойлгож авах.

### **ГЭР БҮР БОЛОН ХЭРЭГЛЭГЧИЙН ШИНЖЛЭХ УХААН**

#### **Өсвөр насны амьдрал**

#### **Улирал (18207)**

“Өсвөр насны амьдрал” хичээлээр тодорхой төсөлд суурилж амьдралын олон тохиолдолд хариуцлагатай хандахад голчлон анхаарна.

Сурагчид дараах зүйлд анхаарал хандуулна:

- Хувь хүний хөгжил.
- Хувийн орон зайгаа хадгалах.
- Хүнс тэжээл болон эрүүл амьдралын дадлыг хэрэгжүүлэх.
- Хэрэглэгчийн болон гэр бүлийн нөөцийг удирдах.
- Даавуу, загвар болон хувцас хэрэглэл бүтээх.
- Гэр бүл болон хэрэглэгчийн шинжлэх ухаантай холбоотой ажил мэргэжлийг судлах.

Уг хичээлийн заах арга зүй нь тохиромжтой үед шинжлэх ухаан, технологи, инженерчлэл болон математик (STEM)-ийн онолууд ашиглана.

### **МАТЕМАТИК**

#### **Математикийн стратегиуд 7-р анги**

### **Бүтэн жил (13117)**

#### **Улирал (13120)**

Стратегийн хичээл нь сонгон суралцах хичээл бөгөөд математикийн хичээлд хоцролттой байгаа сурагчдад зориулагдсан. Стратегийн хичээлээр сурагчид суурь мэдлэгээ бэхжүүлж, өгөгдлийг ойлгох аргачлалд суралцаж, үндсэн хичээлийн агуулгыг сайтар ойлгоход суралцана.

### **ТУСГАЙ БОЛОВСРОЛ**

#### **Заах арга зүй судлал**

#### **Бүтэн жил (10028)**

*Урьдчилсан шаардлага: Сурагчийг тусгай боловсролын үйлчилгээнд хамруулах шаардлагатай гэж дүгнэлт гарсан байх шаардлагатай*

Тусгайлсан боловсролын хөтөлбөр (IEP)-ийн дагуу тухайн сурагчид тусгайлан зориулж хичээл орох ба сурагчид олгох ерөнхий боловсролын шаардлагыг хангахад чиглэнэ. Түүнчлэн сонсох, бичих, зохион байгуулах болон ерөнхий суралцах чадварт онцгой анхаарал хандуулна.

#### **Нийгэмших чадвар, Бүтэн жил (10023)**

*Урьдчилсан шаардлага: Сурагчийг тусгай боловсролын үйлчилгээнд хамруулах шаардлагатай гэж дүгнэлт гарсан байх шаардлагатай*

Нийгэмших чадварын хичээлээр дунд сургуулийн сурагч бусадтай зохистой нийгмийн харилцаанд ороход шаардлагатай ур чадварыг олж авч, дадлага хийх боломжтой. Бусадтай харилцах, өөр өнцгөөс харах, өөрийгөө дайчлах, багаар ажиллах, стресс болон бухимдлаа дарах аргачлал, нийгмийн харилцааны “бичигдээгүй хуулиуд” зэргийг суралцах ур чадварт багтаана. Хувийн зохион байгуулалт, өөрийгөө өмгөөлөх, хамгаалах зэрэг ур чадварууд мөн багтана.

### **СУРАГЧИЙН ДЭМЖЛЭГ**

#### **Үндсэн хичээлийн нэмэлт**

#### **Бүтэн жил (11129)**

#### **Улирал (11128)**

Хувийн зохион байгуулалт, тэмдэглэл хөтлөх, шалгалт өгөх болон сурагч илүү их амжилт олоход туслах бусад арга барилуудыг заах ерөнхий сургалтад энэ хичээл нь зориулагдсан.

Сурагчид дараахад суралцана:

- Хичээл давтах цагаа төлөвлөх.
- Сонсох чадвараа сайжруулах арга барилд суралцах.
- Хичээл, сурлагын талаарх одоогийн хандлагадаа дүгнэлт хийж, юу илүү чухал болохыг тодорхойлж, зорилго тавьж, эерэг хандлага бий болгох.
- Уншиж ойлгох, санаж тогтооход суралцах арга барил, дадал чадварыг хэрэглэх.

## ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ

### Зохион бүтээх ба инновац

#### Бүтэн жил (18464)

#### Улирал (18433)

Сурагчид түүхэнд нөлөөлж, нийгмийг урагшлуулж, манай дэлхийг өөрчилсөн ач холбогдолтой чухал зохион бүтээл болон инженеринг чиглэлээр гаргасан амжилтуудыг судална. Тэд орчин үеийн технологийн асуудлууд, хувь хүн, олон нийт болон дэлхий нийтэд тулгараад бус асуудлуудын талаар судалж, системчилсэн дизайн болон хөгжүүлэлтийн горим ашиглан шийдэл санал болгож, инновац хэрэгжүүлэн, шинэ бүтээл зохион бүтээнэ. Хичээлүүдийг Шинжлэх ухаан, технологи, инженеринг, математикт (ШУТИМ) шигтгэн төлөвлөн боловсруулсан.

Сурагчид дараахад суралцана:

- Асуудал шийдэх инженеринг ашиглах, ойлголт авах.
- Хүн төрөлхтний түүхэн ахиц дэвшилд технологийн гүйцэтгэх үүрэг, нөлөөг судлах.
- Түүхийг өөрчилсөн технологийн дэвшил болон инженерингийн чиглэлийн амжилтуудыг судлах
- Технологийн дэвшил болон инженерингийн чиглэлийн амжилтуудын эерэг болон сөрөг нөлөөллийг дүгнэх.
- Асуудал шийдвэрлэх, загвар урлахад багаар болон хамтран ажиллах дадлага хийнэ.
- Лаборатори дахь багаж, машин, төхөөрөмжийг аюулгүй, зөв ажиллуулна.
- Загвар урлан бүтээхэд ашиглах багаж, үйлдвэрлэх үйл явцыг сонгох.
- Хамгийн шилдэг санааг сонгох зорилгоор янз бүрийн шийдлүүдийг судалж, үнэлж, дүгнэх.
- Хэрхэн ажилладаг болохыг үр дүнтэй тайлбарлах үүднээс зохион бүтээх санаагаа урлах, дүрслэх.
- Хар зураг, олон хэмжээст зураг, компьютерын тусламжтай дизайны программ хангамж зэргийг ашиглан санаагаа ойлгуулах.

### ДЭЛХИЙН ХЭЛНҮҮД

Арлингтоны улсын сургуулийн 7-12-р ангийн сурагчид төрөлх хэл судлалаар болон дэлхийн хэл судлалаар ахлах сургуулийн дэлхийн хэлний кредит авах боломжтой. Дараагийн шатанд үргэлжлүүлэхийн тулд тус хичээлд С эсвэл түүнээс дээш оноо авах шаардлагатайг анхаарна уу. Хичээл үе шаттайгаар явагдах тул С эсвэл түүнээс сайн дүн сурагчид цаашид амжилттай суралцах боломжтой.

Дэлхийн хэлний кредит авахын тулд дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- Кредит тус бүрд 140 цагаас доошгүй албан ёсны хэлний сургалтад хамрагдсан болохыг илтгэх дүнгийн хуулбар.

- Сурагч тэнцсэн дүн авсан байх шаардлагатай.

*Ахисан шатны сургалтын диплом авах хүсэлтэй сурагчид гурван жил/түвшний нэг хэл эсхүл хоёр жилийн хоёр хэл суралцсанаар дэлхийн хэлний шаардлагыг хангана. Дэлхийн хэл бүрийн хичээлийг амжилттай дүүргэснээр Ахисан шатны сургалтын диплом авах нэг кредит авна. Зарим коллеж дэлхийн хэлний сургалтыг ахлах сургуульд мөн үргэлжлүүлсэн байхыг шаарддаг. Хэрэв танай сурагч ахлах сургуулийн эхний жил гурван жилийн сургалтаа амжилттай дуусгасан бол сурагчийн сонгосон коллежийн элсэлтийн шалгуурыг хараарай.*

**Америкийн дохионы хэл (ASL) нь Виржиниягийн улсын их сургуулиуд болон олон нийтийн коллежийн элсэлтийн хэлний шаардлагыг хангадаг. Зарим өөр мужийн их, дээд сургуулиуд ASL-ийг дэлхийн хэлд тооцдоггүй. ASL нь Олон улсын бакалаврын (ОУБ) хэл биш.**

### Америкийн дохионы хэл I (15990)

#### Бүтэн жил, нэг кредит

*Урьдчилсан шаардлага: Байхгүй*

Сурагчид өөрийн гэр, сургууль болон нийгэмд бусадтай харилцахдаа ашиглах дохионы хэл ойлгох, дохионы хэлээр ярих чадварыг суралцана. Сурагчид гэр бүл, сургуулийн арга хэмжээ болон тэмдэглэлт баярын талаар асуулт асууж, хариулж сурна. Гарын дохиогоор бус (тухайлбал, нүүр хувирал, биеийн хөдөлгөөн, хувийн орон зай) байдлыг ашиглаж дохионы хэлээр танилцуулах, баяртай гэж хэлэх, бусдын анхаарлыг хандуулах, хэлэлцээр хийх зэрэг наад захын мэдээллийг өгч, авч сурна. Сурагчид Америкийн дохионы хэлний түүхийг судалж, сонсголгүйчүүдийн соёлыг таньж мэднэ.

### Араб хэл I

#### Бүтэн жил (15800)

Энэ түвшинд сурагчдыг Араб хэлний цагаан толгой болон авианы системтэй танилцуулна. Энэ хичээл соёлын болон түүхийн мэдээллээр баялаг. Араб хэлний түүх, Араб хэлний гэр бүлийн мод болон бичвэрийг олгоно. Анхны авиа зүйд болон бичих системд хандуулах анхаарлын зэрэгцээ сурагчид хэлний авиа, өргөлт болон өнгийг сурч, хэрэглэж сурна. Хэл зүйн дүрмийн үндсэн бүтэц, үгсийн санг танилцуулснаар сурагчид маш анхан шатны албан харилцааг энгийн хялбар өгүүлбэр болон харилцан яриагаар зохих түвшинд өрнүүлнэ. Сурагчид сонссон үг болон өгүүлбэрээ бичих чадвартай болох бөгөөд өмнө сурсан үг болон өгүүлбэрийг уншиж, мэндчилж, бусдыг танилцуулж, энгийн хялбар асуулт, хариулт зохиож, анхан шатны нийгмийн харилцаанд орно, өөрсдийн болон өөрийн гэр бүлийн гишүүд болон бусдын талаар ярьж, өөрийн хувийн үндсэн мэдээллийг солилцоно. Сургалтын үндсэн сэдэв нь хувийн болон гэр бүлийн амьдрал байна.

- Ромын өдөр тутмын амьдрал, зан заншил, төр засаг болон домог түүхийн талаар судлах.

## Хятад хэл I

### Бүтэн жил (15615)

Сурагчид өөрийн тухай болон өөрийн ойр орчны тухай хялбар бүтэцтэй энгийн өгүүлбэр ашиглан ярьж ойлгуулах чадвар эзэмшинэ. Энэ харилцаа нь хэлний дөрвөн ур чадвар болох сонсох, ярих, унших болон бичихээр харагдах бөгөөд ярих болон бичихэд илүү анхаарал хандуулна. Сурагчид хувийн болон гэр бүлийн амьдрал, сургуулийн амьдрал, нийгмийн болон олон нийтийн дундах амьдрал зэрэг сэдвийн хүрээнд хэлийг судална.

## Франц хэл I

### Бүтэн жил (15110)

Бодит амьдрлын жишээ, харилцан яриа, жүжиг болон бусад бүтээлч, биеэр оролцох үйл ажиллагаагаар хэл сурахад анхаарлаа хандуулна. Сурагчид ур чадвараа хөгжүүлж, сонсох, ярих, унших болон бичих замаар хэлний үндсэн бүтэц, үгсийн санг сурна.

Сурагчид дараахад суралцана:

- Мэндчилэх, салах ёс, найрсаг харилцаанд суралцах.
- Найз, гэр бүл болон сургуулийн хүрээнд энгийн яриа өрнүүлэх.
- Танил сэдвээр асуулт асууж, хариулах.
- Хоолны цэс, тэмдэглэгээ, хуваарь болон бусад амьдралын зүйлсийг унших.
- Богино хэмжээний тайлбар, захиа бичих, зааврын дагуу зохион бичлэг бичих.
- Суралцаж буй хэлд холбогдох өдөр тутмын амьдралын соёлтой танилцах.

## Латин хэл I

### Бүтэн жил (15310)

Энэхүү анхан шатны Латин хэлний хичээлээр сурагчид эртний Ромын хэл болон аж амьдралтай танилцана. Латин хэл I хичээлийн гол зорилго нь сонсох, ярих болон бичих ур чадварын дэмжлэгтэйгээр унших чадвараа хөгжүүлэх юм.

Сурагчид дараахад суралцана:

- Хялбарчилсан Латин хэлний текст болон энгийн хялбар Латин эх сурвалжуудыг унших.
- Латин дуудлагын үндсэн элементүүдийг ойлгох.
- Анхан шатны Латин үгнүүд сурах.
- Латин хэлний нэр үг болон үйл үгийн төгсгөлүүд, тэдгээрийн үүргийг сурч ойлгох.
- Латин хэлний анхан шатны хэл зүйн дүрмийг ойлгож авах.
- Латин үгийн үндэс, угтвар болон дагавар ашиглан Латин болон Англи хэл дээр үг үүсгэх мэдлэгээ дээшлүүлэх.

## Испани хэл I

### Бүтэн жил (15510)

Бодит амьдрлын жишээ, харилцан яриа, жүжиг болон бусад бүтээлч, биеэр оролцох үйл ажиллагаагаар хэл сурахад анхаарлаа хандуулна. Сурагчид ур чадвараа хөгжүүлж, сонсох, ярих, унших болон бичих замаар хэлний үндсэн бүтэц, үгсийн санг сурна.

Сурагчид дараахад суралцана:

- Мэндчилэх, салах ёс, найрсаг харилцаанд суралцах.
- Найз, гэр бүл болон сургуулийн хүрээнд энгийн яриа өрнүүлэх.
- Танил сэдвээр асуулт асууж, хариулах.
- Хоолны цэс, тэмдэглэгээ, хуваарь болон бусад амьдралын зүйлсийг унших.
- Богино хэмжээний тайлбар, захиа бичих, зааврын дагуу зохион бичлэг бичих.
- Суралцаж буй хэлд холбогдох өдөр тутмын амьдралын соёлтой танилцах.

## Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан испани хэл I

### Бүтэн жил (15517)

*Урьдчилсан шаардлага: Багшийн тодорхойлсноор Испани хэлээр чөлөөтэй ярьж чаддаг байх*

Энэ хичээл нь Испани хэлээр чөлөөтэй ярьдаг боловч уншиж, бичих чадвар хангалттай эзэмшээгүй сурагчдад зориулагдсан. Сурагчид унших, бичих, ярих харилцааны ур чадвар эзэмшиж, Испани хэл зүйн дүрмийг сурч эхлэх болно. Сурагчид Испани хэл соёлын өнцгөөс харах, илэрхийлэх хэлбэрийн талаар илүү сайн ойлголттой болно.

## Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл II,

### Бүтэн жил (15527)

*Урьдчилсан шаардлага: Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл I хичээлийг амжилттай дуусгасан эсхүл байршуулах шалгалтаар ойролцоо түвшний чадвар эзэмшсэн нь тодорхойлогдсон*

Энэ хичээл нь Испани хэлээр анхан шатны түвшинд хэдийнээ уншиж, бичиж чаддаг хүмүүст зориулагдсан. Сурагчид зөв бичих, механик болон богино зохион бичлэг хийх чадвараа дээшлүүлнэ. Тэд эх бүтээл уншиж, орчуулж эхлэх бөгөөд/эсхүл хүүрнэл өгүүлэл болон шүлгийг шинжилнэ. Хэл зүйн дүрмийг үргэлжлүүлэн судална. Сурагчид ангидаа илтгэл тавих болон хоорондоо харилцах бусад үйл ажиллагаагаар ярианы чадвараа сайжруулна. Соёл, ёс заншлыг судалж, уран зохиолоор дамжуулан илүү гүнзгий ойлголттой болно.

## **8-р АНГИЙН ҮНДСЭН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

### **АНГЛИ ХЭЛ, СОЁЛ**

#### **8-р ангийн Англи хэл (11120)**

Бүх дунд сургуулиудад Англи хэл, соёлын хөтөлбөр нь Виржиниягийн Англи хэл суралцах стандартуудад заасан дөрвөн чиглэлийн хүрээнд голлон анхаарна: харилцаа болон олон хэлбэрийн бичиг үсэг тайлал, унших, бичих болон судлах. Эдгээр чиглэлээр ур чадвартай байх нь сурагчийн ахисан түвшинд тунгаан бодоход нөлөөлж, хичээлдээ болон хичээлээс гадуур амжилтад хүргэхэд хөтөлнө.

Сургалтын хөтөлбөр нь ойлгуулах, чухал асуултуудыг хөндөхөд чиглэсэн үзэл баримтлал, аргачлалд тулгуурлана.

- Уран зохиол болон баримтат зохиолыг харьцуулах хэлбэрээр уншсанаа ойлгох чадварт үргэлжлүүлэн анхаарах болно. Уран зохиолыг уншихдаа сурагчид сэдвийн өрнөлийг тайлбарлаж, зохиолчийн хэв маягийг харьцуулан/жишнэ. Баримтат зохиолд илүү анхаарал хандуулах бөгөөд сурагчид зохиолчийн мэргэшил, байр суурь болон хэв маягт дүн шинжилгээ хийнэ.
- Сурагчид үргэлжлүүлэн үгийн гарал үүсэл, үндсийг судалж, ил болон далд утгыг үргэлжлүүлэн судална.
- Сурагчид төрөл бүрийн хэлбэрээр дүрслэл өгүүллэг болон ятгалга бичлэгт төвлөрсөн зохион бичлэгүүд төлөвлөхийн зэрэгцээ төсөл бичиж, засаж найруулан, хянан тохиолдуулна. Сурагчид эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, учир шалтгаан, нотолгоо, хариу мэдэгдэл ашиглан өөрийн байр суурийг хамгаална.
- Сурагчид медиа зурвас боловсруулах, шинжлэх, хөгжүүлэх, дүгнэх болно. Сурагчид өөр байр суурийг багтаасан олон хэлбэрийн илтгэлүүд бүтээнэ.
- Сурагчид санал бодлоо солилцож, шийдвэр гарган, зорилгодоо хүрч, асуудлыг шийдэхээр бусадтай хамтран ажиллана.

- Сурагчид төрөл бүрийн эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлдээ судалгааны арга техник ашиглан дүн шинжилгээ хийж, буруу ойлголт болон аль нэг талыг илт баримталсан байдлыг олж илрүүлнэ. Сурагчид MLA эсхүл APA хэв маягийг ашиглан анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудаа бүртгэнэ. Бусдын бүтээлийг хулгайлах талаарх ойлголт, түүний үр дагаврыг онцлон танилцуулна.

### **ЭРҮҮЛ МЭНД БОЛОН БИЕ БЯЛДРЫН БОЛОВСРОЛ**

#### **8-р анги Эрүүл мэнд болон бие бялдрын боловсрол (17200)**

8-р ангийн бүх сурагчид эрүүл мэнд болон бие бялдрын боловсролын хөтөлбөрт хамрагдана. Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр нь эрүүл амьдралын хэв маягийг эзэмшихэд сурагчид мэдэх, ойлгох, хийх хэрэгцээ шаардлагыг онцолно. Эрүүл мэндийн боловсролоор сурагчдад халдварт өвчний гарал үүсэл болон учир шалтгааны талаар ойлголт өгнө. Сурагчид эрүүл мэндийн чиглэлээр гаргасан сонголтынхоо үр дагаврыг ойлгож, эрүүл мэндийн ур чадвараа хувийн, гэр бүлийн болон олон нийтийн дунд нөлөөллийн ажилд ашиглана. Судлах сэдвүүдэд сэтгэл зүйн, сэтгэл мэдрэлийн, нийгмийн болон орчны эрүүл мэнд, аюулгүй байдал болон бэлэн байдал, харилцаа, мансууруулах бодисын хэрэглээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гэр бүлийн амьдралын боловсрол зэрэг багтана. Бие бялдрын боловсрол нь өөрчилсөн хөдөлгөөний хэлбэрээс нарийн төвөгтэй хэрэглээ рүү шилжинэ. Сурагчид биеийн бүтцийн болон системийн талаарх мэдлэгээ бие хэрхэн хөдлөхөд ашиглана. Сурагчид зорилгоо тодорхойлж, эрүүл мэндийн холбогдолтой бие бялдрын хөгжлөөр гаргаж буй ахицаа хянаана. Сурагчид төрөл бүрийн спорт/үйл ажиллагаанд цогц чадвар эзэмшиж, насан туршдаа хэрэгжүүлэх дадлын үндсийг олж авна.

### **МАТЕМАТИК**

#### **8-р ангийнханд зориулсан алгебрын бэлтгэл (13112)**

8-р ангийнханд зориулсан алгебрын бэлтгэл нь үндсэн хичээл бөгөөд наймдугаар ангийн сурагчдад зориулсан материалыг эрчимжүүлсэн хэлбэрээр орно. 8-р ангийн стандартууд нь сурагч Алгебр I болон түүний дараах хичээлийг амжилттай дүүргэхэд шаардлагатай бүх суурь алгебрын бэлтгэлийг багтсан. Сурагчид дараах ойлголтыг авна:

1. Тоо ба тооны тухай ойлголт
2. Тооцоолох ба тоймлох
3. Хэмжилт
4. Магадлал ба статистик
5. Хэв маяг, хэлбэр, функц ба алгебр

Түүнчлэн стандарт агуулга нь математик суралцахтай холбоотой дараах үйл явцын зорилгыг дэмжихэд чиглэгдсэн: Асуудал шийдвэрлэх, харилцаа, холбоо, төлөөлөл ба учир шалтгаан.

8-р ангийн математикийн хичээлийн Виржиния мужийн стандартыг (SOL) хангах агуулгын зарим тодорхой жишээг дурдвал:

- Системийн тоог ангилах, тооцоолох зэргийг оролцуулсан бодит тооны систем.
- Хэрэглэгчийн хэрэглээтэй холбоотой бодит бодлогууд.
- Өнцгийн хамааралд үндэслэн мэдэгдэхгүй байгаа өнцгийг хэмжиж олох.
- Төрөл бүрийн дүрсний талбай, эзлэхүүнийг тооцоолох, түүнчлэн өөрчлөгдөж буй нэг шинж чанартай холбоотой тодорхойлолт, дүн шинжилгээ.
- Тусах, ойх, тэлэх зэрэг өөрчлөлтүүдийг хэрэглэж сурах.
- Дээд/доод, хажуугийн болон урд/ард талаас харагдах зургийг ашиглан гурван хэмжээст загвар бүтээх.
- Пифагорын онолыг хэрэглэж, баталгаажуулах.
- Нийлмэл дүрсний тайлбай, периметрийг олох.
- Харилцан хамааралтай болон хамааралгүй үйл явдлын магадлалыг харьцуулан, магадлалыг тооцоолох.
- Төлөөлүүлэх, ажиглалт хийх, таамаг дэвшүүлэх, хайрцаг плот, тархалт плотыг харьцуулан дүн шинжилгээ хийх.
- Алгебрын илэрхийллийг хялбарчлах, бодох.
- Функцид харилцан хамаарал байгаа эсэхийг тодорхойлох, домэйн, хязгаар, хамаарал бүхий болон хамааралгүй хувьсагчийг тодорхойлох.
- Налууг тодорхойлж, тайлбарлах, өгөгдөл, график эсхүл тэгшитгэл нь өгөгдсөн функцийн огтлолцол олох, үгэн тайлбар хийх, хүснэгт, тэгшитгэл болон график.
- Олон үйлдэлт илэрхийлэл бодох, нэг талдаа эсхүл хоёр талдаа хувьсагчтай бодлого бодох, бодит амьдралын жишээнд түүнийг хэрэглэхэд анхаарна.

### Алгебр I (13130)

Алгебр I нь Виржиния мужийн 6 болон 7-р ангийнханд зориулсан суралцах стандартыг хангасан бөгөөд 8-р ангийнханд зориулсан Алгебрын бэлтгэл ангид (VDOE 8-р ангийн математикийн стандарт) нэмэлт зааварчилгаа шаардлагатай байж болох бүх сурагчид математикийг эрчимжүүлсэн хэлбэрээр орох үндсэн хичээл юм.

Алгебрын хичээлээр сурагчид дараах ойлголтыг авах болно:

1. Илэрхийлэл болон үйлдлүүд

2. Тэнцэтгэл болон үл тэнцэтгэл
3. Функциуд
4. Статистик

Түүнчлэн стандарт агуулга нь математик суралцахтай холбоотой дараах үйл явцын зорилгыг дэмжихэд чиглэгдсэн: Асуудал шийдвэрлэх, харилцаа, холбоо, төлөөлөл ба учир шалтгаан.

Алгебр I хичээлийг судлах Виржиния мужийн стандартыг (SOL) хангах агуулгын зарим тодорхой жишээг дурдвал:

- Үгээр илэрхийлсэн тоон нөхцөл байдлыг алгебр хэлбэрээр төлөөлүүлж, илэрхийллийг бодох.
- Зэрэгт дэвшүүлэх, үйлдэл болон үржүүлэх хуулиудыг ашиглан полином үйлдлүүдийг гүйцэтгэх.
- Квадрат болон куб зэрэгт дэвшүүлснийг хялбарчлах.
- Шугаман, квадрат болон илэрхий зэрэг нэг хувьсагчтай олон үйлдэлт тэнцэтгэлийг алгебрын аргаар бодох, бодит асуудал шийдэхэд анхаарал хандуулах.
- Хоёр хувьсагчтай хоёр шугаман тэнцэтгэлийн системийг графикийн аргаар болон алгебрын аргаар бодох.
- Хоёр хувьсагчтай үл тэнцэтгэлийн хариуг графикаар илэрхийлэх, үүнд үл тэнцэтгэлийн системийг хамааруулна.
- Налууг олох, тэнцэтгэлийг бичих, хоёр хувьсагчид шугаман тэнцэтгэлийн графикийг зурах.
- Шугаман болон квадрат функцуудыг графикийн болон алгебрын аргаар судлан, шинжлэх.
- Бодит нөхцөл байдал дахь өгөгдлийн иж бүрдэл өгөгдсөн тохиолдолд шууд эсхүл урвуу хувьсал байгаа эсэхийг тодорхойлж, тэдгээрийг алгебрын болон графикийн аргаар илэрхийлэх.
- Бодит хариу өгөгдсөн тохиолдолд өгөгдлийг цуглуулж, шинжлэх, тохирох муруйн тэнцэтгэлийг тодорхойлж, шугаман болон квадрат функцийн таамаг дэвшүүлэх.

*Тайлбар: Энэ хичээлээр ахлах сургуулийн кредит олгогдох бөгөөд ахлах сургууль төгсөхөд тавигдах шаардлагыг хангаж, ахлах сургуулийн голч дүнд нөлөөлж, ахлах сургуулийн дунгийн жагсаалтад бичигдэнэ. Ахлах сургуулийн кредитийн талаарх 56-р хуудас, APS PIP I-11.6.30 зэргийг харж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.*

### Алгебр I, Гүнзгийрүүлсэн (13140)

Гүнзгийрүүлсэн Алгебр I нь үндсэн хичээл бөгөөд 6, 7 болон 8-р ангийн математикийн хичээлийн Виржиния мужийн сургалтын стандартуудыг хангасан болохоо харуулсан бөгөөд цаашид нэмэлтээр ахисан түвшний сэдэв судлах хүсэлтэй ДС-ийн бүх сурагчдад зориулсан эрчимжүүлсэн хэлбэрээр математикийн агуулгыг танилцуулах хичээл юм.

Гүнзгийрүүлсэн Алгебр I хичээлээр сурагчид дараах ойлголтыг авах болно:

1. Илэрхийлэл болон үйлдлүүд
2. Тэнцэтгэл болон үл тэнцэтгэл
3. Функцүүд
4. Статистик

Түүнчлэн стандарт агуулга нь математик суралцахтай холбоотой дараах үйл явцын зорилгыг дэмжихэд чиглэгдсэн: Асуудал шийдвэрлэх, харилцаа, холбоо, төлөөлөл ба учир шалтгаан.

Гүнзгийрүүлсэн Алгебр I хичээлийг судлах Виржиния мужийн стандартыг (SOL) хангах агуулгын зарим тодорхой жишээг дурдвал:

- Үгээр илэрхийлсэн тоон нөхцөл байдлыг алгебр хэлбэрээр төлөөлүүлж, илэрхийллийг бодох.
- Зэрэгт дэвшүүлэх, үйлдэл болон үржүүлэх хуулиудыг ашиглан полином үйлдлүүдийг гүйцэтгэх.
- Квадрат болон куб зэрэгт дэвшүүлснийг хялбарчлах.
- Шугаман, квадрат болон илэрхий зэрэг нэг хувьсагчтай олон үйлдэлт тэнцэтгэлийг алгебрын аргаар бодох, бодит асуудал шийдэхэд анхаарал хандуулах.
- Хоёр хувьсагчтай хоёр шугаман тэнцэтгэлийн системийг графикийн аргаар болон алгебрын аргаар бодох.
- Хоёр хувьсагчтай үл тэнцэтгэлийн хариуг графикаар илэрхийлэх, үүнд үл тэнцэтгэлийн системийг хамааруулна.
- Налууг олох, тэнцэтгэлийг бичих, хоёр хувьсагчид шугаман тэнцэтгэлийн графикийг зурах.
- Шугаман болон квадрат функцуудыг графикийн болон алгебрын аргаар судлан, шинжлэх.
- Бодит нөхцөл байдал дахь өгөгдлийн иж бүрдэл өгөгдсөн тохиолдолд шууд эсхүл урвуу хувьсал байгаа эсэхийг тодорхойлж, тэдгээрийг алгебрын болон графикийн аргаар илэрхийлэх.
- Бодит хариу өгөгдсөн тохиолдолд өгөгдлийг цуглуулж, шинжлэх, тохирох муруйн тэнцэтгэлийг тодорхойлж, шугаман болон квадрат функцийг таамаг дэвшүүлэх.

Гүнзгийрүүлсэн Алгебр I хичээлээр сурагчид дээрх сэдвүүдийг илүү гүнзгийрүүлэн суралцах болно. Түүнчлэн сурагчид дараах нэмэлт сэдвээр суралцана:

- Үнэмлэхүй тоо бүхий тэнцэтгэл болон үл тэнцэтгэл
- Язгуур илэрхийлэл болон тэнцэтгэл
- Рациональ илэрхийлэл болон тэнцэтгэл
- Графикийн болон алгебрын аргаар квадрат функцтэй илүү их ажиллах
- Нэмэлт функцуудыг судлах

- Илтгэгч зэргээр өсөлт ба буурал
- Пифагорын онол
- Зай ба голч цэг
- Сэлгэлт, комбинаци, нийлмэл үйл явдлууд, асуулга болон түүвэр зэрэг магадлал.

*Тайлбар: Энэ хичээлээр ахлах сургуулийн кредит олгогдох бөгөөд арлах сургууль төгсөхөд тавигдах шаардлагыг хангаж, ахлах сургуулийн голч дүнд нөлөөлж, ахлах сургуулийн дүнгийн жагсаалтад бичигдэнэ. Ахлах сургуулийн кредитийн талаарх 56-р хуудас, APS PIP I-11.6.30 зэргийг харж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.*

## Геометр, гүнзгийрүүлсэн (13141)

Гүнзгийрүүлсэн геометр нь гүнзгийрүүлсэн Алгебр I хичээлийг амжилттай дуусгасан бүх сурагчдад зориулсан математикийн эрчимжүүлсэн үндсэн хичээл юм.

Геометрийн хичээлийг судлах Виржиния мужийн стандартыг (SOL) хангах агуулгын зарим тодорхой жишээг дурдвал:

- Хэд хэдэн таамаглал болон нөхцөлүүд өгөгдсөн тохиолдолд логиктой аргументын үнэн зөвийг шүүн тунгаахад, аргумент дэвшүүлэхэд дедукцийн арга ашиглана.
- Хөндлөн шугамаар огтлолцсон хоёр шулуунаас үүссэн өнцгүүд хоорондын харилцааг ашиглан хоёр буюу түүнээс дээш шулуун параллель болохыг баталж, бодит бодлогын хариуг олох.
- Тэгш хэм болон хувиргалт ашиглан бодлого бодох, үүнд зай, голч цэг, налуу болон координатын аргыг тайлбарлах зэрэг хэрэглээ хамаарна.
- Төрөл бүрийн байгууламжийг барих болон үндэслэлийг гаргах.
- Гурвалжны талуудын урт болон/ эсхүл өнцгийн хэмжээсний мэдээлэл өгөгдсөн нөхцөл бүхий бодлого бодох.
- Хоёр гурвалжин ижил эсхүл төстэй болохыг батлах.
- Зөв гурвалжинтай бодлого бодох, үүнд пифагорын онол, адил талт тусгай зөв гурвалжин болон тригонометрийн харьцаа зэрэг хамаарна.
- Дөрвөн талтын шинж чанарыг ашиглан нягталж, бодлого бодох.
- Олон өнцөгтийн дотоод өнцгийг оролцуулсан бодит бодлого бодох.
- Тойргийн шинж чанартай холбоотой бодлого бодох.
- Тойргийн тэнцэтгэлтэй холбоотой бодлого бодох.
- Гурван хэмжээст геометрийн дүрсийн гадаргуун талбай болон эзлэхүүнийг ашиглах.

Стандарт агуулга нь математик суралцахтай холбоотой дараах үйл явцын зорилгыг дэмжихэд чиглэгдсэн: Асуудал шийдвэрлэх, харилцаа, холбоо, төлөөлөл ба учир шалтгаан.

*Тайлбар: Энэ хичээлээр ахлах сургуулийн кредит олгогдох бөгөөд ахлах сургууль төгсөхөд тавигдах шаардлагыг хангаж, ахлах сургуулийн голч дүнд нөлөөлж, ахлах сургуулийн дүнгийн жагсаалтад бичигдэнэ. Ахлах сургуулийн кредитийн талаарх 56-р хуудас, APS PIP I-11.6.30 зэргийг харж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.*

## **БАЙГАЛИЙН УХААН**

### **8-р ангийн Физикийн шинжлэх ухаан (14125)**

8-р ангийн Физикийн шинжлэх ухааны хичээлээр сурагчид байгалийн шинжлэлийн ойлголтоо гүнзгийхүүлж, биет юмсын бүтэц зохион байгуулалт болон эрчим хүчний шинж чанарын талаарх ойлголт авна. Физикийн шинжлэх ухааны стандарт нь шинжлэх ухааны мөн чанарын талаарх сурагчийн ойлголтыг нэмэгдүүлэхэд үргэлжлүүлэн анхаарах болно. Шинжлэх ухаанч хандлага гэдэг нь ажиглалт, туршилт, загвар, нотолгоо ба системчилсэн ажиллагааг ашиглан байгалийн үзэгдлийг тайлбарлах явдал юм. Шинжлэх ухааны мөн чанар гэдэгт шинжлэх ухааны тайлбарууд нь логик сэтгэлгээнд суурилсан, нотолгооноос хамааралтай, ажиглалт, таамаглал болон туршилтын нотолгоотой нийцэх, учир шалтгаантай шүүмжлэлд нээлттэй, шинжлэх ухааны шинэ нотолгоо гарахад сайжрах болон өөрчлөгдөх боломжтой байдаг гэсэн ойлголтууд багтана. Шинжлэх ухааны мөн чанар нь байгалийн юмс үзэгдлийн тайлбарыг өгөх бөгөөд аливаа үйл ажиллагаанаас гарч болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглах боломжтой хэдий ч *бүх асуултад хариулах бол боломжгүй юм.* Сурагчид шинжлэх ухааны болон инженерчлэлийн ойлголтыг дараах арга замаар үзүүлэх болно: асуулт асуух, асуудал тодорхойлох, төлөвлөх, судалгаа явуулах, тайлбарлах, дүн шинжилгээ хийх, өгөгдлийг үнэлэх, дүгнэлт болон тайлбар боловсруулах ба шүүмжлэх, загвар бүтээх болон ашиглах, мэдээлэл олж авах, үнэлж дүгнэх, бусдад илэрхийлэх. Түүнчлэн сурагчид бие даан туршилтын эсвэл инженерчлэл загварын төсөл гүйцэтгэнэ.

Сурагчид дараах зүйлсийг судалж ойлгох болно:

- биет зүйлс атомоос бүтдэг,
- биет зүйл шинж чанартай бөгөөд тэдгээр нь химийн болон физик урвалын үед хадгалагддаг,
- үелэх систем нь элементүүдийг атомын бүтцээр нь зохион байгуулж байрлуулсан загвар,
- эрчим хүч хадгалагддаг,
- эрчим хүчний хөдөлгөөнд долгион чухал ач холбогдолтой,
- цахилгаан соронзон цацраг идэвх шинж чанартай,

- ажил, хүч ба хөдөлгөөн харилцан хамааралтай,
- цахилгаан болон соронзонгийн үндсэн зарчмууд бий.

## **НИЙГЭМ СУДЛАЛ**

### **Дэлхийн газар зүй (12210)**

Энэ хичээлээр дэлхийн бүс нутгуудад онцгой ач холбогдол өгч, дэлхийн хүмүүс, газар болон орчныг судална. Тус хичээлийн мэдлэг, чадвар, үзэл баримтлал нь дэлхий хүн ам, соёлын шинж чанарууд, газар нутгийн бүтэц, уур амьсгал, эдийн засгийн хөгжил, нүүдэллэх болон оршин суух хэв маяг зэрэгт төвлөрсөн байна. Газар зүйн орон зайн ойлголтыг хүмүүс болон тэдний амьдарч буй орчин хоорондын харилцааг судлахад ашиглана. Газар зүйн нөөц ашиглан, сурагчид асуулга, судалгаа болон технологийн ур чадварыг ашиглан газар зүйн асуултууд асууж, хариулна. Сурагчдын газар зүйн ойлголтыг ойлгох, ашиглах болон ур чадвараа өдөр тутмын амьдралдаа ашигладаг болоход онцгой анхаарал хандуулна.

8-р ангийн сэдэв бол харилцаа юм. Зорилго нь хүмүүс хоорондын харилцаа болон бүс нутгууд дахь орчинтойгоо тэдний харилцах харилцаанд төвлөрнө, тухайлбал, Африк, Антарктик, Ази, Австрали, Төв Америк, Кариб, Европ, Ойрх Дорнод, Хойд Америк, Өмнөд Америк болон хуучнаар Зөвлөлт Холбоот Улс. Хичээлийн агуулга нь байршил, газар, хүн ба орчны харилцаа, хөдөлгөөн ба бүс нутаг зэрэг гол ойлголтуудын хүрээнд явагдана.

Сурагчид дараахад суралцана:

- Газар зүйн дүн шинжилгээ хийх чадварт суралцах.
- Газрын зураг, бөмбөрцөг, фото зураг болон зураг ашиглах.
- Физикийн болон экологийн зарим үйл явц дэлхийн гадаргууг хэрхэн тодорхойлдог болохыг шинжлэх.
- Бүс нутгийн ойлголтыг хэрэглэх.
- Латин Америк, Кариб, Европ, Америкийн Нэгдсэн Улс, Канад зэрэг дэлхийн бүс нутгуудын физик, эдийн засаг, нийгэм, соёлын шинж чанарыг олж, шинжлэх.  
Мөн Хойд Африк, Зүүн Өмнөд Ази, Зүүн Ази, Австрали, Номхон далайн арлууд болон Антарктидыг шинжлэх.
- Шилжин суурьших хэв маяг болон байгалийн болон хөрөнгийн нөөцийн байршлын хувьд хүн амын тархалт, өсөлтийн хувь хэмжээ, шинж чанарыг харьцуулах болон жиших.
- Хүний нүүдэл болон соёлын харилцааны өнгөрсөн болон өнөөгийн чиг хандлагыг нийгэм, эдийн засаг, улс төр болон эдийн

засгийн хүчин зүйлсийн нөлөөллийн хүрээнд шинжлэх.

- Байгалийн, хүний болон хөрөнгийн нөөцийг олж тогтоон, тэдгээрийн ач холбогдлыг тайлбарлах.
- Хөгжилтэй болон хөгжиж буй улсуудыг ялгаж, эдийн засгийн хөгжлийн түвшнийг амьдралын стандарт болон чанартай холбон ойлгох.
- Олон улсын хэв маяг болон эдийн засгийн харилцан хамаарлын сүлжээг шинжлэх.
- Зөрчил болон хамтын ажиллагааны хүч дэлхийн гадарга дахь хуваагдал болон хяналтад хэрхэн нөлөөлж буйг шинжлэх.
- Хот байгуулалтын хэв маягт дүн шинжилгээ хийх.
- Газар зүй ашиглан өнгөрснийг тайлбарлаж, өнөөг ойлгон, ирээдүйд зориулан төлөвлөх.

*Тайлбар: Энэ хичээлийг авч буй сурагчид Дэлхийн газар зүйн стандарт суралцах үнэлгээний шалгалт өгнө. Энэ хичээлээр ахлах сургуулийн кредит олгогдох бөгөөд арлах сургууль төгсөхөд тавигдах шаардлагыг хангана. Дэлгэрэнгүй мэдээллийг 56-р хуудаснаас авна уу.*

## **8-р АНГИЙН СОНГОН СУРАЛЦАХ БОЛОН ҮНДСЭН БУС ХИЧЭЭЛҮҮД**

Зургаа болон долоодугаар ангид танин мэдэхүйн болон сонгон суралцах төрөл бүрийн хичээлүүд судалснаас 8-р ангийн сурагчид өөрсдөд нь ялангуяа сонирхолтой хоёр эсхүл түүнээс их сонгон суралцах хичээл судлах боломжтой болно. Аль хичээлүүдийг хослуулж, хавсрах боломжтой эсэх нь тухай сургуулийн хуваариас хамаарна. Хичээлийн дараах АСТ II хөтөлбөрийн хүрээнд багтсан сонгон суралцах хичээлүүдэд сурагчид мөн хамрагдах боломжтой. (6-р хуудсыг харна уу).

### **УРЛАГИЙН БОЛОВСРОЛ**

#### **Гитар, бүтэн жил (19246)**

Сурагчид дараах ур чадварт суралцана

- Хөгжмийн зэмсгийг зөв зохистой арчилж, зөв барьж сурах.
- Зөв тоглох техник үзүүлж, зөв аялгуу гаргах.
- Хөглөгч ашиглан хөгжмийн зэмсэг хөглөж сурах.
- Гитарын үндсэн ойлголт авч, хөгжмийн стандарт тэмдэглэгээг уншиж сурах.
- Ноотны анхдагч барилтууд, ая тоглох.
- Баруун гарын үндсэн техник болон аялгуут хэв маягаар тоглох.
- Тоглолт хийх замаар сурснаа харуулах, ингэхдээ цөөхүүд эсхүл гитарын чуулгатай хамтарч тоглох.

Сурагчид сурах бичиг болон акустик (ардын эсхүл сонгодог) гитар худалдаж авах ёстой. Сургуулийн эзэмшлийн цөөн тооны хөгжмөөс түрээслэн хэрэглэх боломжтой.

#### **Анхан шатны дуу хөгжим, Төгөлдөр хуур дарах Улирал (19252)**

Улирлаар судлах уг хичээлээр сурагчдад төгөлдөр хуурын үндсэн ур чадваруудыг заана. Сурагчид хөгжим тоглох анхан шатны түвшний SOL-ыг хангахын зэрэгцээ цөөн хэдэн өөр стандартуудыг мөн хангана. Сурагчдаас төгөлдөр хуур эсхүл даралтат хөгжим авахыг шаардахгүй. Сургуулиас цахилгаан даралтат хөгжим өгөх бөгөөд энэ нь сургуульдаа үлдэнэ.

Сурагчид дараах ур чадварт суралцана

- Төгөлдөр хуурын үндсэн ур чадварт суралцах.
- Хялбар ая, аялгуу уншиж, тоглож сурах.
- Хөгжмийн нот, тэмдэглэгээ уншиж, тоглож сурах.
- Хэд хэдэн төрлийн ритмийг ялгаж, тоглож сурах.
- Гишгүүр ашиглах үндсэн техникт суралцах.

#### **Хөгжмийн зэмсэг**

Анги тус бүрийн зорилтыг доор зааж өгсөн бөгөөд эдгээр зорилтоос гадуур өөр бусад зорилтууд байж болно. Сургууль тус бүрд сурагчийн чуулга өөрийн гэсэн онцлог нэртэй байж болно.

*Дунд шатны хамтлаг, Хичээлийн бүтэн жилд (19201) сурагчид дараахад суралцана:*

- Анхан шатны хамтлаг хичээлээр олж авсан мэдлэгтэй элсэн орох (Бага сургуулийн эсхүл 6-р ангийн Анхан шатны хамтлаг).
- Хөгжмийн тэмдэглэгээ, нийлмэл метр, хуваагдал, түлхүүрийн тэмдэглэгээ болон хэд хэдэн нэмэлттэй зэрэг нотыг ойлгож, хариу үйлдэл хийх.
- Нэг хагас октав дээр тоглох ур чадвар эзэмших буюу анхан шатны онолын эхлэл (цохиур хөгжим) тавьж, эдгээр ур чадварыг чуулгын нэгэн гишүүний хувьд ашиглана.
- Сонсголоороо хөгжмийн зэмсэг хөглөж сурна.
- 2-оос 4 хэмжигдэхүүн урттай хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Хурд, дуудлага, хэв маягийн өөрчлөлт оруулан удирдаж буй удирдаачид хариу үйлдэл хийх.
- I ангийн уран зохиол, түүний дотор зохимжтой бол ганцаарчилсан тоглолт хийх зэргээр сурсан мэдсэнээ тоглолт, үзүүлбэрээр харуулах.
- Концертын зохиолоос хоёр анги доогуур түвшинд хараагаар унших.

*Ахисан шатны хамтлаг, Хичээлийн бүтэн жилд (19228) сурагчид дараахад суралцана:*

- Дунд анхан шатны хамтлаг хичээлээр олсон ур чадвар бол элсэн орох.
- Хөгжмийн нот ойлгож тоглох, ингэхдээ найруулгыг онцгой анхаарна.
- Хоёр октав дээр тоглох ур чадвар эзэмших буюу төрөл бүрийн зарчмыг (цохиур хөгжим) ойлгож, чуулгын нэгэн гишүүний хувьд эдгээр ур



чадварыг хоршил болон тэнцвэрт мэдрэмжтэйгээр ашиглана.

- Түлхүүрийн тэмдэглэгээг тодорхойлж, сонгосон мажор болон минорт харгалзах даралтуудыг тоглоно.
- Олон цохиур, хэлний олон байршил, болон хурууны даралтын байрлалууд оролцуулан зохих түвшинд ахисан шатны арга техникээр тоглох.
- 4-өөс 8 хэмжигдэхүүн урттай хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Өргөн хүрээний хэв маяг ашиглан тоглолт болон илтгэлүүдээр сурснаа харуулах.
- Концертын чадвараас хоёр анги доогуур түвшинд хараагаар уншина.

**Анхан шатны оркестр**, Хичээлийн бүтэн жилд (19237) ангид сурагчид дараахад суралцана:

- Хөгжмийн зэмсэг болон нумыг зөв зохистой арчилж, зөв барьж сурна.
- Зөв техниктэй тоглож буйг харуулах, зөв аяыг гаргах, үүнд пиззикато дуу гаргах, нумыг хөрөөдөх үндсэн техник зэрэг нь орно.
- Зөв өнгө, хэмнэл, хугацаа, түлхүүр, хэмнэл болон илэрхийлэх тэмдэглэгээ зэргээр хөгжим унших үндсэн ойлголттой болох ба холбогдох хөгжмийн тоглолтыг зөв ойлгох.
- Нээлттэй чавхдас дээр (нэгдүгээр байрлалд) нэг октав болон давхар зогсолт тоглох ур чадвар эзэмших, эдгээр чадварыг чуулгын гишүүний хувьд ашиглах.
- Хөглөгч ашиглан хөгжмийн зэмсэг хөглөж сурах.
- 1-ээс 2 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Метроном ашиглан тогтсон хэмнэлээс тоглох, мөн удирдаачийн хөдөлгөөнөөр тоглох.
- Зохих тоглолт, үзүүлбэрийг хийх замаар сурснаа харуулах.

**Дунд шатны оркестр**, Хичээлийн бүтэн жилд (19242) сурагчид дараахад суралцана:

- 8-р ангийн Анхан шатны оркестр хичээлээр олсон ур чадвартайгаар элсэн орох буюу дунд шатны оркестрын шалгуурыг хангасан байна.
- Хөгжмийн тэмдэглэгээ, үүний дотор төрөл бүрээр хийлдэж, хуурдах арга техник ашиглах, нийлмэл метр, хуваагдал болон хоёр диеттэй түлхүүрийн тэмдэглэгээг хүртэл ойлгож, тоглох.
- Нэг хагас октав дээр өргөтгөл ашиглан, нумын жин, хурд, хүрэлцээг тохируулан тоглох чадвартай болох; эдгээр чадварыг чуулгын нэг гишүүний хувьд ашиглаж харуулах.
- Сонсголоороо хөгжмийн зэмсэг хөглөж сурна.
- 2-оос 4 хэмжигдэхүүн урттай хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Хурд, дуудлага, хэв маягийн өөрчлөлт оруулан удирдаж буй удирдаачид хариу үйлдэл хийх.

- Тоглолт болон илтгэлүүдийг гүйцэтгэх замаар сурснаа харуулах, зохимжтой тохиолдолд гоцлол тоглолт хийх.
- Концертын зохиолоос хоёр анги доогуур түвшинд хараагаар унших.

**Ахисан шатны оркестр**, Хичээлийн бүтэн жилд (19243) сурагчид дараахад суралцана:

- 8-р дунд анхан шатны оркестр хичээлээр олсон ур чадвартай бол элсэн орно.
- Хөгжмийн нот ойлгож тоглох, ингэхдээ найруулгыг онцгой анхаарна.
- Хоёр октав дээр тоглох ур чадвар эзэмших, ингэхдээ шилжилтээ илүү цэвэр болгож, эдгээр ур чадварын чуулгын гишүүний хувьд ашиглан харуулна.
- Түлхүүрийн тэмдэглэгээг тодорхойлж, сонгосон мажор болон минорт харгалзах даралтуудыг тоглоно.
- Илүү ахисан шатны арга техник ашиглан тоглох, ингэхдээ тухайлбал, тохиромжтой тохиолдолд, вибрато, зэрэгцээ хөрөөдөх, спиккато зэргийг ашиглах.
- 4-өөс 8 хэмжигдэхүүн урттай хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Өргөн хүрээний хэв маяг ашиглан тоглолт болон илтгэлүүдээр сурснаа харуулах.
- Концертын чадвараас хоёр анги доогуур түвшинд хараагаар уншина.

**Жааз хамтлаг, Бүтэн жил (19239)**

Жаазын блюз, пентатоник болон бебоп төрлүүд, даралт, даралтын тэмдэглэгээнүүд, даралтын өөрчлөлтүүд зэрэг үндсэн элементүүдийг суралцах: тэдгээрт үндэслэл гоцлол тоглох ойлголтыг авах. Томоохон хамтлагт болон/эсхүл жижиг хоршил хэлбэрээр тоглолт хийх.

**Театрын урлаг-Драм**

**Бүтэн жил (11394)**

**Улирал (11393)**

Сурагчид дараахад суралцана:

- Зохиол бичигдсэн болон бичигдээгүй материалыг бэлтгэлгүйгээр бүтээх.
- Дизайны элементүүд ашиглан орчин бүрдүүлэх.
- Театрын түүхийн элементүүдийг судлах.
- Продакшны сэтгэл хөдөлгөсөн элементүүдэд дүн шинжилгээ хийж, тэдгээрийг тайлбарлахад санал нэгдэх.
- Жүжгийн арга барилуудыг ашиглаж, дүр бүтээх.
- Хувийн чадвар болон бүтээлч тэмүүллийг үнэлэхэд шударга хандлага төлөвшүүлэх.

**Дүрслэх урлаг I**

**Бүтэн жил (19040)**

**Улирал (19041)**

Сурагчид дараахад суралцана:

- Урлагийн бүтээл бүтээхийн тулд дизайны зарчмууд болон зургийн элементүүдийг ашиглах.

- Төрөл бүрийн арга техник болон үйл явцыг ашиглан гурван хэмжээт бүтээл бүтээх.
- Төрөл бүрийн урлагийн бүтээлд өөрийн хувийн тайлбар хийх, шүүмж өгөх.
- Зургийн нэр томьёо ашиглан урлагийн эцсийн бүтээлийг шинжилж, шүүмжлэх.
- Урлагийн бүтээл хийхдээ ёс зүйтэй шийдвэр гаргах, түүнийг тайлбарлах.

## **Дүрслэх урлаг II** **Бүтэн жил (19117)** **Улирал (19115)**

Сурагчид дараахад суралцана:

- Дизайныг зарчмууд болон зургийн элементүүдийг портфолиод хэрэглэнэ.
- Зургийн хавтгай дахь сүүдэр болон төрөл бүрийн хэлбэрийн харагдац ашиглан зузааныг илэрхийлнэ.
- Дизайны зарчмуудыг нэгтгэн хувийн урлагийн бүтээл туурвиж, чанарыг сайжруулна.
- Урлагийн элементүүд болон дизайны зарчмууд ашиглан орчин болон илэрхийллийг бий болгоно.
- Урлагийн бүтээл хийхдээ ёс зүйтэй шийдвэр гаргана.
- Зургийн нэр томьёо ашиглан урлагийн эцсийн бүтээлийг шинжилж, шүүмжлэх.

## **Дуу хөгжим**

Анги тус бүрийн зорилтыг доор зааж өгсөн бөгөөд эдгээр зорилгоос гадуур өөр бусад зорилтууд байж болно. Сургууль тус бүрд сурагчийн чуулга өөрийн гэсэн онцлог нэртэй байж болно.

## **Анхан шатны хоор, Бүтэн жил (19261)**

Тухайн улиралд (19264) сурагчид дараахад суралцана:

- Сайн аялгуу гаргахын тулд биеийн зөв байрлал, амьсгалын зөв хяналт, ам зөв барихад суралцах.
- Зөв өнгө, хэмнэл, хугацаа, түлхүүр, хэмнэл болон илэрхийлэх тэмдэглэгээ зэргээр хөгжим унших үндсэн ойлголттой болох ба холбогдох хөгжмийн тоглолтыг зөв ойлгох.
- Диатоник өнгөний систем ашиглан зөв өнгө гаргах, чуулганд өөрийн хэсгийг зөв барих чадвар хөгжүүлэх.
- 1-ээс 2 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Удирдаачид хариу үйлдэл үзүүлэх.
- I эсхүл II ангийн түвшинд зохих тоглолт болон илтгэлүүдийг гүйцэтгэх замаар сурснаа харуулах.

## **Дунд шатны хоор, Бүтэн жил (19274) Улирал (19275)**

Сурагчид дараахад суралцана:

- *Анхан шатны хоор* хичээлээр олж авсан ур чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлэх.
- Соль түлхүүрийн нотын тэмдэглэгээг ойлгож хэрэглэх.

- Өсвөр насны дуу хоолойны өөрчлөлтийн талаар сурч, тэдгээр өнгө болон царааны өөрчлөлтөд хэрхэн дасан зохицох талаар мэдэж авах.
- Хоёр болон гурван хэсэг, капелла дуулах үеэр хэрхэн өөрийн хэсгийг бие даан барих чадварт суралцан хөгжүүлнэ.
- Нотын барилт дотроо хэрхэн өнгийг зөв сонсож, гаргах чадвараа хөгжүүлнэ.
- 2-оос 4 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Удирдаачийн фермат, хурдасгах болон удаашрах хөдөлгөөнийг ойлгож, гүйцэлдүүлэх.
- II болон III ангийн тохирох уран зохиол, түүний дотор зохимжтой бол ганцаарчилсан тоглолт хийх зэргээр сурсан мэдсэнээ тоглолт, үзүүлбэрээр харуулах.
- I түвшинд хараагаар унших.

## **Ахисан шатны хоор, Хичээлийн бүтэн жил (19285)** сурагчид дараахад суралцана:

- Соль түлхүүр болон басс түлхүүрийн аль алины нотын тэмдэглэгээг ойлгож дуулна.
- Өргөн цараагаар болон илүү бие даасан байдлаар дуулах чадвараа хөгжүүлж, уг чадварыг чуулгын нэг гишүүний хувьд ашиглан харуулна.
- Гурваас дөрвөн хэсэгт дууны хувьд капеллад нийцүүлэн өнгөө цэвэр гаргах чадвараа хөгжүүлнэ.
- 4-өөс 8 хэмжигдэхүүн урттай энгийн хялбар хэмнэлтэй эсхүл аялгуут ая бүтээх.
- Хурд, дуудлага, хэв маягийн өөрчлөлт оруулан удирдаж буй удирдаачид хариу үйлдэл хийх.
- III болон IV ангийн тохирох уран зохиол, түүний дотор зохимжтой бол ганцаарчилсан тоглолт хийх зэргээр сурсан мэдсэнээ тоглолт, үзүүлбэрээр харуулах.
- Концертын зохиолоос хоёр анги доогуур түвшинд хараагаар унших.

## **БИЗНЕС, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ**

### **Компьютерын хэрэглээ ба интернэт технологиуд**

#### **Бүтэн жил (13107)**

#### **Улирал (13106)**

Энэ хичээлийг үр дүнд хөтлөгдсөн арга барил ашиглан жинхэнэ бодит амьдрал дээрх ур чадвараа хөгжүүлэх сурагчдад зориулсан. Сурагчид дижитал иргэншил, компьютерын үндсэн үйлдлүүд, шивэх, программ хангамжийн хэрэглээ (word боловсруулах, тооцоолох, мультимедиа хэрэглүүрүүд болон мэдээллийн сан), болон ажил мэргэжил судлах талаар суралцана. Энэ хичээл хичээлийн хөтөлбөрийн бүхий л хэсэгт хэрэглэгдэх ур чадварыг дэмжиж, сургууль, бизнес болон хувийн амьдралд ашиглагдах 21-р зууны ур чадварт холбогдох бэлтгэл болно.

Сурагчид дараахад суралцана:

- Дижитал технологиудыг хэрэглээг тодорхойлон, үзүүлж, мэдээллийг боловсруулахад тэдгээр нь хэрхэн ашиглагддаг болохыг тайлбарлана.

- Компьютер хэрхэн бусад тооцоолох систем болон төхөөрөмжүүдтэй харилцдаг болохыг тайлбарлаж, программ хангамж болон техник хангамж хамтдаа хэрхэн цахим үүрэг даалгавар гүйцэтгэдэг тухай болон программ хангамжийг хэрхэн хөгжүүлж, шинэчлэн сайжруулдгийг тайлбарлана.
- Компьютерын үйлдлийн системийг ойлгож, улмаар Windows, түүний дотор файл болон дискийг удирдах.
- Системийн тохиргоог хэрхэн өөрчлөх болон аппликейшнүүдийг хэрхэн суулгах буюу устгахыг тодорхойлно.
- Бичиг баримт үйлдэх, форматлах, засварлах, шинэчлэх замаар шивэх ур чадварыг хэрэглэнэ.
- Зохих хэрэглүүрийг ашиглан өгөгдлийн сан, тооцоолох хуудас болон илтгэлийн хуудас төлөвлөн, боловсруулна.
- Э-мэйл болон э-мэйл “netiquette” протоколыг зохих ёсоор хэрэглэж сурна.
- Төрөл бүрийн интернэт хайлтын хөдөлгүүр болон порталууд ашиглаж харуулна.
- Компьютерын шинжлэх ухаан зэрэг төрөл бүрийн ажил мэргэжил дэх технологийн хэрэглээг судална.
- Компьютер хэрэглүүр, интернэт технологиуд болон компьютерын технологиуд (заавал биш) чиглэлээр үндэсний хэмжээнд танигдсан салбарын гэрчилгээ болох Интернэтийн үндсэн компьютерын гэрчилгээ (IC3) авахад бэлтгэнэ.

## Дижитал оролтын технологиуд

### Бүтэн жил (16607)

#### Улирал (16617)

Энэ хичээлээр шинэ тутам гарч ирж буй оролтын төхөөрөмжүүд (тухайлбал, яриа болон гар бичлэг таних программ хангамж, таблет, үүлэн тооцооллын аппликейшнүүд, чихэвч/микрофон, сканер, дижитал зургийн аппарат, хөдөлгөөнт төхөөрөмж, компьютер систем) зэргийг танилцуулж, өдөр тутам ажлын байранд хэрэглэгддэг стандарт хэрэглээ болж буй хэрэгслийг ашиглахад сурагчдыг бэлтгэнэ.

Сурагчид дараахад суралцана:

- Товшин шивэх арга техникээ хөгжүүлэн оновчтой бөгөөд хурдтай шивэх чадварт суралцана.
- Word боловсруулалтын программ хангамж, түүний дотор десктоп эх бэлтгэлийн бүхий л үзүүлэлт, ур чадварыг эзэмших, дадлага хийх.
- Хичээлд зориулан баримт бичиг боловсруулахдаа word боловсруулалтын программ хангамж ашиглах, бичих болон засварлах чадвараа сайжруулах.
- Төрөл бүрийн баримт бичиг үйлдэх, форматлах дадлага хийх. Үүнд бизнесийн болон хувийн захидал, дугтуй, графикууд, тайлан, улирлын ажил болон гэмдэглэл багтана.
- Төрөл бүрийн ажил мэргэжлийн судалгаа хийж, анкет бэлтгэх болон ярилцлага хийх ур чадвар

зэрэг ажлын байранд тэнцэх хувийн ур чадваруудын талаар ойлголт авах.

- Америкийн эдийн засгийн систем дэх бизнес эзэмшил, бизнесийн чиг үүрэг зэрэгтэй танилцах.
- Хувийн санхүүгээ хянах, чек дансныхаа баланс гаргах, төлбөрийн чекийг тайлбарлах, даатгал болон автомашин худалдаж авах, боломжийн нөхцөлтэй орон байр сонгох, хөрөнгө оруулах болон хэрэглэгчийн холбогдолтой бусад ур чадвар.
- Шинэ тутам гарч ирж буй технологийг ажлын байранд ашиглах талаар хэлэлцэх (тухайлбал, дэлгэц дээр бичих, яриа таних, iPad, болон хөдөлгөөнт технологи).

## Компьютерын програмчлал ДС (16640)

### Бүтэн жил, нэг кредит

Компьютерын програмчлалын (Код бичих) хичээл нь сурагчдын код бичих, тооцоолон бодох, санхүүгийн болон дижитал мэдлэг, ур чадварыг сайжруулахын зэрэгцээ компьютерын шинжлэх ухааны онол, дизайны ойлголтуудыг өгнө. Сургалтын хөтөлбөрт Java бүхий Python Alice, Java Scratch, HTML, Java Scripting зэрэг програмчлалын хэл ашиглан код бичих, гар утасны апп болон цахим хуудас хөгжүүлэх багтана. Нэгдсэн цогц төсөл нь “бодит амьдрал дээрх” математик болон санхүүгийн боловсролыг ашиглахад чиглэгдэнэ.

*Тайлбар: Энэ хичээлээр ахлах сургуулийн кредит олгогдох бөгөөд арлах сургууль төгсөхөд тавигдах шаардлагыг хангана. Дэлгэрэнгүй мэдээллийг 56-р хуудаснаас авна уу. “С” эсвэл түүнээс дээш үнэлгээтэй энэ хичээлийг дүүргэсний дараа сурагчид хос бус элсэлттэй Компьютерын програмчлалын гүнзгий эсвэл AP Компьютерын шинжлэх ухааны үндэс хичээл уруу дэвшиж болно.*

## АНГЛИ ХЭЛ

### 8-р ангийн Унших чадварын хичээл

#### Бүтэн жил (11121)

#### Улирал (11125)

*Багш болон/эсхүл зөвлөхийн санал болгосноор*

8-р ангийн Унших чадварын хичээл нь сурагчид уншиж бичих чадвараа нэмэгдүүлэхэд тусгайлан чиглэсэн заавар авч, нэмэлт цаг зарцуулах сонгох Англи хэлний хичээл юм. Багш нар унших чадварт холбогдох дараах зүйлүүдэд голчлон анхаарна: авиа зүй, авиабар, түгдрэхгүй унших, үгсийн сан, уншсанаа ойлгох. Эдгээр нэн чухал бүрэлдэхүүн хэсгийн зэрэгцээ үе үе шалгалт авч сурагчийн зорилгот түвшинд хүрэхэд гаргасан ахицыг хэмжинэ. Сурагчид бие даан болон багаараа дараах зорилгоор ажиллана:

- идэвхтэй унших стратегиудыг сурч, дадлага хийх
- зохион байгуулалттай унших дадлага хийх (илэрхий, кодчилох/код тайлах системтэй үг дээр ажиллах)

- унших болон бичих тэсвэр хатуужил суух, чөлөөтэй эзэмших
- үгсийн сангаа баяжуулах
- ойлголтоо нэмэгдүүлэх
- унших туршлагаа өргөжүүлэх.

### **Сэтгүүл зүй, Бүтэн жил (11201)**

Энэхүү сонгон суралцах хичээлээр сурагчид сонин эсхүл мэдээний нэвтрүүлэг хийнэ. Өөрсдийн бүтээлээр дамжуулан сурагчид сонин болон нэвтрүүлэг бичих болон найруулах чадвар эзэмшинэ.

Сурагчид дараахад суралцана:

- Сэтгүүл зүйн хэв маягуудыг сурч, ашиглах.
- Хэвлэмэл болон/эсхүл телевизийн нэвтрүүлгийг агуулга болон техникийн чанарын хувьд шинжлэх.
- Спортын, мэдээний, сэтгэгдлийн зэрэг нийтлэлүүд бичих болон/эсхүл сурталчилгаа, олон нийтийн үйлчилгээний зар, эсхүл мэдээний шоу зэрэг нэвтрүүлэг бэлтгэх.
- Хянах, засварлах, зураг, хуулбар, онцлох өгүүлбэр зэргийг байрлуулах, үсэг өрөх, эцсийн бүтээгдэхүүн гаргах зэрэг сэтгүүл зүйн холбогдолтой төрөл бүрийн ажил хийж үзэх.

### **Төгсөлтийн альбом, Бүтэн жил (11209)**

Энэ хичээлээр сурагчид сургуулийн төгсөлтийн альбомыг бүтээнэ. Өөрсдийн бүтээлээр дамжуулан сурагчид хэвлэн нийтлэх бичилт болон нэвтрүүлэг найруулах чадвар эзэмшинэ.

Сурагчид дараахад суралцана:

- Хянах, засварлах, зураг, хуулбар, онцлох өгүүлбэр зэргийг байрлуулах, үсэг өрөх, эцсийн бүтээгдэхүүн гаргах болон түгээлт зэрэг сэтгүүл зүйн холбогдолтой төрөл бүрийн ажил хийж үзэх.
- Сэтгүүл зүйн хэв маягуудыг сурч, ашиглах.
- Хэвлэн нийтлэхэд тохиромжтой төрөл бүрийн нийтлэлүүд бичнэ.
- Нийтлэлийг хянан, засварлана.

### **ГЭР БҮР БОЛОН ХЭРЭГЛЭГЧИЙН ШИНЖЛЭХ УХААН**

#### **Амьдралын менежментийн чадвар**

#### **Бүтэн жил (18245)**

#### **Улирал (18244)**

Энэ хичээлээр гэр бүлийн дүрд тоглох, хүүхэд асрах, богино болон урт хугацааны зорилгоо үнэлэх болон ажил, амьдралын тэнцвэрийг хангах төрөл бүрийн арга техникийг үнэлэх зэрэг амьдралын туршлагауудыг тоглох замаар тунгаан бодох ур чадвараа сайжруулна. Сурагчид мөн түүнчлэн мультимедиа лабораторид бие даан төрөл бүрийн модуль хийж гүйцэтгэнэ.

Сурагчид дараахад суралцана:

- Цаг болон мөнгөний менежментийн сайн дадалд суралцана.

- Хэрэглэгчийн сонголтод нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжилнэ.
- Найз нөхөд болон гэр бүлийн гишүүдтэйгээ эергээр харилцана.
- Орчин үеийн машин төхөөрөмж ашиглан хувцас бүтээж, арчилна.
- Тэнцвэрт хоол хүнс бэлтгэж, сайн хүнс тэжээлийн ач холбогдлыг ойлгоно.
- Үндэсний хоол хүнс болон соёлын ялгааг мэдэрнэ.
- Ажлын орчныг цэвэр байлгаж хүнсийг аюулгүй хэрэглэх.
- Зөрчлийн хэрхэн зохицуулж, асуудлыг шийдвэрлэх талаар суралцана.
- Бага насны хүүхдүүдийг хэрхэн асран хамгаалах ур чадвар, дадлагыг эзэмшинэ.
- Бусадтай харилцах харилцаа, дотно харилцааг судална.
- Жорыг зөв зохистой ойлгож, ашигласнаар хүнсний бүтээгдэхүүнийг амжилттай үйлдвэрлэнэ.
- Ажил мэргэжил болон ахлах сургуулийн холбогдох хичээл сонголтыг судална.

### **Хувь хүний хөгжил (18210)**

#### **Бүтэн жил, нэг кредит**

Энэ хичээл нь эергээр өөрийгөө үнэлэх үнэлэмж бий болгох; гэр бүл, үе тэнгийнхэн болон өөрийн амьдарч буй дүүргийнхээ гишүүдтэй эрүүл харилцаа өрнүүлэх; стресс болон зөрчлийг удирдах; коллеж болон ажлын байранд гарахад бэлдэх. Сургалтын агуулга нь өөрийгөө үнэлэх үнэлэмж, үнэ цэнэ, шийдвэр гаргах болон зорилгоо тодорхойлох ур чадвар, хүн хоорондын болон гэр бүлийнхэнтэйгээ харилцах харилцаа% мэргэжил төлөвлөлт зэрэгт төвлөрнө.

Сурагчид дараахад суралцана:

- Үнэ цэнэ эрсдэлт зан төлөвт хэрхэн нөлөөлдгийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх.
- Жендерийн үүрэг, дадсан ойлголтын нөлөөг судлах.
- Сонголт болон сорилтын талаар ойлголтоо хөгжүүлэх.
- Эерэг харилцан яриа, зөрчил шийдвэрлэх ур чадварын дадлага хийх замаар зохистой зан төлөвт суралцах.
- Компьютержсон хүүхэддэй ашиглан эцэг эх байх симуляцид оролцох.
- Ажил хайх стратеги, ажлын байранд тавигдах шаардлага болон ажлын байран дахь дагалдан зэрэг хэлбэрээр карьер судлах.

### **МАТЕМАТИК**

#### **Алгебрын стратегиуд, Бүтэн жил (13125)**

Алгебрын стратегиуд нь Алгебр I хичээлд амжилттай суралцахад нэмэлт дэмжлэг шаардлагатай сурагчдад зориулсан сонгон суралцах хичээл. Энэ хичээлийг авч буй сурагчид тухайн агуулгын цаад утга санааг ойлгож, түүхэн мэдээллийг авч, материалыг илүү бүрэн дүүрэн ойлгож авна.

## **Математикийн стратегиуд 8-р анги**

### **Бүтэн жил (13118)**

#### **Улирал (13119)**

Стратегийн хичээл нь сонгон суралцах хичээл бөгөөд математикийн хичээлд хоцролттой байгаа сурагчдад зориулагдсан. Стратегийн хичээлээр сурагчид суурь мэдлэгээ бэхжүүлж, өгөгдлийг ойлгох аргачлалд суралцаж, үндсэн хичээлийн агуулгыг сайтар ойлгоход суралцана.

## **ТУСГАЙ БОЛОВСРОЛ**

### **Заах арга зүй, Бүтэн жил (10028)**

*Урьдчилсан шаардлага: Сурагчийг тусгай боловсролын үйлчилгээнд хамруулах шаардлагатай гэж дүгнэлт гарсан байх шаардлагатай*

Тусгайлсан боловсролын хөтөлбөр (IEP)-ийн дагуу тухайн сурагчид тусгайлан зориулж хичээл орох ба сурагчид олгох ерөнхий боловсролын шаардлагыг хангахад чиглэнэ. Түүнчлэн сонсох, бичих, зохион байгуулах болон ерөнхий суралцах чадварт онцгой анхаарал хандуулна.

### **Нийгэмших чадвар, Бүтэн жил (10023)**

*Урьдчилсан шаардлага: Сурагчийг тусгай боловсролын үйлчилгээнд хамруулах шаардлагатай гэж дүгнэлт гарсан байх шаардлагатай*

Нийгэмших чадварын хичээлээр дунд сургуулийн сурагч бусадтай зохистой нийгмийн харилцаанд ороход шаардлагатай ур чадварыг олж авч, дадлага хийх боломжтой. Бусадтай харилцах, өөр өнцгөөс харах, өөрийгөө дайчлах, багаар ажиллах, стресс болон бухимдлаа дарах аргачлал, нийгмийн харилцааны “бичигдээгүй хуулиуд” зэргийг суралцах ур чадварт багтаана. Хувийн зохион байгуулалт, өөрийгөө өмгөөлөх, хамгаалах зэрэг ур чадварууд мөн багтана.

## **СУРАГЧИЙН ДЭМЖЛЭГ**

### **Үндсэн дээр нэмэлт**

#### **Бүтэн жил (11129)**

#### **Улирал (11128)**

Хувийн зохион байгуулалт, тэмдэглэл хөтлөх, шалгалт өгөх болон сурагч илүү их амжилт олоход туслах бусад арга барилуудыг заах ерөнхий сургалтад энэ хичээл нь зориулагдсан.

Сурагчид дараахад суралцана:

- Хичээл давтах цагаа төлөвлөх
- Сонсох чадвараа сайжруулах арга барилд суралцах.
- Хичээл, сурлагын талаарх одоогийн хандлагадаа дүгнэлт хийж, юу илүү чухал болохыг тодорхойлж, зорилго тавьж, эерэг хандлага бий болгох.
- Уншиж ойлгох, санаж тогтооход суралцах арга барил, дадал чадварыг хэрэглэх.

## **ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ**

### **Робот зохион бүтээх технологи (18421)**

#### **Бүтэн жил, нэг кредит**

Сурагчид автоматжуулалтын систем, бичил процессор болон тэдгээрийг үйлдвэрлэл, тээвэрлэлт болон харилцаа холбооны системд хэрэглэх

хэрэглээний талаар судална. Хамрах сэдвүүдэд компьютер төхөөрөмж болон үйлдлийн систем, роботик, програмчлал, удирдлагын систем болон тэдгээр технологиудын нийгэм/ соёлд үзүүлэх нөлөөлөл хамаарна. Асуудал шийдвэрлэх үйл ажиллагаанууд сурагчдад дизайн гаргах, програмчлах болон компьютер системүүдтэй холбогдох сорил болдог. Сургалтын үйл ажиллагаанд роботик, компьютерын тусламжтай үйлдвэрлэл болон дизайн, цахилгаан механик төхөөрөмжүүдийг удирдах зэрэг нь багтана.

*Тайлбар: Энэ хичээлээр ахлах сургуулийн кредит олгогдох бөгөөд арлах сургууль төгсөхөд тавигдах шаардлагыг хангана. Дэлгэрэнгүй мэдээллийг 56-р хуудаснаас авна уу.*

## **Технологийн систем**

### **Бүтэн жил (18462)**

#### **Улирал (18463)**

Сурагчид технологийн систем хэрхэн ажилладаг талаар судалж, төрөл бүрийн техникийн салбарт бодит амьдрал дээр ашиглагддаг системийн эд ангиудыг таньж тогтоон, ангийн төсөлд зориулан системүүд зохион бүтээж, дизайн гаргаж, дүгнэнэ. Системийн загвар гаргаж, зохион бүтээж, түүний үр нөлөөг үнэлж дүгнэснээр сурагчид технологийн ертөнцийн асуудал болон боломжуудад хэрхэн хандвал зохих талаар ойлголт авна. Уг хичээлд сурагчид инженерингийн асуудалд шийдэх үйл явц болон дизайны программ хангамж ашиглан шийдэл гарган, үйлдвэрлэлийн үйл явцыг олон хэсэгт төслүүд бий болгоход ашиглах зэрэг үйл ажиллагаа багтана. Тухайлбал CO2 уралдааны машины төслийг дурдаж болно. Үүнд сурагчид AutoCAD ашиглан дизайн гаргаж; материал боловсруулах лабораторид загваруудаа өрөмдөж, зүсэж, зүлгэж, эцэслээд; хурд болон агаарын хоолойн шинжилгээ хийсэн.

Сурагчид дараахад суралцана:

- Систем гэж юу болохыг ойлгож авч, барилга, тээвэр, харилцаа холбоо болон электроникс зэрэг төрөл бүрийн салбар дахь тэдгээр системийн эд ангиуд, дэд системүүдийг таньж тогтооно.
- Өгөгдсөн симуляци сорилд инженерингийн асуудал шийдэх үйл явцыг ашиглан шийдэл олно.
- Системийг хамтдаа хүссэн үр дүнд хүрэх хоорондоо харилцан холбоотой эд ангиудын бүлэг гэж тодорхойлно.
- Оролт, боловсруулалт, гаралт, санал зэргийг сурах зорилгоор технологийн систем судалж, бүтээнэ.
- Алдаа илрүүлэх, судалгаа ба хөгжил, зохион бүтээл ба инновац, туршилт ба асуудал шийдэл зэргийн гүйцэтгэх үүргийн талаар ойлголттой болно.
- Байгууламж, тээвэрлэлт, тээврийн хэрэгсэл, график дизайн, 3D загвар, роботик эсхүл бусад холбогдох технологитой холбоотой инженерингийн сорилуудад шийдвэл олж, зохион бүтээнэ.

- Асуудал шийдвэрлэх, загвар урлахад багаар болон хамтран ажиллах дадлага хийнэ.
- Лаборатори дахь багаж, машин, төхөөрөмжийг аюулгүй, зөв ажиллуулна.
- Хамгийн шилдэг санааг сонгох зорилгоор янз бүрийн шийдлүүдийг судалж, үнэлж, дүгнэх.
- Хар зураг, олон хэмжээст зураг, компьютерын тусламжтай дизайн зэргийг ашиглан санаагаа ойлгуулах.

## ДЭЛХИЙН ХЭЛ

Арлингтоны улсын сургуулийн 7-12-р ангийн сурагчид дэлхийн хэл судлалаар ахлах сургуулийн дэлхийн хэлний кредит авах боломжтой. Дараагийн түвшинд үргэлжлүүлэхийн тулд бус хичээлд С эсвэл түүнээс дээш дүн авах шаардлагатайг анхаарна уу. Хичээл үе шаттайгаар явагдах тул С эсвэл түүнээс сайн дүн сурагчид цаашид амжилттай суралцах боломжтой.

Дэлхийн хэлний кредит авахын тулд дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- Кредит тус бүрд 140 цагаас доошгүй албан ёсны хэлний сургалтад хамрагдсан болохыг илтгэх дүнгийн хуулбар.
- Сурагч тэнцсэн дүн авсан байх шаардлагатай.

*Ахисан шатны сургалтын диплом авах хүсэлтэй сурагчид гурван жил/ түвшний нэг хэл эсхүл хоёр жил хоёр хэл суралцсанаар эсхүл мужаас хүлээн зөвшөөрсөн ур чадварын шалгалтыг амжилттай өгснөөр дэлхийн хэлний шаардлагыг хангана. Дэлхийн хэл бүрийн хичээлийг амжилттай дүүргэснээр Ахисан шатны сургалтын диплом авах нэг кредит авна.*

Араб, Хятад ба Латин хэлний нэг буюу түүнээс дээш түвшний хичээл зайнаас суралцах технологи ашиглан орох магадлалтай. Улсын эсхүл мужийн өөр газарт үйл ажиллагаа явуулдаг онлайн зайн сургалтын газрын хичээлүүд APS-уйнхаас өөр дүгнэх, даалгавар өгөх болон ирц бүртгэх журамтай байж болно.

**Америкийн дохионы хэл (ASL) нь Виржиниягийн улсын их сургуулиуд болон олон нийтийн коллежийн элсэлтийн хэлний шаардлагыг хангадаг. Зарим өөр мужийн болон хувийн их, дээд сургуулиуд ASL-ийг дэлхийн хэлд тооцдоггүй. ASL нь Олон улсын бакалаврын (IB)-ын хэл биш**

## Америкийн дохионы хэл I (15990)

### Бүтэн жил, нэг кредит

*Урьдчилсан шаардлага: Байхгүй*

Сурагчид өөрийн гэр, сургууль болон нийгэмд бусадтай харилцахдаа ашиглах дохионы хэл ойлгох, дохионы хэлээр ярих чадварыг суралцана. Сурагчид гэр бүл, сургуулийн арга хэмжээ болон тэмдэглэлт баярын талаар асуулт асууж, хариулж сурна. Гарын дохиогоор бус (тухайлбал, нүүр хувирал, биеийн хөдөлгөөн, хувийн орон зай) байдлыг ашиглаж дохионы хэлээр танилцуулах, баяртай гэж хэлэх,

бусдын анхаарлыг хандуулах, хэлэлцээр хийх зэрэг наад захын мэдээллийг өгч, авч сурна. Сурагчид Америкийн дохионы хэлний түүхийг судалж, сонсголгүйчүүдийн соёлыг таньж мэднэ.

## Америкийн дохионы хэл II (15995)

### Бүтэн жил, нэг кредит

*Урьдчилсан шаардлага: Америкийн дохионы хэл I амжилттай дүүргэсэн*

Сурагчид АДХ дээрх харилцах ур чадвараа улам сайжруулна. Тодруулга хийх зорилгоор асуулт асуух, хариулахын зэрэгцээ өдөр тутмын амьдрал болон эргэн тойрны тухай өөрийн үзэл бодол, хүсэл сонирхлыг илэрхийлнэ. Сурагчид илүү хийсвэр сэдэв болон уран зохиол судлах замаар үгийн баялаг болон харилцан ярианы ур чадвараа нэмэгдүүлнэ. Сонсголгүй иргэдийн талаар болон хэл сурах боломжийнх талаар илүү гүнзгий ойлголттой болно. АДХ-ээ ашиглан хичээлийн танхимаас гадуур бусадтай харилцахыг бид тэднээс уриалах болно.

## Араб хэл I, Бүтэн жил (15800)

Энэ түвшинд сурагчдыг Араб хэлний цагаан толгой болон авианы системтэй танилцуулна. Энэ хичээл соёлын болон түүхийн мэдээллээр баялаг. Араб хэлний түүх, Араб хэлний гэр бүлийн мод болон бичвэрийг олгоно. Анхны авиа зүйд болон бичих системд хандуулах анхаарлын зэрэгцээ сурагчид хэлний авиа, өргөлт болон өнгийг сурч, хэрэглэж сурна. Хэл зүйн дүрмийн үндсэн бүтэц, үгсийн санг танилцуулснаар сурагчид маш анхан шатны албан харилцааг энгийн хялбар өгүүлбэр болон харилцан яриагаар зохих түвшинд өрнүүлнэ. Сурагчид сонссон үг болон өгүүлбэрээ бичих чадвартай болох бөгөөд өмнө сурсан үг болон өгүүлбэрийг уншиж, мэндчилж, бусдыг танилцуулж, энгийн хялбар асуулт, хариулт зохиож, анхан шатны нийгмийн харилцаанд орно, өөрсдийн болон өөрийн гэр бүлийн гишүүд болон бусдын талаар ярьж, өөрийн хувийн үндсэн мэдээллийг солилцоно. Сургалтын үндсэн сэдэв нь хувийн болон гэр бүлийн амьдрал байна.

## Араб хэл II, Бүтэн жил (15822)

*Урьдчилсан шаардлага: Араб хэл I хичээлийг амжилттай дуусгасан буюу багшийн дүгнэснээр ижил түвшинд тухайн хэлийг эзэмшсэн*

Энэ хичээл нь анхлан суралцагчийн эзэмших түвшинд үргэлжлүүлэн сонсох, ярих, унших болон бичих чадвар хөгжүүлэн Арабаар ярьдаг улсуудад тохиож болох өдөр тутмын амьдралын нөхцөл байдлын хүрээний сэдвийг хөндөнө.

Сурагчид үгийн сангаа нэмэгдүүлж, Араб хэлний өгүүлбэрийн энгийн бүтцийг үргэлжлүүлэн сурч,

ажил хэргийн ярианд хэл зүйн дүрмийн суурийг хэрэглэнэ. Араб хэл II хичээлийг дүүргээд сурагчид нийгмийн харилцааг өөрөө эхлүүлэх чадвартай болж, соёлын талаас нь үндсэн ойлголттой болно. Сурагчид энгийн хялбар асуултыг ойлгож, хариулж чадах бөгөөд богино өгүүлбэрүүд, ялангуяа танил сэдвээр өргөн хэрэглэгддэг тушаал зааврыг өгч чаддаг болно. Өмнө дадлага хийж, цээжилсэн өгүүлбэрүүд, хэллэгүүдийг ашиглан сурагчид хүмүүсийг дүрсэлж, ямар харагдаж, ямар мэдрэмж төрж буйг тайлбарлаж, сонирхлынхоо талаар мэдээлэл солилцож, өмнө сурсан материал ашиглан энгийн өгүүлбэр, богино хэмжээний догол мөр уншиж, зохиож бичиж чаддаг болно. Түүнчлэн тэд албан болон ярианы Араб хэлний зарим ялгааг мэддэг болно. Хамрах сэдэвт сургууль, гэрийн амьдрал, нийгмийн амьдрал, хувийн сонирхол, олон нийтийн амьдрал, дэлгүүр хэсэх, ресторан болон хоол багтана.

### **Хятад хэл I, Бүтэн жил (15615)**

Сурагчид өөрийн тухай болон өөрийн ойр орчны тухай хялбар бүтэцтэй энгийн өгүүлбэр ашиглан ярьж ойлгуулах чадвар эзэмшинэ. Уг харилцаа нь хэлний бүх дөрвөн чадвар болох сонсох, ярих, унших болон бичир чадвараар илэрнэ. Энэ хичээл нь сонсох болон ярих ур чадварт илүү анхаарал хандуулна. Сурагчдад пиньинийг танилцуулж, хялбарчилсан Хятад дүрс үсэг заана.Тэдгээр нь энэ түвшинд зорьсон сэдэв болон хэлзүйн дүрмийн элементийн хүрээнд байна. Сурагчид зөвхөн уншиж чаддаг болох төдийгүй бичиж, компьютер болон бусад электрон төхөөрөмж дээр оруулж чаддаг байх зорилгоор дүрс үсгийг таньж мэддэг болно. Сурагчид хувийн болон гэр бүлийн амьдрал, сургуулийн амьдрал, нийгмийн болон олон нийтийн дундах амьдрал зэрэг сэдвийн хүрээнд хэлийг судална.

### **Хятад хэл II, Бүтэн жил (15625)**

*Урьдчилсан шаардлага: Хятад хэл I хичээлийг амжилттай дуусгасан буюу багшийн дүгнэснээр ижил түвшинд тухайн хэлийг эзэмшсэн.*

Сурагчид өөрийн тухай болон өөрийн ойр орчны тухай хялбар бүтэцтэй энгийн өгүүлбэр ашиглан ярьж ойлгуулах чадвар үргэлжлүүлэн эзэмшинэ. Энэ харилцаа нь хэлний дөрвөн ур чадвар болох сонсох, ярих, унших болон бичихээр харагдах бөгөөд ярихад илүү анхаарал хандуулна. Сурагчид I түвшинд сурсан хувийн болон гэр бүлийн амьдрал, сургуулийн амьдрал, нийгмийн болон олон нийтийн амьдрал сэдвүүдийг илүү өргөжүүлэн сурна. Сурагчид хялбарчилсан хятад хэлээр бичих чадвараа улам сайжруулна. Сурагчид зөвхөн уншиж чаддаг болох төдийгүй бичиж, компьютер болон бусад электрон төхөөрөмж дээр оруулж чаддаг байх зорилгоор дүрс үсгийг таньж мэддэг болно. I түвшинд сурсан дүрс үсгүүд дээр нэмээд сурагчдад шинэ хялбарчилсан

Хятад дүрс үсэг заана.Тэдгээр нь энэ түвшинд зорьсон сэдэв болон хэлзүйн дүрмийн элементийн хүрээнд байна.

### **Франц хэл I, Бүтэн жил (15110)**

Бодит амьдрлын жишээ, харилцан яриа, жүжиг болон бусад бүтээлч, биеэр оролцох үйл ажиллагаагаар хэл сурахад анхаарлаа хандуулна. Сурагчид ур чадвараа хөгжүүлж, сонсох, ярих, унших болон бичих замаар хэлний үндсэн бүтэц, үгсийн санг сурна.

Сурагчид дараахад суралцана:

- Мэндчилэх, салах ёс, найрсаг харилцаанд суралцах.
- Найз, гэр бүл болон сургуулийн тухай энгийн харилцан ярианд оролцоно.
- Танил сэдвээр асуулт асууж, хариулах.
- Хоолны цэс, тэмдэглэгээ, хуваарь болон бусад амьдралын зүйлсийг унших.
- Богино хэмжээний тайлбар, захиа бичих, зааврын дагуу зохион бичлэг бичих.
- Суралцаж буй хэлд холбогдох өдөр тутмын амьдралын соёлтой танилцах.

### **Франц хэл II, Бүтэн жил (15120)**

*Урьдчилсан шаардлага: Франц хэл I хичээлийг амжилттай дуусгасан буюу багшийн дүгнэснээр ижил түвшинд тухайн хэлийг эзэмшсэн.*

Сурагчид сонсох, ярих, унших болон бичих чадвараа үргэлжлүүлэх хөгжүүлж, зорилтот хэлний соёлын асуудлыг илүү өргөн хүрээнд ойлгодог болно.

Сурагчид дараахад суралцана:

- Найз нөхөд, гэр бүл, сургуулийн хамааралтай сэдвүүд, мэдрэмж, цаг, цаг агаар болон байршлын талаар ярихдаа ирээдүй болон өнгөрсөн цаг ашиглаж сурна.
- Өмнө сурсан материалаа ашиглан илүү гэнэтийн, нөхцөл байдлаас үүдэн гарсан харилцан ярианд оролцдог болно.
- Хувийн үндсэн мэдээллээр ярилцлага өгч сурна.
- Үзэл бодол, дуртай, дургүй зүйлсээ илэрхийлэх.
- Бодит унших материалын талаар сэтгэгдлээ илэрхийлнэ.
- Бүтээлч зохион бичлэгээр өөрийгөө илэрхийлнэ.
- АНУ болон зорилтот соёл хоорондын төстэй болон ялгаатай талуудыг таньж тогтооно.

### **Латин хэл I, Бүтэн жил (15310)**

Энэхүү анхан шатны Латин хэлний хичээлээр сурагчид эртний Ромын хэл болон аж амьдралтай танилцана. Латин хэл I хичээлийн гол зорилго нь

сонсох, ярих болон бичиг ур чадварын дэмжлэгтэйгээр унших чадвараа хөгжүүлэх юм.

Сурагчид дараахад суралцана:

- Хялбарчилсан Латин хэлний текст болон энгийн хялбар Латин эх сурвалжуудыг унших.
- Латин дуудлагын үндсэн элементүүдийг ойлгоно.
- Анхан шатны Латин үгс сурна.
- Латин хэлний нэр үг болон үйл үгийн төгсгөлүүд, тэдгээрийн үүргийг сурч ойлгох.
- Латин хэлний анхан шатны хэл зүйн дүрмийг ойлгож авах.
- Латин үгийн үндэс, угтвар болон дагавар ашиглан Латин болон Англи хэл дээр үг үүсгэх мэдлэгээ дээшлүүлнэ.
- Ромын өдөр тутмын амьдрал, зан заншил, төр засаг болон домог түүхийн талаар судална.

### **Латин хэл II, Бүтэн жил (15320)**

*Урьдчилсан шаардлага: Латин хэл I хичээлийг амжилттай дуусгасан буюу багшийн дүгнэснээр ижил түвшинд тухайн хэлийг эзэмшсэн.*

Сурагчид илүү нарийн төвөгтэй, Латин хэл дээрх жинхэнэ материал унших замаар ур чадвараа хөгжүүлнэ. Тэд Ромын соёл, түүх болон домгийг илүү гүнзгийрүүлэн судална.

Сурагчид дараахад суралцана:

- Илүү урт, хүнд орчин цагийн Латин хэл дээрх материал уншина.
- Найраглал болон шүлэг хэлбэрээр анхны Латин хэл дээр материал уншиж эхэлнэ.
- Латин хэлний үгсийн санг баяжуулах.
- Латин үгийн хэлбэрүүдийг үргэлжлүүлэн сурна, тухайлбал, үйл үгийн үндэс, өнгөрсөн цаг дээр хувирах, дагаврууд гэх мэт.
- Илүү төвөгтэй хэл зүйн дүрмүүд мэддэг болно.
- Латин хэлний Англи болон бусад Романс хэлнүүдэд үзүүлсэн нөлөөллийг илүү тодорхой харна.

### **Испани хэл I, Бүтэн жил (15510)**

Бодит амьдралын жишээ, харилцан яриа, жүжиг болон бусад бүтээлч, биеэр оролцох үйл ажиллагаагаар хэл сурахад анхаарлаа хандуулна. Сурагчид ур чадвараа хөгжүүлж, сонсох, ярих, унших болон бичих замаар хэлний үндсэн бүтэц, үгсийн санг сурна.

Сурагчид дараахад суралцана:

- Мэндчилэх, салах ёс, найрсаг харилцаанд суралцах.
- Найз, гэр бүл болон сургуулийн тухай энгийн харилцан ярианд оролцоно.
- Танил сэдвээр асуулт асууж, хариулах.
- Хоолны цэс, тэмдэглэгээ, хуваарь болон бусад амьдралын зүйлсийг унших.
- Богино хэмжээний тайлбар, захиа бичих, зааврын дагуу зохион бичлэг бичих.

- Суралцаж буй хэлд холбогдох өдөр тутмын амьдралын соёлтой танилцах.

### **Испани хэл II, Бүтэн жил (15520)**

*Урьдчилсан шаардлага: Испани хэл I хичээлийг амжилттай дуусгасан буюу багшийн дүгнэснээр ижил түвшинд тухайн хэлийг эзэмшсэн*

Сурагчид сонсох, ярих, унших болон бичих чадвараа үргэлжлүүлэх хөгжүүлж, зорилтот хэлний соёлын асуудлыг илүү өргөн хүрээнд ойлгодог болно.

Сурагчид дараахад суралцана:

- Найз нөхөд, гэр бүл, сургуулийн хамааралтай сэдвүүд, мэдрэмж, цаг, цаг агаар болон байршлын талаар ярихдаа ирээдүй болон өнгөрсөн цаг ашиглаж сурна.
- Өмнө сурсан материалаа ашиглан илүү гэнэтийн, нөхцөл байдлаас үүдэн гарсан харилцан ярианд оролцдог болно.
- Хувийн үндсэн мэдээллээр ярилцлага өгч сурна.
- Үзэл бодол, дуртай, дургүй зүйлсээ илэрхийлэх.
- Бодит унших материалын талаар сэтгэгдлээ илэрхийлнэ.
- Бүтээлч зохион бичлэгээр өөрийгөө илэрхийлнэ.
- АНУ болон зорилтот соёл хоорондын төстэй болон ялгаатай талуудыг таньж тогтооно.

### **Чөлөөтэй ярьдаг сурагчдад зориулсан Испани хэл I, Бүтэн жил (15517)**

*Урьдчилсан шаардлага: Багшийн тодорхойлсноор Испани хэлээр чөлөөтэй ярьж чаддаг байх*

Энэ хичээл нь Испани хэлээр чөлөөтэй ярьдаг боловч уншиж, бичих чадвар хангалттай эзэмшээгүй сурагчдад зориулагдсан. Сурагчид унших, бичих, ярих харилцааны ур чадвар эзэмшиж, Испани хэл зүйн дүрмийг сурч эхлэх болно. Сурагчид Испани хэл соёлын өнцгөөс харах, илэрхийлэх хэлбэрийн талаар илүү сайн ойлголттой болно.

### **Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл II, Бүтэн жил (15527)**

*Урьдчилсан шаардлага: Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл I хичээлийг амжилттай дуусгасан эсхүл байршуулах шалгалтаар ойролцоо түвшиний чадвар эзэмшсэн нь тодорхойлогдсон*

Энэ хичээл нь Испани хэлээр анхан шатны түвшинд хэдийнээ уншиж, бичиж чаддаг хүмүүст зориулагдсан. Сурагчид зөв бичих, механик болон богино зохион бичлэг хийх чадвараа дээшлүүлнэ. Тэд эх бүтээл уншиж, орчуулж эхлэх бөгөөд/эсхүл хүүрнэл өгүүллэг болон шүлгийг шинжилнэ. Хэл зүйн дүрмийг үргэлжлүүлэн судална. Сурагчид ангидаа илтгэл тавих болон хоорондоо харилцах бусад үйл ажиллагаагаар ярианы чадвараа сайжруулна. Соёл, ёс заншлыг судалж, уран зохиолоор дамжуулан илүү гүнзгий ойлголттой болно.



**Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл  
III,**

**Бүтэн жил (15537)**

*Урьдчилсан шаардлага: Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл II хичээлийг амжилттай дуусгасан эсхүл байршуулах шалгалтаар ойролцоо түвшний чадвар эзэмшсэн нь тодорхойлогдсон*

Энэ хичээл нь илүү ахисан түвшинд уншиж, бичиж чаддаг сурагчдад зориулагдсан. Сурагчид захидал, зохион бичлэг, тайлан бичиж чадах ба илүү нарийн төвөгтэй, урт өгүүллэгүүдийг орчуулах болон/эсхүл шинжилдэг болно. Түүнчлэн, сурагчид төрөл бүрийн сэдвээр тайлан бичих буюу амаар илтгэл тавина. Соёл, ёс заншлыг хуваалцаж, уран зохиолоор дамжуулан илүү гүнзгий ойлголттой болно.

## GUNSTON ДУНД СУРГУУЛЬ

### ИСПАНИ ХЭЛНИЙ ХӨТӨЛБӨР

Испани хэлний дадлагын сурагчид 6, 7 болон 8-р ангийн Испани хэл урлаг, нийгэм судлал болон шинжлэх ухаан (Шинжлэх ухаан болон нийгэм судлалын сургалтын хөтөлбөрөөс дэлгэрэнгүй мэдээлэл авна уу) хичээлүүдийг Испани хэлээр судална.

#### Испани хэл урлаг

Испани хэл урлаг хөтөлбөр нь сурагчдад Испани хэлээр сонсож ойлгох, ярих, унших болон бичих чадвараа сайжруулах боломж олгодог. Соёл, ёс заншил, үзэл санааг ойлгуулахад онцгой анхаарал хандуулна.

Испани хэл урлаг хөтөлбөр нь сурагчдаас дараах дарааллаар ажиллахыг шаарддаг:

1. Мэдээлэл цуглуулах
2. Төсөлд оролцох
3. Багаар ажиллах
4. Аман илтгэл тавих
5. Өөрийн бүтээл, ажлыг үнэлж, дүгнэх

6-р ангид сурагчид:

- Янз бүрийн сэдвийг хамарсан харилцан ярианд оролцоно.
- Ойлгох зорилгоор зохих унших стратегийг ашиглана.
- Сонирхлоороо унших ба уран зохиолын бүлгүүдэд оролцоно.
- Өөр өөр жанраар бичнэ.
- Зорилтот соёлын хэл, амьдралын хэв маяг, үнэ цэнийг өөрийнхтэйгөө харьцуулж, жишнэ.
- Соёлын ялгаа нь нийгмийн салшгүй нэг хэсэг болохыг таньж ойлгоно.

7-р ангид сурагчид:

- Өргөн хүрээний сэдвийг хамарсан харилцан ярианд оролцоно.
- Ойлгох зорилгоор зохих унших стратегийг ашиглана.
- Сонирхлоороо унших ба уран зохиолын бүлгүүдэд оролцоно.
- Өөр өөр жанраар бичнэ.
- Бичих замаар мэдээлэлд боловсруулалт хийнэ.
- Хэл судлалыг бусад хичээлийн болон хичээлийн бус туршлагаудтай холбоно.
- Испани хэлтний соёлын Америкийн өв уламжлалд үзүүлсэн нөлөөг ойлгож авна.
- Бодит эх сурвалжаас Испани хэлтний соёлын талаар мэдээлэл олж авна.

8-р ангид сурагчид:

- Төрөл бүрийн хэл зүйн дүрмийн бүтэц, үгсийн сан ашиглан нарийн төвөгтэй илтгэл, яриаг ойлгоно.
- Өргөн хүрээний сэдвийг хамарсан харилцан ярианд оролцоно.
- Ойлгох зорилгоор зохих унших стратегийг ашиглана.
- Мэдээлэл авах зорилгоор болон сэргэх зорилгоор уншина.
- Уншсан зүйлсээ түүхэн болон соёлын нөлөөлөлтэй холбож ойлгоно.
- Дүрслэл зохион бичлэг хийнэ.
- Ангиас гадуур зорилтот хэл ашигладаг болно.
- Зорилтот хэлээр ярьдаг улсуудын ёс заншлын талаар мэдээлэл олж авна.

*Тайлбар: Энэ хичээлээр 7 болон 8-р ангийн сурагчдад ахлах сургуулийн кредит олгогдох бөгөөд ахлах сургууль төгсөхөд тавигдах шаардлагыг хангана. Дэлгэрэнгүй мэдээллийг 56-р хуудаснаас авна уу.*

Ганстон дахь Монтессори дунд сургуулийн хөтөлбөр нь олон ялгаатай насны ангиудын цагаар дамжуулан салбар хоорондын суралцах боломжийг хөхүүлэн дэмждэг. 6 болон 7-р ангийн сурагчид Монтессори орчинд Англи хэл урлаг, шинжлэх ухаан, математик болон түүх судалдаг; харин сонгон суралцах хичээлийг багш нар уламжлалт Gunston хөтөлбөрөөр заадаг. 8-р ангийн Монтессори сурагчид газар зүй болон математикийн уламжлалт анги руу шилждэг бол Англи хэл болон шинжлэх ухааны хичээл нь Монтессори хөтөлбөрт хэвээр үлддэг.

Хичээлийн мэдлэгээс гадна уг хөтөлбөр нь сурагчийн бие бялдрын, нийгмийн болон сэтгэл зүйн хөгжлийг дэмждэг. Монтессори боловсролын хувьд эдгээр нь салшгүй чухал хэсгүүд юм. Монтессори дунд сургуулийн хөтөлбөр нь үр дүнтэй харилцаа, нинжин сэтгэл, бусдыг болон байгаль орчноо анхаарч хандах, зөрчил шийдвэрлэх чадвар, шинэ зүйлд нээлттэй байдал, амьдралыг халуун дулаанаар, ээргээр, хайрлаж хандах үзлийг хөгжүүлэхэд дэмжлэг болоход зориулагдсан. Дунд сургуулийн сурагчид бие даасан, хараат бус байдлыг эрхэмлэдэг тул анги танхим нь нийгмийн хариуцлага болон хувийн сахилга баттай орчин сонголт хийх эрх чөлөөг бүрдүүлдэг. Багш нар зөвлөгч болон чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэж, сониуч байх, бүтээлчээр асуудал шийдэх, хамтран ажиллах, суралцах замаар нийгмийн харилцаанд орохыг уриалдаг.



## Thomas Jefferson дунд сургууль

Олон улсын бакалаврын дэлхийн сургууль  
Дунд сургуулийн хөтөлбөр явуулж байна

Олон улсын бакалаврын дунд сургуулийн хөтөлбөр (IBMYP) нь хувьсан өөрчлөгдөж буй бөгөөд улам л уялдаа холбоотой болж буй дэлхийд идэвхтэй, хариуцлагатай оролцоход шаардлагатай мэдлэг, хандлага болон ур чадварыг хөгжүүлэхэд сурагчдад туслахаар боловсруулагдсан. Энэ нь зөвхөн “мэдээд” зогсохгүй байх сургалтын хөтөлбөртэй ажиллана гэсэн үг. Үүнд илүү тунгаан бодох, шүүмж болон бүтээлч хэлбэрээр асуудал шийдэх, хувийн үзэл бодолдоо дүн шинжилгээ хийж, хэлэлцэх чадвар багтана.

Гурван үндсэн ойлголт нь дэлхий дахины бүх Дунд сургуулийн хөтөлбөрийн философийн суурийг тавьдаг: соёл хоорондын харилцан ойлголцол, харилцаа холбоо болон бүрэн дүүрэн бүх талаас суралцах. *Соёл хоорондын харилцан ойлголцол* нь олон ургалч үзэл дотоодын, үндэсний болон дэлхий нийтэд амин чухал учраас бүх хүнийг хүндэлж, хүлээн зөвшөөрч, талархан хүлээн авахыг илэрхийлнэ. *Харилцаа холбоо* нь залуу хүний амжилтад хүрэхэд нэн чухал чадвар юм. IBMYP бүх хичээлийн багш нар сурагчдын харилцааны чадварыг хөгжүүлэхэд онцгой үүрэгтэй болохыг онцолж, бүх сурган хүмүүжүүлэгчдийг харилцаа холбооны багш гэж үздэг. Өөр хэлээр харилцаж чаддаг байх нь мөн чухал учраас бүх IBMYP сурагчид хоёр дахь хэл сурдаг. *Бүрэн дүүрэн суралцах* гэдэг нь бүх мэдлэг хоорондын уялдаа холбоотой бөгөөд сургалтын хөтөлбөр нь сурагчийн нийт хэрэгцээг хангахад чиглэгдсэн байх ёстой болохыг илэрхийлдэг. Сурагчдаас сурсан мэдлэг, ур чадвараа шинэ, холбогдолтой нөхцөл байдалд ашиглахыг уриалснаар Бүрэн дүүрэн суралцах боломж бүрддэг. Түүнчлэн, өөр өөр чиглэлийн багш нар нэгдсэн ойлголт, сэдвийн хүрээнд хичээлээ төлөвлөснөөр салбар хоорондоо уялдаа холбоог ойлгох ойлголтыг хөхүүлэн дэмждэг. Thomas Jefferson-ны багш нар сурагчдад бүх хичээлийн чиглэлээр болон хичээлээс гадуур амжилтад хүрэх шилжилтийн ажлын дадал, ур чадвар, хандлагыг хөгжүүлэхэд нь туслахыг эрмэлздэг.

Бүх IB хөтөлбөрүүд нь сурагчдад IB суралцагчийн шинж чанарыг суулгаж өгөхөд анхаардаг. Эдгээр шинж чанарууд нь дэлхийн хамтын нийгэмлэгийн насан туршийн суралцагчдыг хөгжүүлэх арван шинж чанар, хандлага юм.

Мэдлэгтэй Сэтгэгч	Тунгаан боддог Тэнцвэртэй	Нээлттэй Зарчимч	Харилцааны чадвартай Эрсдэл гаргагч	Судлаач Халамжтай
----------------------	------------------------------	---------------------	--	----------------------

### Судалгаа

TJMS-д манай зорилго бол сурагчид үргэлж идэвхтэй оролцдог судалгаанд суурилсан ангиудтай байх явдал юм. Зохион байгуулалттай судалгааны арга барил нь сурагчдад таньж мэдэх боломж олгож, шүүмжлэн сэтгэгч чанарыг хөгжүүлэхийн зэрэгцээ хичээлийн үндсэн онолууд болон холбогдох ур чадваруудыг мөн сургана. Дунд сургуулийн хөтөлбөр нь заах арга зүйг төлөвлөхдөө хамтран ажиллахыг шаардах бөгөөд ингэснээр сурагчид хувийн хэрэгцээгээ хангахын зэрэгцээ эн тэнцүү суралцах орчноор хангагдана. Хичээлийн сэдвүүд болон холбогдох шалгалт, даалгавруудыг багш нарын баг төлөвлөдөг. Багш нар мөн заах арга зүйгээ хэрхэн ялгавартай хэрэгжүүлэх тал дээр хамтран ажилладаг. Багш нар заах арга зүйгээ төлөвлөдөг хэдий ч анги танхим бол багш, сурагчид заах болон суралцах үйл явцад түншүүд байдаг орчин юм.

### Үйлдэл

Дунд сургуулийн хөтөлбөрийн сурагчид ангидаа идэвхтэй оролцох замаар үйлдэл хийдэг. Тэдний оролцоо нь хариуцлагатай сонголт, боломжуудыг харгалзан үзсэний үндсэн дээр бодит амьдрал дээрх асуудлуудыг судлахад төвлөрнө. Хийх үйлдэл нь өөрсдөдөө болон бусдад нөлөөлөх, заах зэрэг нь орж болно. Хийх үйлдэл мөн үйлчлэх замаар суралцах хэлбэртэй байж болно. Thomas Jefferson сургуульд байх хугацаандаа бүх сурагчид үйлчлэх үйл ажиллагаанд оролцоно гэсэн хүлээлт сургуульд байдаг. Сурагчид Thomas Jefferson олон нийтийн цэцэрлэгт ажиллангаа суралцах зэргээр сургуулиас зохион байгуулсан долоо хоног бүрийн үйл ажиллагаанд оролцох замаар үйлчилсэн цаг цуглуулах боломжтой. Түүнчлэн сургалтын хөтөлбөрийн холбогдолтой шууд асууж, сурах замаар үйлчлэх өөр боломжууд олох боломжтой. Сурагчид үйлчлэх боломжуудыг хөөхийн хэрээр аливаа асуудал, зорилгыг дэмжихийг тэднээс уриалдаг. Өөрсдийн сонирхлоор тодорхой чиглэлээр тэдний суралцах байдал болон оролцоо нь дунд сургуулийн сурагчдын хөтөлбөрийн даалгавар болох 8-р ангид хэрэгжүүлэх шаардлагатай олон нийтийн төслийн сэдэв болон хувирах магадлалтай.

### Дүгнэлт

Дунд сургуулийн хөтөлбөрийн сурагчид шүүмжит тунгаан бодох үйл явцад оролцож, нотолгоог тэд хэрхэн ашигладаг, төрөл бүрийн аргыг хэрхэн ашигладаг, аливаа дүгнэлтэд хэрхэн хүрдэг талаар тунгаан боддог. Түүнчлэн сурагчид өөрийн үзэл бодолд дүн шинжилгээ хийж, болзошгүй хэт нэг талыг баримталсан байдал болон өөрийн болон бусдын ажилд алдаа байгаа эсэхийг нягталдаг.

Эцэст нь сурагчид Jefferson дэх 3 жилийн хугацааны IBMYP хувийн хэргийг бий болгодог. Хувийн хэрэгт Jefferson дунд сургуулийн эрхэм зорилгыг хангахад сурагчдын хийсэн зүйлсийг тусгана: нийгэмдээ идэвхтэй олон улсын иргэд болсон байдлыг нь тусгана.

## **2022-23 онд 6-р ангийн ИВМҮР дөрвөн ээлжлэн сонгон суралцах хичээл**

Thomas Jefferson дунд сургууль нь Дунд сургуулийн хөтөлбөр (МҮР) хэрэгжүүлдэг Олон улсын бакалаврын дэлхийн сургууль юм. ИВ-ын шаардлагын дагуу сурагч бүр дараах хичээл тус бүрийг 50 цагаас доошгүй суралцсан байх ёстой: Шинжлэх ухаан, Дизайн технологи, Хүмүүнлэгийн ухаан, Урлаг судлал, Математик, Хэл А, Хэл В болон Биеийн тамирын боловсрол. 6-р ангийн сурагчид МҮР-ийн шаардлагыг хангахын тулд дөрвөн тойрох сонгон суралцах хөтөлбөрт оролцох ёстой.

Бүх сурагчид бүтэн жилийн туршид өнжөөд нэг удаа Биеийн тамирын хичээлд орно. Түүнчлэн тэд Дизайн технологи болон Урлагийн тэнцвэр хангасан ангиудаас нэмж сонгон орно. Урлагийн ангиуд нь Драм, Хоор (улирал) болон Дүрслэх урлаг. Дизайн технологийн ангиуд нь Компьютер, Гэр бүл болон хэрэглэгчийн шинжлэх ухаан, технологийн боловсрол. Эдгээр анги улирлын турш өнжөөд нэг орно. Бүтэн жилийн Хамтлаг, Оркестр, Хоор хөгжим нь өдөр бүр орох бөгөөд тэдгээр нь урлаг болон дизайн технологийн ангийн аль алинд тооцогдоно.

6-р ангийн сурагчид мөн өнжөөд нэг ордог Дэлхийн хэл хичээлд бүтэн жил хамрагдах ёстой. Үзэж болох дэлхийн хэл нь Америкийн дохионы хэл (АДХ), араб, хятад, франц, латин, испани хэлээр чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан испани хэл. Америкийн дохионы хэл (АДХ) нь Олон улсын бакалаврын (ОУБ) хэл биш бөгөөд Виржиниягийн улсын их сургууль, коллежийн дэлхийн хэлний элсэлтийн шаардлагыг хангадаг болохыг анхаарна уу. Зарим өөр мужийн болон хувийн их, дээд сургуулиуд АДХ-ийг дэлхийн хэлд тооцдоггүй.

## **KENMORE ДУНД СУРГУУЛЬ**

### **Урлаг ба харилцааны технологи төвтэй хөтөлбөр**

Kenmore дунд сургууль нь урлаг болон харилцааны технологи төвтэй сургууль болоод 24 дэх жилийнхээ нүүрийг үзэж байна. Дунд сургуулийн хөтөлбөрийг урлагаар болон харилцаа холбооны технологиор дамжуулан хүргэдэг. Kenmore сургуулийн сурагчид судалж, холбогдож, бүтээж, харилцдаг. Сургуулийн өдрийн туршид тэд суралцах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, харилцаа холбооны технологийг дүрслэх урлаг, хөгжим болон хөдөлгөөнтэй уялдуулдаг. Арлингтон даяарх сурагчид Kenmore сургуульд суралцахаар өргөдөл гаргах боломжтой. Харьяалах дүүргийн гаднаас хамрагдах сурагчдад зориулсан автобус явдаг.

Сургуулийн урлаг ба технологи нь сурагчдад өөр хэлбэрээр суралцах боломж олгодог. Энэ арга барил нь Howard Gardner-ын Олон төрлийн оюун ухаан онолд суурилсан бөгөөд сурагчдаас найман оюун ухаан болох: хөгжмийн, дүрслэлийн, хэл ярианы, логикийн, хөдөлгөөний, харилцааны болон байгаль орчны оюун ухааныг ашиглахыг уриалж, эрэлхийлдэг. Сурагчдыг шүүмжит хэлбэрээр тунгаан бодож, ангидаа хамтран ажилладаг байхыг уриалдаг. Суралцах үйл явц нь идэвх болон оролцоо юм. Нийгмийн болон сэтгэлзүйн хөгжлийг Эерэг зан байдлын оролцоо болон дэмжлэг (PBIS) тогтолцоогоор дэмждэг ба энэ нь Арлингтоны шат дараалсан дэмжлэгийн систем (ATSS) загварт нийцдэг. Хичээлийн оролцоог уян хатан байдлаар үүсгэсэн багшийн зөвлөх багууд болон нэмэлт сонгон суралцах хичээлүүд ба сургуулийн дараах дэмжлэгээр бэхжүүлдэг. Kenmore сургууль Мягмар болон Пүрэв гаригуудад сургуулийн дараах АСТ II хөтөлбөрөөр дамжуулан сонгон суралцах хичээлүүд явуулдаг.

Тус сургууль нь урлагийг дэмжиж ирсэн түүх уламжлалтай бөгөөд Урлагийн тоглолтын Кеннеди төвтэй урт хугацаанд харилцаатай байж ирсэн. Kenmore жилийн туршид театрын урлаг, хоор дуу, оркестр болон хамтлагуудын хөтөлбөрийн олон тоглолтуудыг тавьдаг. Kenmore сургуулийн сурагчид мөн биеийн тамирын хичээлд Бүжиг авах боломжтой бөгөөд олон нийтэд зориулсан бүжгийн тоглолт мөн тавьдаг. Багш нарыг урлагийн хичээлийн агуулгадаа оруулах чиглэлээр мэргэшүүлэн хөгжүүлдэг. Tableau, уншигчийн театр, дүрслэх урлаг болон бусад арга техникийг жилийн туршид сургалтын хөтөлбөрт шигтгэсэн байдаг.

Технологийн бүтээлч хэрэглээ нь тус сургуулийн шилдэг дадлын нэг юм. Сурагчид iPad, УХААЛАГ самбар, интерактив хариултын систем, телевизийн студи болон төрөл бүрийн программ хангамжийг суралцах үйл явцдаа ашиглах боломжтой. Kenmore сургуулийн сурагчид сонгон суралцах хичээлээрээ Роботик болон Дизайн сэтгэлгээ хичээлүүд сонгох боломжтой. Эдгээр хичээл нь шинжлэх ухаан, технологи, инженеринг, урлаг болон математик (STEAM)-ийн цогц хэрэглээг хангадаг. Түүнчлэн сурагчид хэд хэдэн цуврал STEAM-холбогдолтой хичээлийг амжилттай дуусгасныг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээтэй хөтөлбөрт хамрагдахаар сонгож болно. Сургууль нь олон үйлдэлт үйлдвэрлэлийн лаборатори (STEAM өрөө) болон технологиор тоногдсон анги танхимуудтай. Бүх ангид УХААЛАГ самбар бий. Нэг ангид олон тооны УХААЛАГ самбар байрлуулсан бол өөр нэг ангид интерактив хана босгосон.

Дунд сургуулийн загварын дагуу сурагчдыг үндсэн хичээлийн хувьд ангийн түвшнээр багуудад хуваадаг. Сурагчдыг хамтран ажиллах тав эсхүл зургаан багшид хуваарилж, тэдэнд сорьсон хэдий ч дэмжлэгтэй хичээлийн орчныг бүрдүүлж өгдөг. Багш нар болон ажилтнууд урлаг болон технологийг нэгтгэх, ашиглах мэргэшил дээшлүүлэх арга хэмжээнд тогтмол хамрагддаг. Түүнчлэн багш нар хамтран ажиллангаа суралцах багуудаараа үе үе уулзаж, сурагчийн сурлагын ахицад хяналт тавьж, сурагчдын бүхий л хэрэгцээ хангагдаж байгаа эсэхийг нягтална.

### **6-р АНГИ**

#### **ЭРҮҮЛ МЭНД БОЛОН БИЕ БЯЛДРЫН БОЛОВСРОЛ**

#### **6-р анги Эрүүл мэнд болон Бие бялдрын боловсрол/Бүжиг 6 Бүтэн жил (17111)**

6-р ангийн бүх сурагчид эрүүл мэнд болон бие бялдрын боловсролын хөтөлбөрт хамрагдана. Энэ хичээлийн бүжгийн хэсэг нь бүжигт илүү анхаарах байдлаар Виржиния мужийн биеийн тамирын боловсролын стандартыг хангах боломж олгоно.

Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр нь эрүүл амьдралын хэв маягийг эзэмшихэд сурагчид мэдэх, ойлгох, хийх хэрэгцээ шаардлагыг онцолно. Судлах сэдвүүдэд сэтгэл зүйн, сэтгэл мэдрэлийн, нийгмийн болон орчны эрүүл мэнд, аюулгүй байдал болон онцгой байдалд бэлэн байх, харилцаа, мансууруулах бодисын хэрэглээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гэр бүлийн амьдралын боловсрол зэрэг багтана.

6-р ангийн Эрүүл мэнд болон бие бялдрын боловсролын хичээлийн зорилго дээр нэмээд сурагчид

- Бүжгийн элементүүдийг ойлгож, дадлага хийнэ.
- Балет, жааз, орчин үеийн бүжиг, хип хоп бүжгийн үндэс суурийг ойлгож, харуулна.
- Бусад соёлын бүжгүүдийг ойлгож, харуулна.

## **УРЛАГИЙН БОЛОВСРОЛ**

### **ШОУНЫ ЦАГ, Бүтэн жил (11402)**

ШОУНЫ ЦАГ нь сургуулийн хичээлийн жилийн турш өдөр бүр цуглана. Энэ нь ялангуяа сонгон суралцах сонирхол нь урлаг болохыг хэдийнээ ойлгосон сурагчдад зориулагдсан. Жилийн турш Хоор болон Драм зэргээр хослуулан судалсны дараа энэ хичээл нь сурагчдад урлагийн мэргэжлийн продакшн нэгдсэн байдлаар гаргах туршлага олгодог. Улирал бүх Шоуны Цагийн сурагчид нэгээс доошгүй тоглолтод үзүүлбэрээ үзүүлдэг.

Шоуны Цагийг заахдаа багийн ажлыг голчилдог. Жилийн туршид сурагчид салбар бүр дэх өөрийн ур чадварыг сайжруулахаар ажиллахыг зэрэгцээ багаар хичээл зүтгэл гаргах орчинд тухтай байх түвшнийг нэмэгдүүлнэ.

## **7-р АНГИ**

### **ЭРҮҮЛ МЭНД БОЛОН БИЕ БЯЛДРЫН БОЛОВСРОЛ**

#### **7-р анги Эрүүл мэнд болон бие бялдрын боловсрол/Бүжиг 7 Бүтэн жил (17121)**

7-р ангийн бүх сурагчид эрүүл мэнд болон бие бялдрын боловсролын хөтөлбөрт хамрагдана. Энэ хичээлийн бүжгийн хэсэг нь бүжигт илүү анхаарах байдлаар Виржиния мужийн биеийн тамирын боловсролын стандартыг хангах боломж олгоно. Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр нь эрүүл амьдралын хэв маягийг эзэмшихэд сурагчид мэдэх, ойлгох, хийх хэрэгцээ шаардлагыг онцолно. Судлах сэдвүүдэд сэтгэл зүйн, сэтгэл мэдрэлийн, нийгмийн болон орчны эрүүл мэнд, аюулгүй байдал болон онцгой байдалд бэлэн байх, харилцаа, мансууруулах бодисын хэрэглээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гэр бүлийн амьдралын боловсрол зэрэг багтана.

7-р ангийн Эрүүл мэнд болон бие бялдрын боловсролын хичээлийн зорилго дээр нэмээд сурагчид

- Балет, жааз, орчин үеийн бүжиг, хип хоп бүжгийн үндэс суурийг ойлгож, харуулна.
- Үзэгчдийн өмнө бүжгийн үзүүлбэр үзүүлнэ.
- Хөгжмийн хэмнэлд тэнцвэр хөдөлгөөнөө нийцүүлж үзүүлнэ.

- Соёлын бүжгүүдийн гарал үүслийг ойлгох.

## **БИЗНЕС БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ**

### **Мультимедиа технологи I Улирал (16606)**

Сурагчид үндсэн хичээлүүддээ зориулан дуу, график болон дижитал дүрс бичлэг ашигласан мультимедиа болон DTP илтгэлүүд хийж сурна.

Сурагчид дараах ур чадварт суралцана

- Microsoft Office болон Adobe программ хангамжуудыг ашиглан анхан шатны компьютерт хэвлэн нийтлэх чадвар эзэмшинэ.
- Интернет ашиглах ур чадвар, техникт суралцана.
- Компьютер дээр технологийн анхан шатны чадварт суралцана
- Програмчлалын (код бичих) талаар ойлголт авна
  - Өгүүлэх самбар буюу Storyboards (энэ нь юу болох, яах гэж ашигладаг, хэрхэн үүсгэдэг тухай)
  - Хялбар хөдөлгөөнт дүрс болон дүрслэл эффектээр илтгэлээ сайжруулах хөдөлгөөнт товч.
- Видео камер ашиглан видео илтгэл бүтээнэ.
- Microsoft Movie Maker буюу кино бүтээгч ашиглаж сурна
  - Зурах болон будах арга хэрэгсэл ашиглан мультимедиа илтгэл бүтээх
- Дижитал аппарат ашиглан зураг авч, засварлах, Adobe Creative Cloud ашиглан илтгэл хийнэ.
- Сканераар зураг оруулж, илтгэлд ашиглана.

### **Мультимедиа технологи II Улирал (16609)**

Сурагчид дараах ур чадварт суралцана

- HTML, төрөл бүрийн цахим хуудас үүсгэх программ хангамж болон интернет сайтууд ашиглан, цахим хуудас зохион бүтээнэ.
- Бусад хуудас, сайт болон программ хангамж руу hypertext холбоос үүсгэх (PowerPoint, Excel, Word, гэх мэт.)
- Мультимедиа болон DTP салбарт ажил мэргэжил судлах.

## **АНГЛИ ХЭЛ, СОЁЛ**

### **Олон нийтийн илтгэл судлал Улирал (11301)**

Сурагчид илтгэл тавихтай холбоотой бэлтгэх, хүргэх болон үнэлэх зэрэг бүхий элементүүдийг давтаж үзэх ба үүнд

- Судална, зохион байгуулна, илтгэлийн тойм гаргана.
- Гэнэтийн болон цаг үеийн үг хэлэх арга техникээ хөгжүүлнэ.
- Тойм гаргасан болон бэлтгэсэн үг хэлнэ.

- Өндөр үр дүнтэй харилцаа, хошин мэдрэмжтэй байдал, эшлэл, үзүүлэн, график мэдээллийн техникүүдээ хөгжүүлэх
- Илүү үр дүнтэй хүргэхийн тулд ярианы чадварт суралцана

## ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ

### STEAM суурь, Улирал (18482)

STEAM суурь хичээл нь жилийн турш бодит амьдралд хэрэгжих төсөлд таван салбарыг (шинжлэх ухаан, технологи, инженеринг, урлаг, математик) багтаан оруулсан хичээл юм. Сурагчид өрсөлдөөнт болон хамтын ажиллагаа шаардсан үйл ажиллагаагаар асуудал шийдвэрлэхэд суралцана. Математик болон шинжлэх ухааны ур чадварууд эдгээр үйл ажиллагаанд шигтгэгдсэн байна. Сурагчид барилга байгууламж, тээвэрлэлтийн систем, цахилгаан болон эрчим хүчний систем зэргийг төсөөлөн бодож, загвар гарган, бүтээх, технологийн тэмцээнд өрсөлдөх сорилын улмаас инженерингийн дизайн цикл болон судалгаа хийх шинжлэх ухааны аргад суралцана. Хэлбэр, ажиллагааны уялдаа холбоог хангахын зэрэгцээ гоо үзэмжийн ач холбогдлыг мөн ойлгож авна. Хичээлийн туршид сурагчид өөрсдийгөө сорих, шийдэл/дизайн олох, түүнийг туршиж, зохион бүтээж, шаардлагатай өөрчлөлтийг хийж гүйцэтгэхэд шаардлагатай STEAM агуулгад суралцаж, даалгасан сорилуудыг гүйцэтгэх болно.

Сурагчид дараах дөрвөн чиглэлийн үндсэн үйл ажиллагааны ойлголттой болно:

Чиглүүлсэн хүрээний судалгаа, урлаг ба дизайн, технологи бүтээмж ба инженерингийн хэрэглээ. Эдгээрийг STEAM-ийн таван салбарын (шинжлэх ухаан, технологи, инженеринг, урлаг, математик) хүрээнд болон асуудалд суурилсан заах арга зүйн хүрээнд хүргэнэ.

### 8-р анги

## ЭРҮҮЛ МЭНД БОЛОН БИЕ БЯЛДРЫН БОЛОВСРОЛ

### 8-р анги Эрүүл мэнд болон бие бялдрын боловсрол/Бүжиг 8 Бүтэн жил (17205)

8-р ангийн бүх сурагчид эрүүл мэнд болон бие бялдрын боловсролын хөтөлбөрт хамрагдана. Энэ хичээлийн бүжгийн хэсэг нь бүжигт илүү анхаарах байдлаар Виржиния мужийн биеийн тамирын боловсролын стандартыг хангах боломж олгоно. Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр нь эрүүл амьдралын хэв маягийг эзэмшихэд сурагчид мэдэх, ойлгох, хийх хэрэгцээ шаардлагыг онцолно. Судлах сэдвүүдэд сэтгэл зүйн, сэтгэл мэдрэлийн, нийгмийн болон орчны эрүүл мэнд, аюулгүй байдал болон

онцгой байдалд бэлэн байх, харилцаа, мансууруулах бодисын хэрэглээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гэр бүлийн амьдралын боловсрол зэрэг багтана.

8-р ангийн Эрүүл мэнд болон бие бялдрын боловсролын хичээлийн зорилго дээр нэмээд сурагчид

- Бүжгийн элементүүд ашиглан богино хэмжээний бүжиг дэглэнэ.
- Балет, жааз, орчин үеийн бүжиг, хип хоп бүжгийн үндэс суурийг ойлгож, харуулна.
- Үзэгчдийн өмнө бүжгийн үзүүлбэр үзүүлнэ.
- Хөгжмийн хэмнэлд тэнцвэр хөдөлгөөнөө нийцүүлж үзүүлнэ.
- Соёлын бүжиг хийж үзүүлнэ.

## УРЛАГИЙН БОЛОВСРОЛ

### Дүрслэх урлаг III, Бүтэн жил (19118)

Энэ хичээл нь дүрслэх урлаг судлахаар бүрэн шийдсэн, маш их сонирхол эрмэлзэлтэй урлагийн сурагчдад зориулагдсан. Сурагчид Дүрслэх урлаг I болон II хичээлүүдэд сурсан ур чадвар дээрээ тулгуурлан хоёр буюу гурван хэмжээст төрөл бүрийн туршлага, төслүүдэд оролцоно. Урлагийн компьютерын лабораторийг бүтээлч ажилд хувь нэмэр болох арга хэрэгсэл болгон ашиглана. Үзэгдэх байдал болон хэлбэр дүрс дээр онцгой ач холбогдол өгнө. Сурагчид даалгасан дизайны асуудлаас урган гарсан эсхүл түүнтэй төстэй зорилго болон санаа бүхий бүтээлийг бүтээсэн урлаачийг судлах замаар Урлагийн түүх орно. Сурагчид өөрийн санааг тэмдэглэх таталбар зургийн дэвтэртэй байна. Дүрслэх урлаг III хичээлийн таталбар зураг зурах даалгавар нь бүтээлч сэтгэлгээг сэдэрэх зорилготойн зэрэгцээ зураасны жин, үнэ цэнэ зэрэгт анхаарч зургийн арга техникийн сайн дадал эзэмшүүлнэ. Сурагчид мөн өөрийн бүтээлийн портфолио үргэлжлүүлэн хийнэ.

Сурагчид дараахад суралцана:

- Урлагийн элементийн үр нөлөө, түүний зарчмыг шинжилнэ.
- Өөрийн болон бусдын бүтээлд зохих нэр томъёог ашиглан бичгээр болон амаар шүүмж өгнө.
- Ажиглалт болон тайлбарт үндэслэн урлагийн бүтээлийн талаар утга учиртай асуулт асууна.
- Дүрслэлээр мэдээлэл болон санааг ойлгуулна.
- Зургийн элементүүд болон дизайны зарчмуудыг хоёр болон гурван хэмжээст урлагийн бүтээлд ашиглах.
- Тодорхой өнгөний албан харилцааг тодотгосон урлагийн бүтээл туурвина.
- Төрөл бүрийн сэдэв болон үйл явцыг ашиглан гурван хэмжээст бүтээл бүтээнэ.



- Хоёр хэмжээст зурагт зузааныг илэрхий болгон дүрсэлнэ.
- Урлагийн бүтээлийн портфолио үүсгэн баяжуулна.
- Сургуульд байнга байршуулах үзмэрийн бүтээл дээр багаар ажиллана.

## **БИЗНЕС БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ**

### **Мультимедиа технологи, I Улирал (16606)**

Сурагчид үндсэн хичээлүүддээ зориулан дуу, график болон дижитал дүрс бичлэг ашигласан мультимедиа болон DTP илтгэлүүд хийж сурна.

Сурагчид дараахад суралцана:

- Microsoft Office болон Adobe программ хангамжуудыг ашиглан анхан шатны компьютерт хэвлэн нийтлэх чадвар эзэмшинэ.
- Интернэт ашиглах ур чадвар, техникт суралцана.
- Компьютер дээр технологийн анхан шатны чадварт суралцана.
- Програмчлалын (код бичих) талаар ойлголт авна:
  - Өгүүлэх самбар буюу Storyboards (энэ нь юу болох, яах гэж ашигладаг, хэрхэн үүсгэдэг тухай).
  - Хялбар хөдөлгөөнт дүрс болон дүрслэл эффектээр илтгэлээ сайжруулах хөдөлгөөнт товч.
- Видео камер ашиглан видео илтгэл бүтээнэ.
- Microsoft Movie Maker буюу кино бүтээгч ашиглаж сурна:
  - Зурах болон будах арга хэрэгсэл ашиглан мультимедиа илтгэл бүтээнэ.
- Дижитал аппарат ашиглан зураг авч, засварлах, Adobe Creative Cloud ашиглан илтгэл хийнэ.
- Сканераар зураг оруулж, илтгэлд ашиглана.

### **Мультимедиа технологи II, Улирал (16609)**

Сурагчид дараахад суралцана:

- HTML, төрөл бүрийн цахим хуудас үүсгэх программ хангамж болон интернэт сайтууд ашиглан, цахим хуудас зохион бүтээнэ.
- Бусад хуудас, сайт болон программ хангамж руу hypertext холбоос үүсгэх (PowerPoint, Excel, Word, гэх мэт.)
- Мультимедиа болон DTP салбарт ажил мэргэжил судлах.

## **АНГЛИ ХЭЛ**

### **Олон нийтийн илтгэл судлал, Улирал (11301)**

Сурагчид илгээлт хийхтэй холбоотой бэлтгэл, илтгэл болон дүгнэлт зэрэг бүхий элементийг давтаж үзнэ. Үүний тулд:

- Судална, зохион байгуулна, илтгэлийн тойм гаргана.

- Гэнэтийн болон цаг үеийн үг хэлэх арга техникээ хөгжүүлнэ.
- Тойм гаргасан болон бэлтгэсэн үг хэлнэ.
- Өндөр үр дүнтэй харилцаа, хошин мэдрэмжтэй байдал, эшлэл, үзүүлэн, график мэдээллийн техникүүдээ хөгжүүлэх
- Илүү үр дүнтэй хүргэхийн тулд ярианы чадварт суралцана

## **ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ**

### **STEAM хэрэглээ, Улирал (18258)**

STEAM хэрэглээ хичээл нь улирлын турш бодит амьдралд хэрэгжих төсөлд таван салбарыг (шинжлэх ухаан, технологи, инженеринг, урлаг, математик) багтаан оруулсан хичээл юм. Энэ хичээлээр сурагчид бие даан олон нийтийн төсөл хэрэгжүүлэх эсхүл бүс нутгийн болон улсын тэмцээнд уралдаанд оролцоход нь багш орон зай, нөөц, туслалцаа дэмжлэгээр хангана. Сурагчид суурь хичээлээр сурсан инженерингийн дизайн цикл болон судалгаа хийх шинжлэх ухааны аргыг тэмцээн уралдаан эсхүл олон нийтийн хэрэгцээ шаардлагаас үүдэн гарсан бодит асуудлыг шийдвэрлэхэд хэрэглэнэ. Эдгээр сорилыг давахын тулд сурагчид дараах дөрвөн чиглэлээр үйл ажиллагааны үндсэн ойлголт авна: Суурь хичээлээр сурсан чиглүүлсэн хүрээний судалгаа, урлаг ба дизайн, технологи бүтээмж ба инженерингийн хэрэглээ. Сурагчид өөрийн сорилыг дуусгахад шаардлагатай математик болон шинжлэх ухааны чадварт суралцана.

### Дэлхийн хэлний сонгон суралцах хичээл

Дэлхийн хэлнүүдийн танилцуулга хичээлүүд нь ахлах сургуулийн кредит авах хичээлд суухаар шийдэхийн өмнө тухайн дэлхийн хэлтэй харьцаж үзэх боломжийг олгохоор төлөвлөгдсөн. Энэ нь зорилтот хэлний бүтцийн болон соёлын суурийг тавьж ахлах сургуулийн төгсөлтийн шаардлагыг хангах сонгосон хэлээ судлахдаа илүү их амжилт гаргахад нь тусална. Оролцохын тулд сурагчид өөрийн ангийн эсхүл түүнээс дээш түвшинд уншдаг байх ёстой. Өөрийн хүүхдийн зөвлөхтэй уулзаж илүү мэдээлэл аваарай.

#### **6-р анги Дэлхийн хэл танилцуулах хичээлүүд:**

Доорх боломжуудын нэгийг сонгосон сурагчид өөрийн сонгосон Ажлын хэлний нэг улирлын хичээлийг нэг улирлын Унших хичээлтэй хослуулан авна.

#### **Франц хэлний танилцуулга (15101)**

##### **Улирлын хичээл**

Сурагчид тухайн хэлний талаар ойлголт авч, дараах үндсэн харилцааны ур чадварыг эзэмшинэ: ойлгох, асуух, өөрийн тухай асуултад хариулах, цээжилсэн үг хэллэгийг ашиглан бусадтай харилцах, мэндчилгээ, өнгө, тоо болон хоол зэрэгтэй холбоотой үг хэллэгийг ойлгож, ашиглах. Хичээлээр сурагчид ахлах ангид кредит авах хичээлд суухаас өмнө бэлтгэл болгож тухайн хэлний талаар ойлголт авна. Сурагчид ахлах сургуульд сонгосон хэлээ амжилттай сурах боломжийг олгохын тулд холбогдох хэлний талаар суурь ойлголтыг өгөх болно.

#### **Латин хэлний танилцуулга (15301)**

##### **Улирлын хичээл**

Сурагчид Латин хэлтэй болон Ром хүмүүсийн амьдралтай танилцана. Хэлний талаарх үндсэн онолуудыг танилцуулж, сурагчид Латин хэлний үгсийн сангаа эхлүүлнэ. Латин хэлнээс үүссэн үгэнд онцгой анхаарал хандуулна.

#### **Анхан шатны Испани хэл (15501)**

##### **Улирлын хичээл**

Сурагчид тухайн хэлний талаар ойлголт авч, дараах үндсэн харилцааны ур чадварыг эзэмшинэ: ойлгох, асуух, өөрийн тухай асуултад хариулах, цээжилсэн үг хэллэгийг ашиглан бусадтай харилцах, мэндчилгээ, өнгө, тоо болон хоол зэрэгтэй холбоотой үг хэллэгийг ойлгож, ашиглах. Хичээлээр сурагчид ахлах ангид кредит авах хичээлд суухаас өмнө бэлтгэл болгож тухайн хэлний талаар ойлголт авна. Сурагчид ахлах сургуульд сонгосон хэлээ амжилттай сурах боломжийг олгохын тулд холбогдох хэлний талаар суурь ойлголтыг өгөх болно.

## ТУСГАЙ СУРАГЧИД

### Тусгай боловсролын үйлчилгээ авах сурагчид

Дунд сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад заах арга зүйн нь холбооны болон мужийн хууль тогтоомжид нийцсэн байна. Тусгай боловсрол нь хөгжлийн бэрхшээлийн улмаас тусгай зааварчилгаа шаардлагатай сурагчдад зориулсан үйлчилгээнээс бүрдэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчид Тусгайлсан боловсролын хөтөлбөр (IEP)-т суурилсан байдлаар, аль болох чөлөөтэй орчинд үйлчилгээ авна. IEP-т шаардлагатай үйлчилгээ, аливаа тусгай үйлчилгээ болон/эсхүл хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг өөрчлөх болон байршуулах талаар заасан байна.

### Англи хэл сурагч (EL) үйлчилгээ авах сурагчид

Англи хэл сурагч (EL) үйлчилгээ нь EL гэж тодорхойлогдсон сурагчдад үзүүлэх үйлчилгээ юм. Англи хэл хөгжүүлэх (ELD) сургалтын хөтөлбөрийг WIDA Англи хэл мэргэшлийн стандарт болон Виржиния мужийн суралцах стандартад нийцүүлсэн.

Англи хэлний мэргэшил (ELP)-ийн 1 эсхүл 2-р түвшинд тодорхойлогдсон сурагчид мэргэжлийн ESL багшийн хамт уншлага/хэлний урлаг (хоёр үе бүхий блок) хичээлүүдийг судалдаг. Сурагчид ESL багштай эсхүл хамтран заадаг ангид шинжлэх ухаан болон нийгэм судлалын хичээл судалж, ерөнхий боловсролын сонгон суралцах хичээл болон бие бялдрын боловсролын хичээлд оролцоно. Сурагчдын бэлэн байдалд нь суурилан математикийн хичээл санал болгодог.

Англи хэлний мэргэшил (ELP)-ийн 3 эсхүл 4-р түвшинд тодорхойлогдсон сурагчид мэргэжлийн ESL багшийн хамт уншлага/хэлний урлаг (хоёр цаг) хичээлүүдийг судалдаг. Сурагчид ерөнхий боловсролын багштай эсхүл хамтран заадаг ангид шинжлэх ухаан болон нийгэм судлалын хичээл судалж, ерөнхий боловсролын сонгон суралцах хичээл болон бие бялдрын боловсролын хичээлд оролцоно. Сурагчдын бэлэн байдалд нь суурилан математикийн хичээл санал болгодог.

Англи хэл суралцагч (EL) гэж тодорхойлогдсон сурагчид дараагийн түвшин рүү ELL-д зориулсан WIDA ACCESS шалгалтын оноо дээр үндэслэн шилжинэ. Сурагчдыг ахиулах нэмэлтээр харгалзан үзэх хүчин зүйлсэд уншлагын түүх, SOL оноо, зохион бичлэгүүд болон/эсхүл багшийн санал зэрэг орно.

ELD 1 Англи хэл 10786

ELD 2 Англи хэл 10790

ELD 1 Уншлага 10787

ELD 2 Уншлага 10791

ELD 1 Шинжлэх ухаан 10780

ELD 2 Шинжлэх ухаан 10781

ELD Математик (10880)

ELD 1 10789 (1-р түвшний анхан шатны SOL түүхийн хичээл аваагүй сурагчдад зориулсан сонголт)

ELD 1-2 U.S. Өнөө үе хүртэлх АНУ-ын түүх 10800

ELD 1-2 Иргэний эрх, 10801

ELD 3 Англи хэл 10796

ELD 4 Англи хэл 10799

ELD 3 Уншлага 10794

ELD 4 Уншлага 10797

ELD 3-4 АНУ-ын 1865 он хүртэлх түүх, иргэний эрх болон эдийн засаг 10795

ELD 3-4 АНУ-ын 1865 оноос өнөөг хүртэлх түүх, иргэний эрх болон эдийн засаг 10798

## ГОЦ АВЬЯАСТАЙ СУРАГЧДАД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хамтран ажиллах багийн загвар нь гоц авьяастай сурагчдад үзүүлэх үйлчилгээг хүргэх загвар юм. Гоц авьяастайд тооцогдох сурагчдыг 5-8-р группт хуваарилах бөгөөд Англи хэлний урлаг, шинжлэх ухаан болон нийгэм судлалын холимог анги дотор олж тогтоосон чиглэлээр нь ангилна. Дунд сургууль бүрд бүтэн цагаар ажиллах гоц авьяастай хүүхдийн харилцах багш (RTG) байна. Хамтран ажиллах багийн загварын хүрээнд RTG болон багийн багш нар тогтмол төрөл бүрийн арга замаар өдөр тутмын ялгах арга хэмжээг төлөвлөнө: Ахисан түвшний суралцагчдын шилдэг туршлагын гарын авлагад тусгагдсан сургалтын хөтөлбөрөөс хэрэгжүүлэх; сэдэв болон хичээлүүдэд илүү эрчимжүүлсэн, гүнзгийрүүлсэн болон хүндрүүлсэн хэлбэрээр үргэлжлүүлэх зорилгоор шүүмжит болон бүтээлч сэтгэлгээгээр тодорхойлсон стратегиудыг ашиглах; урьдчилсан шалгалт авах болон сургалтын хөтөлбөрийг шахах замаар хичээлийг ялгах, уян хатнаар багт хуваах, сурагчийн дуу хоолой болон сонголтыг сонсох, ялгавартай шат дараатай даалгавар өгөх, төсөл болон төсөлд суурилсан суралцах арга зам, хувьчилсан суралцах арга барил, бие даасан судалгаа болон/эсхүл судалгааны төслүүд.

Бэлэн болох нь илэрхий сурагчдад математикийн хичээлээр ахлах сургуулийн кредит авах ахисан шатны ялгавартай агуулга авах нэмэлт боломжууд олгодог. Туршлагатай математикийн багш нарын баг уулзаж нийт сурагчдад зориулсан математикийн хичээлийг санал болгодог. Тус баг сурагчдын агуулгын талаарх мэдлэг, үндэслэлийг тогтоох чадвар, заавар зөвлөгөө авах чадвартай холбоотой олон хэмжигдэхүүнийг харгалзан үздэг. Энэ өгөгдлийг одоогийн математикийн багшийн саналын хамт харгалзан үзнэ. Гоц авьяастай гэж тодорхойлогдсон сурагчдыг түргэвчилсэн хэлбэрээр зургаадугаар ангид 6-р ангийн сурагчдад зориулсан Алгебрын бэлтгэл, долоодугаар ангид 7-р ангийн сурагчдад зориулсан Алгебрын бэлтгэл, долоо болон наймдугаар ангид гүнзгийрүүлсэн Алгебр, эсхүл наймдугаар ангид геометр оруулж болно. Бэлэн болсон бүх сурагчид түргэвчилсэн хэлбэрээр суралцах боломжтой.

Гоц авьяастай гэж тодорхойлогдсон эсхүл маш өндөр чадамжтай дунд сургуулийн сурагчдын авч болох ахлах сургуулийн кредит авах боломжтой бусад хичээлүүд нь Дэлхийн газар зүй, Латин хэл I ба II, Испани хэл I ба II, Франц хэл I ба II мөн компьютерын шинжлэх ухаан судлал юм. Наймдугаар ангийн сурагчид Ажил мэргэжлийн төв дээр Arlington Tech сургуулийн нэгдүгээр ангид элсэн суралцах өргөдөл гаргах боломжтой. Тэд мөн бүс нутгийн Виржиния мужийн засаг даргын сургуульд хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэн суралцах өргөдөл гаргах боломжтой (Шинжлэх ухаан, технологийн Thomas Jefferson ахлах сургууль, Виржиния мужийн Annandale хотноо байрладаг, Виржиния мужийн Fairfax дүүргийн улсын сургуулиудын доор үйл ажиллагаа явуулдаг).

Урлагийн болон хөгжмийн багш нар сурагчидтай шууд ажиллаж, тухайн сурагчдад тохирсон ялгавартай байдлаар заадаг. Шалгуурт нийцсэн сурагчид хамтлаг, хоор болон оркестрын салбарт гүнзгийрүүлсэн хэлбэрийг сонгох боломжтой.

Дунд сургууль бүр эцэг эхчүүдэд зориулан Гоц авьяастай сурагчдын үйлчилгээний мэдээлэл өгөх өдөрлөг зохион байгуулж, үйлчилгээг хэрхэн хэрэгжүүлдэг тухай болон/эсхүл шалгах болон санал болгох үйл явцыг танилцуулдаг.

## НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Сургуулийн номын сан сургуулийн заах болон суралцах үйл явцын гол цөм нь байна. Номын санч нь бүх сурагчдын оюуны, сэтгэл хөдлөл, нийгмийн хөгжлийн бие даан унших, суралцах хэвлэмэл болон дижитал нөөцийг бүрдүүлдэг. Сурагчдад шүүмжит болон бүтээлч сэтгэлгээ, харилцаа болон хамтран ажиллах ур чадварыг заах бөгөөд ингэснээр тэд амьдралынхаа туршид мэдээлэл амжилттай ашиглагчид болох юм. Номын санч шинэчлэгдсэн сантай байх бөгөөд тэдгээрт сургуулиасаа болон гэрээсээ хандах боломжтой байхын зэрэгцээ сургалтын хөтөлбөрийн болон хөгжлийн хэрэгцээг харгалзан үзсэн нийгмийн, соёлын болон ёс зүйн олон талт байдлыг тусгасан байна.

Сургуулийн номын санч сурагчдад төрөл бүрийн хичээлийн агуулгын хүрээнд тухайн агуулгын хичээлийн багш нартай хамтран, суралцах төрөл бүрийн арга хэлбэрт тохирсон мэдээлэл олох, тэдгээрийг дүгнэх, нийцүүлэн ашиглах зэргийг заана.

Сурагчид мэдээлэл олох, зохион байгуулалтад оруулах, баримтжуулах, шинжлэх, дүгнэх, боловсруулах, танилцуулахын тулд номын сангийн хэвлэмэл болон дижитал материалыг ашиглана. Сурагчид мэдээллийг зохистой ашиглахдаа Ёс зүйн дүрмийг болон Хүлээн зөвшөөрсөн хэрэглээний журмыг мөрдөнө. Номын санч мөн түүнчлэн ажилтнуудтай хамтран ажиллаж сургалтын хөтөлбөр болон тусгай хөтөлбөр боловсруулна. Сургуулийн номын сан уртасгасан цагаар ажиллаж, сурагчдын суралцах боломжийг нэмэгдүүлнэ.

Сурагчид болон тэдний гэр бүл сургуульд болон гэртээ сургуулийн номын сангийн цахим хуудсаар болон Canvas дахь APS номын сангийн үйлчилгээний эх сурвалжаар дамжуулан номын сангийн нөөцийг ашиглахыг уриалж байна.

## **СУРГУУЛИАС ГАДУУРХ СПОРТЫН ХӨТӨЛБӨР**

Хот доторх болон сургууль хоорондын спортын хөтөлбөрүүд нь боловсролын хөтөлбөрийн салшгүй нэг хэсэг. Эдгээр хөтөлбөр нь бие бялдрын боловсролын хөтөлбөрийн өсөлтийг хангадаг. Тэд сурагчдыг өөрсийн сургуулийн, нийгмийнхээ үнэт гишүүн байх боломжийг хангахад туслах замаар сурагчдын бие бялдрын, оюун санааны, сэтгэл зүйн болон нийгмийн хэрэгцээг хангахад хувь нэмэр оруулдаг.

Хот доторх хөтөлбөр сургуулийн дараа Даваа, Мягмар, Лхагва болон Пүрэв гаригуудад 14:50-аас 16:00 цагийн хооронд явагддаг. Сургууль даяарх оролцоо нь гол зорилт болдог; иймд, бүх сурагчид хот доторх төрөл бүрийн арга хэмжээнд оролцох эрхтэй. Эцсийн арга хэмжээ нь бусад хот доторх арга хэмжээтэй харьцуулахад илүү зохион байгуулалттай үйл ажиллагаа юм. Уг арга хэмжээг хүйсээр ялган сургууль хоорондын тэмцээн хэлбэрээр зохион байгуулдаг (сургууль бүр бусад сургуулиуд бүртэй нэг удаа өрсөлдөнө)

Дунд сургуулийн сургууль хоорондын спортын хөтөлбөрөөр сурагчдад сэлэлт, эрэгтэй болон эмэгтэй хөл бөмбөг, теннис, сагсан бөмбөг, бөх, ултимейт, хөнгөн атлетик зэрэг тэмцээнд оролцох боломж олгодог. Оролцохын тулд одоогийн биеийн байдлын үзлэгт орсон байх хэрэгтэй бөгөөд Арлингтоны улсын сургуулиудын Тамирчны гэрээг байгуулсан байх хэрэгтэй.

### **НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН ӨСӨЛТ**

Дунд сургууль бүр өсвөр насныхны нийгмийн болон сэтгэл зүйн өсөлтийг тодорхой үйл ажиллагаагаар болон боломжит үйлчилгээ, зааварчилгаа өгөх дадлага болон байгууллагаар дамжуулан дэмжлэг үзүүлнэ. Том сургуульд үл үзэгдэгч мэт байх мэдрэмж төрүүлэхээс сэргийлж, сурагчдыг багт хуваарилна (ангийн түвшинд, анги-, эсхүл хөтөлбөрийн түвшинд –түвшин). Цөөн хүнтэй “нийгэм” нь сурагчдад тухайн газарт байх ёстой мэдрэмж төрүүлж, илүү их өөртөө итгэх итгэл төрүүлдэг, энэ нь тэдэнд хичээлийн хувьд болон нийгэм, сэтгэл зүйн хувьд өсөх боломж бүрдүүлдэг. Багш нар мөн өсвөр насныхны суралцах үйл ажиллагаагаа төлөвлөх явцад тэдний нийгмийн болон сэтгэл зүйн хэрэгцээг харгалзан үзнэ. Сурагчдад жижиг багаар ажиллах, хамтран ажиллах, өөрсдийнх нь сонирхол болон чадварыг хөгжүүлэх даалгавар сонгох олон боломж гарна. Дунд сургуулийн сурагчийн мөн чанарт ийнхүү анхаарал хандуулснаар сурагч тус бүр хичээл хийхийн зэрэгцээ сэтгэл зүйн хувьд болон нийгмийн харилцааны хувьд өсөх боломж бүрдэнэ.

### **БАГШ ЗӨВЛӨХИЙН ХӨТӨЛБӨР**

Дунд сургуулийн сурагч бүр багш зөвлөхийн (Т/А) багт хуваарилагдана. Эдгээр жижиг багууд сургуулийн долоо хоногийн туршид хуваарилагдсан ажилтнуудтай үе үе уулзаж, нийгмийн болон сэтгэл зүйн тодорхой сэдэв болон үйл ажиллагаа дээр хамтран ажиллаж, сургуульдаа болон сургуулиас ирж буй шаардлагуудад дасан зохицоход тусална. Зарим арга хэмжээг дурдвал шинэ сургуулийн чиглүүлэх өдөрлөг (шүүгээг хэрхэн нээхээс эхлээд заал руу хэрхэн очих), шинэ болон хуучин нөхөрлөл, суралцах чадвар, зан чанарын боловсрол болон ахлах сургуулийн бэлтгэл. Хамгийн чухал нь Багш зөвлөх нь тухайн сурагчийг сайн мэддэг тухайн сургуульд байдаг насан хүрэгч байх бөгөөд аливаа асуулт, асуудалтай тулгарвал сурагч түүнд хандах юм. Т/А багууд нь сурагчдад дунд сургуулийн асар том орчинд "үүр" бий болгох боломжийг бүрдүүлдэг.

### **СУРАГЧДАД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

Сурагчийн үйлчилгээ гэсэн Сургуулийн туслах албанд зөвлөх, сургуулийн сэтгэлзүйч, сургуулийн нийгмийн ажилтан, ирцийн мэргэжилтэн, мансууруулах, согтууруулах эм бэлдмэл хэтрүүлэн хэрэглэхтэй тэмцэх зөвлөх багтана. Энэ газар сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээтэй хамтран ажиллаж, нягт харилцаатай байна. Олон салбарын баг загварыг дунд сургуулийн сурагчийн нийгмийн болон сэтгэл зүйн өсөлтийг дэмжихэд туслах зорилгоор ашигладаг. Зөвлөхүүд сургуулиуд дээр байрладаг бол бусад ажилтнууд долоо хоног бүрийн тодорхой өдрүүдэд сургуулиудаар хуваарилагддаг.

### **ТУСГАЙ БОЛОВСРОЛЫН ГАЗАР**

Тусгай боловсрол хариуцсан сургалтын дэмжлэгийн алба Амьдрах чадварын функциональ хөтөлбөрт дараах хичээлийг санал болгоно. Сургалтын агуулга нь сурагчийн Хувьчилсан заах аргазүйн хөтөлбөр (ХЗХ)-т тусгасан хэрэгцээ шаардлагын дагуу байх бөгөөд Виржиния мужийн өөр хэлбэрээр үнэлэх хөтөлбөр (ВМӨХҮХ)-ийг дэмжлэг Нийцүүлсэн суралцах стандартын дагуу байна. Сургалтын хөтөлбөр нь харилцаа, өөртөө туслах, нийгэмших ур чадвар, мэргэжлийн бэлтгэл ур чадвар болон суралцах ур чадвар зэрэгт амьдралын ур чадварыг хөгжүүлэхэд анхаарна. Сургууль болон олон нийт зэрэг төрөл бүрийн байдаг л орчинд заавар зөвлөгөөг өгнө.

### **Англи хэл (10035)**

Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Хичээл нь богино өгүүллэг, шүлэг болон роман ашиглан уншиж ойлгох, зөв бичих, үгсийн сан ашиглах, өгүүлбэрийн бүтэц, догол мөр бүтээх, уран зохиол судлах зэрэгт анхаарна. Материал болон сурах бичгийг сурагчийн унших түвшинд нийцүүлэн сонгоно.

### **Математик (10036)**

Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Хичээл нь бүхэл тоо, бутархай, аравт, харьцаа, пропорц, хувь, хэмжигдэхүүн болон функц зэргийг оруулсан үйлдлийг гүйцэтгэхэд анхаарна.

### **Нийгэм судлал (10039)**

Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн.

### **Шинжлэх ухаан (10038)**

Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн.

### **Уншлага (10014)**

Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Хичээл нь тухайн сурагчийн үзүүлсэн унших хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Түүнчлэн тодорхой ур чадварыг эзэмшихийн тулд таалан унших болон ойлгож унших шаардлагатай бөгөөд ангиас гадуурх материал ашиглахыг онцолно.

## **ГЭРТЭЭ БАЙХ ЧӨЛӨӨ АВАХ ЗААВАР**

Эрүүл мэндийн шалтгаанаар, тухайлбал, сэтгэл мэдрэлийн нөхцөл байдлаас сургуульд явах боломжгүй сурагчид гэртээ байх чөлөө эдлэх боломжтой байж болзошгүй. Гэртээ байх чөлөө авах өргөдлийг APS цахим хуудаснаа нийтэлсэн байгаа, <https://www.apsva.us/special-education/homebound-instruction/>. Өргөдлийн хувийн аль ч APS сургууль авах хүсэлт гаргаж болно. Өргөдлийг сурагчийн сургуульд хянуулахаар өгсний дараагаар Тусгай боловсролын газарт хүргүүлнэ. Гэртээ байх чөлөөг зөвшөөрсний дараа IEP багийн уулзалтыг хийж, шаардагдах үйлчилгээг тодорхойлно. Бүхий л тохиолдолд чөлөө авах шалгуур хангасан байдлыг есөн долоо хоног бүр нягталдаг.

## **СУРАГЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Сурагчдад клуб, сурагчийн засаглал, бусад байгууллагууд зэрэг нийгмийн болон сэтгэл зүйн хувьд өсөх олон боломжууд бий. Ихэвчлэн эдгээр багууд сургуулийн дараа уулздаг. Сурагчдыг оролцохыг уриалах бөгөөд гишүүнчлэлд аливаа хязгаарлалт байхгүй.

## **ГЭР/СУРГУУЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХАРИЛЦАА**

Дунд сургуулийн сурагч оюуны, нийгэмшлийн, сэтгэл зүйл болон бие бялдрын хувьд өсөхийн тулд гэр болон сургууль нь сурагчийн сонирхлын төлөө хамтран ажиллах шаардлагатай. Хамтран ажиллахын тулд эцэг эх/асран хамгаалагч, багш нар болон ажилтнууд хоорондоо харилцах шаардлагатай. Албан болон албан бус харилцааны олон арга зам бий.

### **Эцэг эх/асран хамгаалагчид тайлагнах нь**

Есдүгээр сард эцэг эхчүүдэд тараан өгч нийтлэгдсэн хуваарийн дагуу есөн долоон хоногийн дүгнэх хугацааны төгсгөлд дүнгийн картыг сурагчид хүлээн авна. Дөрвөн удаагийн дүгнэх хугацааны дунд үед сурагч бүр дунд хугацааны тайланг өөрийн үндсэн багш нарын багаас авах ба үүнд сурагчийн одоогийн гаргаж буй ахицыг заасан байна. Сонгон суралцах/танилцуулах хичээлийн багш нар мөн дунд хугацааны тайлан өгөх ба үүнд хангалтгүй

ажилласан, муу дүнтэй, өөрийн чадвараас хамаагүй доогуур ажилласан болохыг тэмдэглэнэ. Эцэг эхчүүдэд тайлагнах эдгээр албан арга замын зэрэгцээ олон баг болон багш нар гэрт нь илгээдэг мэдээний захидал, зурвас болон сурагчийн ажлаар харилцдаг.

### **Бага хурлууд**

Намар болон хавар тусгай сурагчгүй өдөр зохион байгуулдаг багш нарын төлөөлөлтэй хийх бага хуралд бүх гэр бүлүүдийг урьж байна. Түүнчлэн эцэг эх/асран хамгаалагч эсхүл багц хүссэн цагтаа хүүхдийн гаргаж буй ахицын талаар хурал хийх хүсэлт тавьж болно. Эцэг эх/асран хамгаалагч сурагчийн үндсэн багтай тухайн сурагчийн талаар хэлэлцэх уулзалт хийж болно. Ихэвчлэн зөвлөх эцэг эх/асран хамгаалагч/багш нарын бага хурал зохион байгуулдаг.

### **Дуудлага ба зурвас**

Эцэг эх/асран хамгаалагч сургалтын ахиц дэвшлийн талаар багшид (сургуулийн өдөр ихэвчлэн ангидаа байдаг) утсаар мессеж үлдээж эсвэл зурвас эсхүл э-мэйл илгээж, холбоо барьж болно. Багш нар аль болох хурдан хариу өгөхийг хичээнэ. Зөвлөх мэргэжилтнүүд сурагчийн сургалтын ахицтай хлобоотой асуулт эсвэл санал хүсэлтэд хариу өгч, багш нар болон эцэг эхийг хооронд нь холбох боломжтой.

### **Зочлох болон сайн дураар туслах**

Эцэг эх/асран хамгаалагчид сургуулийн үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцож, хэд хэдэн хэлбэрээр сурагчийнхаа орчныг илүү сайн таних боломжтой. Эцэг эх багш нарын холбоо (РТА) болон сайн дурын үйлчилгээ нь эцэг эхчүүд өөрийг сонирхол, идэвх зүтгэлийг харуулах арга зам юм. Эцэг эхчүүд эсхүл асран хамгаалагчид сурагчдын тоглолт, спортын арга хэмжээ, эсхүл тодорхой уулзалтуудад ирэхэд сурагчид маш их баярладаг. Учир нь энэ нь хувийн дэмжлэг үзүүлж буйн илрэл болдог.

## **ДУНД СУРГУУЛИЙН СТАНДАРТ ШАЛГАЛТУУД**

Виржиниягийн Боловсролын зөвлөлөөс 6, 7 болон 8-р ангийн уншлага, математик, түүх болон нийгэм судлалаар Сурагчдын стандарт (SOL)-ын шалгалтыг сурагчдаас авахыг шаарддаг. 8-р ангийн сурагчид бичих болон шинжлэх ухааны чиглэлээр шалгалт мөн өгнө. Алгебр эсвэл геометр эсхүл дэлхийн газар зүй хичээл авсан сурагчид тухайн сэдвээрээ SOL Хичээлийн төгсгөлийн шалгалт өгнө. SOL шалгалтууд нь Виржиния мужийн SOL-д нийцүүлсэн шалгуурыг лавлагаа болгон ашигласан шалгалтууд юм.

Ахлах сургуулийн бүх сурагчид диплом авах шалгуур хангахын тулд таваас доошгүй ахлах сургуулийн Хичээлийн төгсгөлийн шалгалт (EOC)-д тэнцсэн байх шаардлагатай. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах бол энэ баримт бичгийн доор байрлах Төгсөлтийн шаардлагууд хэсгийг харах буюу сурагчийнхаа зөвлөлтэй ярилцаарай.

### **Шалгалтын үр дүн**

Сурагчдын өгсөн шалгалтын дүнг шалгалтууд дуусахад эцэг эх рүү нь ParentVUE Порталаар илгээж эсвэл шуудангаар хүргүүлнэ. Арлингтоны сургуулиудын ерөнхий дүнг [www.apsva.us](http://www.apsva.us) гэсэн APS цахим хуудаснаа нийтэлнэ.

## **ДУНД СУРГУУЛЬД АХЛАХ СУРГУУЛИЙН КРЕДИТ АВАХ ХИЧЭЭЛҮҮД**

Сурагч дунд сургуульд байх хугацаандаа ахлах сургуулийн кредит авах хичээл авсан бол (тухайлбал, Алгебр, геометр, Араб хэл I/II, Хятад хэл I/II, Франц хэл I/II, Латин хэл I/II, Испани хэл I/II, Дэлхийн газар зүй, эсхүл компьютерын шинжлэх ухаан судлал), эцэг эх/асран хамгаалагчид дараах сонголтууд бий.

- Кредитийг (авсан тохиолдолд) ахлах сургуулийн төгсөлтийн шаардлага болгон ашиглаж, ахлах сургуулийн түвшинд хичээлийн эцсийн дүнг сурагчийн дүнгийн голчид оруулан тооцно.
- Хичээлийн эцсийн дүнг сурагчийн ахлах сургуулийн түвшинд голчийг тооцоход оруулахгүй бөгөөд кредитийг (авсан тохиолдолд) ахлах сургуулийг төгсөх шаардлагыг хангахад ашиглахгүй.

Эцэг эхчүүд энэ боломжийн талаарх мэдэгдлийг хүүхдийнхээ сүүлийн онооны картын хамт хүлээн авна. Хэрэв заасан хугацаанд дунд сургуулийн ажилтан эцэг эхээс тухайн хичээлийг хасах хүсэлт хүлээн аваагүй тохиолдолд,

цуглуулсан кредит болон авсан дүн нь ахлах сургуулийн бүртгэлд орох болно (Виржиниягийн итгэмжлэх стандартын дагуу).

Эцэг эх/асран хамгаалагч дунд сургуульд авсан ахлах сургуулийн кредиттэй хичээлийг тухайн сурагчийн ахлах сургуулийн гуравдугаар курс хүртэл дүнгийн хуулбарт оруулахгүй байх хүсэлт гаргаж болно.

### **АХЛАХ СУРГУУЛИЙН БОЛОМЖУУД**

Арлингтон улсын сургуулиудын ахлах сургууль нь сурагчдын оюуны болон нийгмийн/сэтгэл зүйн хэрэгцээг хангах цогц хөтөлбөрүүдийг явуулдаг. Цогц ахлах сургуулиудын зэрэгцээ Арлингтоны улсын сургуулиудад бусад хэд хэдэн боломжууд байдгийг гэр бүлүүд сонирхон танилцах боломжтой. Эдгээр боломжууд нь Н-В Woodlawn хөтөлбөр, Олон улсын бакалаврын хөтөлбөр, Сангийн Онц сурлагатны хөтөлбөр болон Шинжлэх ухаан, технологийн Thomas Jefferson ахлах сургууль зэрэг нь юм. STEM мэргэжил болон техникийн хичээлүүдийг Мэргэжлийн төвөөр дамжуулан Арлингтон ахлах сургуулийн сурагчид мөн авах боломжтой.

Ахлах сургуульд Олон улсын бакалаврын диплом авах сонирхолтой сурагчид 7-р ангидаа Испани, Франц, Хятад эсхүл Латин хэл I, 8-р ангидаа Испани, Франц, Хятад эсхүл Латин хэл II авах нь зүйтэй. Түүнчлэн тэд 8-р ангидаа Алгебр I хичээл авсан байх шаардлагатай. Зуны сургалтаар дамжуулан мөн зохицуулалт хийгдэх боломжтой.

Ахлах сургуулийн боломжуудын талаар илүү мэдээлэл авах бол дунд сургуулиуд дээрх Зөвлөх үйлчилгээний алба эсхүл Сургалтын тэнхимтэй холбогдоно уу.




**Ахлах сургуулийн сонголтууд**  
**Тайлбар: Эдгээр бүх сонголтод тээвэрлэлт шийдэгдсэн.**

<b>Хөтөлбөр</b>	<b>Байршил</b>	<b>Элсэлтийн журам</b>
Arlington Tech	Арлингтоны мэргэжлийн төв	<ul style="list-style-type: none"> <li>Одоо 8 эсхүл 9-р ангид аль нэг APS сургуульд суралцаж буй сурагч шилжих анкет бөглөн улс даяарх сугалаанд оролцох боломжтой.</li> <li>Арлингтон технологийн хөтөлбөрт элсэн орохын өмнө 9-р ангийн өргөдөл гаргагч Алгебр I дээр нэг баталгаажсан кредит авсан байх ёстой ба 10-р ангийн өргөдөл гаргагчид геометрт нэг баталгаажсан кредит авсан байх шаардлагатай.</li> <li>Хөтөлбөрийн талаар илүү мэдээлэл авах бол цахим хуудсаар нь зочилно уу  <a href="#">Arlington Технологийн хөтөлбөр</a></li> </ul>
Сангийн Онц сурлагатны хөтөлбөр	Wakefield ахлах сургууль	<ul style="list-style-type: none"> <li>Одоо 8-р ангид аль нэг APS сургуульд суралцаж буй сурагч шилжих анкет бөглөн элсэх боломжтой.</li> <li>Хөтөлбөрийн талаар болон шилжин суралцах үйл явцын талаар илүү мэдээлэл авах бол цахим хуудсаар нь зочилно уу  <a href="#">Wakefield дэх Нэгдүгээр курсийнхний сан</a></li> </ul>
H-B Woodlawn	H-B Woodlawn	<ul style="list-style-type: none"> <li>Одоо 8-р ангид аль нэг APS сургуульд суралцаж буй сурагч шилжих анкет бөглөн улс даяарх сугалаанд оролцох боломжтой.</li> <li>Хөтөлбөрийн талаар болон шилжин суралцах үйл явцын талаар илүү мэдээлэл авах бол цахим хуудсаар нь зочилно уу  <a href="#">H-B Woodlawn Хөтөлбөр</a></li> </ul>
Олон улсын бакалаврын зэргийн хөтөлбөр	Washington-Liberty ахлах сургууль	<p><b>W-L сургуулийн IB-ын өмнөх хөтөлбөрт тавигдах урьдчилсан шаардлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 8-р ангид Алгебр I эсхүл түүнээс дээш эсхүл 9-р ангид геометр эсхүл түүнээс дээш</li> <li>- 8-р ангид Араб хэл II, Хятад хэл II, Франц хэл II эсхүл Латин хэл II эсхүл Испани хэл II эсвэл 9-р ангид Араб хэл III, Хятад хэл III, Франц хэл III, Латин хэл III эсхүл Испани хэл II</li> <li>- Бүх хичээлд A болон B үнэлгээтэй</li> <li>- Богино хариутай/эсээ асуултууд</li> <li>• Washington-Liberty сургуульд хамрагдах бүсэд амьдардаггүй сурагчид IB өргөдлөөс гадна шилжин суралцах өргөдөл мөн гаргана.</li> <li>• Хөтөлбөрийн талаар болон шилжин суралцах үйл явцын талаар илүү мэдээлэл авах бол цахим хуудсаар нь зочилно уу  <a href="#">Washington-Liberty сургууль дахь IB хөтөлбөр</a></li> </ul>
Испани хэлний хөтөлбөр	Wakefield ахлах сургууль	<ul style="list-style-type: none"> <li>• Сургуульд хамрагдах бүсийн сурагчид, Gunston дахь хөтөлбөрт хамрагдаж байсан сурагчид, болон Испани хэлний зохих түвшний мэдлэгтэй болохоо харуулсан сурагчид элсэх боломжтой.</li> <li>• Wakefield дэх бүсэд хамаарахгүй сурагчид шилжин суралцах өргөдөл гаргах хэрэгтэй.</li> <li>• Хөтөлбөрийн талаар болон шилжин суралцах үйл явцын талаар илүү мэдээлэл авах бол цахим хуудсаар нь зочилно уу  <a href="#">Wakefield дэх Испани хэлний хөтөлбөр</a></li> </ul>

<p>Шинжлэх ухаан, технологийн Thomas Jefferson ахлах сургууль</p>	<p>Шинжлэх ухаан, технологийн Thomas Jefferson ахлах сургууль, Fairfax дүүргийн улсын сургуулиуд</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Одоо 8-р ангид суралцаж буй Алгебр I (эсхүл түүнээс дээш түвшний математик) хичээл авч байгаа аливаа APS сурагч элсэхээр өргөдөл гаргах боломжтой.</li> <li>• Бүх өргөдөл гаргагч Thomas Jefferson-ний элсэлтийн шалгалтыг өгөх ёстой</li> <li>• Сургуулийн талаар болон түүнд хэрхэн элсэх талаар мэдээлэл авах бол дараах цахим хуудсаар зочилно уу <a href="#">TJHSST Элсэлт</a></li> </ul>
---	--	---


# APS-ийн дунд сургуулийн математикийн хичээлийн зам



Бүх ангиудад “Математикийн стратегиуд” хичээл орох боломжтой ба энэ хичээлийг ангийн түвшинд хүрэхэд тусламж хэрэгтэй байгаа сурагчид сонгож болно.

## Арлингтоны улсын сургуулийн Алгебр I-ээс дээших математикийн сургалт

Сурагч Алгебр I хичээлд суусны дараа (тухайн сурагчаас хамаараад өөр түвшинд байх болно) цааших сургалтууд эхэлнэ. Сурагчийн түвшин, бэлэн байдлаас хамаарч янз бүрийн замаар хичээл, сургалтад хамрагдана. Бэлтгэл хийх шаардлагын талаар мэдэж авахын тулд хичээлийн тодорхойлолтыг харна уу.



Энд дурдаагүй ОУБ болон давхар элсэлттэй хичээлийн талаар мэдэхийн тулд ахлах сургууль бүрд заагдаж буй хичээлийн индексийг харна уу.

Нэмэлт дэмжлэг шаардлагатай сурагчид Алгебр I, Геометр, эсхүл Алгебр II болон Стратегийн хичээлүүдэд зэрэг элсэн суралцах боломжтой.

\*AFDA-г Алгебр I-ийн дараа болон геометрийн дараа ЭСХҮЛ геометрийн дараа бөгөөд Алгебр II-ын өмнө зөвхөн ахлах сургуульд авах боломжтой.

### Дэлхийн хэлний сургалтын дараалал<sup>1</sup>

#### Америк дохионы хэл

7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин		
	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	
		1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин
			1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин
				1-р түвшин	2-р түвшин

#### Араб хэл

7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	5-р түвшин ОУБ/И	ОУБ II
	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	5-р түвшин
		1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин

#### Хятад хэл

7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	Хятад хэл ба соёл, AP/IB I	ОУБ II
	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	Хятад хэл ба соёл, AP
		1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин

#### Франц хэл

7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	5-р түвшин эсхүл Франц хэл ба соёл, AP эсвэл ОУБ I*	Франц хэл, соёл, AP эсвэл франц хэл эсвэл ОУБ II гүнзгийрүүлсэн судлал
	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	5-р түвшин эсхүл Франц хэл ба соёл, AP
		1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин
			1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин
				1-р түвшин	2-р түвшин
					1-р түвшин

#### Герман хэл

7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
		1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	
			1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин
				1-р түвшин	2-р түвшин
					1-р түвшин

<sup>1</sup> Энэ дараалал нь ердийн хөтөлбөрийнх болно. Олон улсын бакалаврын хэлний хичээлүүдтэй бүрэн танилцах бол Ахлах сургуулийн сургалтын хөтөлбөрийг үзэж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

**Япон хэл**

7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
		1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	
			1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин
				1-р түвшин	2-р түвшин
					1-р түвшин

**Латин хэл**

7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	5-р түвшин эсвэл латин хэл, АР эсвэл ОУБ I	Латин хэл, АР эсхүл Ахисан түвшний Латин хэл эсвэл ОУБ II
	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	5-р түвшин эсхүл Латин хэл, АР
		1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин
			1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин
				1-р түвшин	2-р түвшин
					1-р түвшин

**Испани хэл**

7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	5-р түвшин эсхүл Испани хэл ба соёл, АР  эсвэл ОУБ I	Испани хэл ба соёл, АР эсхүл Испани уран зохиол, АР эсвэл Ахисан түвшний Испани хэл эсвэл IB II
	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	5-р түвшин эсхүл Испани хэл ба соёл, АР
		1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин
			1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин
				1-р түвшин	2-р түвшин
					1-р түвшин

**Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан испани хэл**

7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги	12-р анги
1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	Испани хэл ба соёл, АР	Испани уран зохиол, АР	Ахисан түвшний Испани хэл
	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	Испани хэл ба соёл, АР	Испани уран зохиол, АР эсвэл Ахисан түвшний Испани хэл
		1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	Испани хэл ба соёл, АР
			1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин
				1-р түвшин	2-р түвшин
					1-р түвшин

**Тайлбар:**

1. Герман, япон хэлийг зөвхөн ахлан сургуулийн түвшинд санал болгоно.
2. Washington Liberty ахлах сургуулиас бусад ахлах сургуульд Хятад хэлийг онлайн хэлбэрээр Хятад төрөлх хэлтэй туслахын тусламжтайгаар зааж байгаа.
3. AP эсвэл ОУБ-ын шалгалтыг Америк дохионы хэл эсхүл араб хэлээр өгөх боломжгүй.
4. ОУБ-ын түвшний хэлийг Washington Liberty ахлах сургуульд зөвхөн судлах боломжтой.
5. AP хичээлийг Герман болон Япон хэл дээр авах боломжгүй.
6. Нэг буюу түүнээс дээш гадаад хэлийг ахисан түвшинд эзэмшсэн болохыг харуулсан APS сурагчид Шалгалтаар олох кредитэд амжилттай оролцох замаар 4 хүртэл кредит (1-4-р түвшин) цуглуулах боломжтой. Илүү мэдээлэл авахын тулд [www.apsva.us/worldlanguages\\_](http://www.apsva.us/worldlanguages_) хаягаар орно уу. Давхар кредит олгохгүй.

## АХЛАХ СУРГУУЛЬ ТӨГСӨХӨД ТАВИХ ШААРДЛАГА

Сурагч анх 9-р ангид орох үед хүчин төгөлдөр байсан шаардлагууд диплом авч, Виржиниягийн ахлах сургуулийг төгсөхөд тавигдана. Сурагчид Виржиниягийн ахлах сургуулиас төгсөхдөө диплом авна.

9-р ангиас доош ангийн сурагчид 9-өөс 12-р ангийн кредит авахад зориулагдсан хичээлийг амжилттай дүүргэсэн бол тэдгээр кредитийг төгсөхөд шаардагдах стандарт нэгжид тооцно. Эдгээр хичээлүүдэд баталгаажсан нэгж кредит авахыг хүсвэл, сурагчид Виржиниягийн чанарын стандартад тавигдсан шаардлагыг хангах ёстой (.8VAC20-131-110).

Боловсролын зөвлөлөөс зөвшөөрсөн нэмэлт шаардлагыг сургуулийн зөвлөлөөс нэвтрүүлснээс бусад тохиолдолд диплом авахад тавигдах шаардлага нь зөвхөн дараах шаардлагууд байна. Сургуулийн зөвлөлөөс нэвтрүүлсэн Боловсролын зөвлөлөөс зөвшөөрсөн бүх нэмэлт шаардлагууд тухайн сургуулийн зөвлөлөөс тэдгээрийг өөрчлөх эсхүл цуцлах хүсэлт гаргах хүртэл хүчин төгөлдөр байна.

### Стандарт дипломд тавигдах шаардлага.

2013 оноос өмнөх анхны есдүгээр ангийнхан 2018-19 оны есдүгээр ангийнхнаас эхлээд сурагчид стандарт болон баталгаажсан нэгж кредит цуглуулах шаардлагатай.

Стандарт дипломтой төгсөхийн тулд сурагч заавал авах хичээл болон сонгон сургалцах хичээлд тэнцэх замаар 22-с доошгүй стандарт нэгж кредит цуглуулж, хичээлийн төгсгөлд авдаг SOL шалгалтад эсхүл Боловсролын зөвлөлөөс баталсан бусад үнэлгээнд тэнцэх замаар таваас доошгүй баталгаажсан кредит цуглуулах шаардлагатай.

Түүнчлэн сурагчид дараах шаардлагыг хангана:

- Ахисан түвшинд тэнцэх, шагнал авах, олон улсын бакалаврын эсхүл хосолсон элсэлтийн хичээл дүүргэх; ажлын байран дээр суралцахад холбогдож дээд зэргийн амжилт үзүүлсэн; эсхүл карьерын болон техникийн боловсролын гэрчилгээ авсан.
- Нэг виртуал сургалтыг амжилттай дүүргэсэн.
- Яаралтай анхны тусламж үзүүлж, зүрх-уушгины сэргээх арга (CPR) хэрэглэж сурах, автомат гадаад дефибриллятор (AED) ашиглаж сурах, түүний дотор зүрхний сэргээх массаж хийхэд шаардлагатай ур чадварыг эзэмших дадлага мөн орно.
- Виржиниягийн суурь ур чадварууд болох 5 C: тунгаан бодох, бүтээлчээр бодох, хамтран ажиллах, харилцан яриа ба иргэншил.

Салбар	Шаардлагатай стандарт нэгж кредит	Шаардлагатай баталгаажсан кредит
Англи хэл (унших болон бичих)	4	2
Математик	3	1
Байгалийн ухаан	3	1
Түүх, нийгэм судлал	3	1
Эрүүл мэнд, Бие бялдрын боловсрол	2	
Дэлхийн хэлнүүд Дүрслэх урлаг эсхүл мэргэжил, техникийн боловсрол	2	
Эдийн засаг, хувийн санхүү	1	
Сонгон суралцах	4	Энэ шаардлагыг хангах хичээл нь хоёроос доошгүй дараалан сонгон суралцах хичээл байна.
Нийт	22	5



## Ахисан түвшний сургалтын дипломд тавигдах шаардлага.

2018-19 оны есдүгээр ангийнхнаас эхлээд сурагчид стандарт болон баталгаажсан нэгж кредит цуглуулах шаардлагатай.

Ахисан түвшний сургалтын дипломтой төгсөхийн тулд сурагч заавал авах хичээл болон сонгон сургалцах хичээлд тэнцэх замаар 26-с доошгүй стандарт нэгж кредит цуглуулж, хичээлийн төгсгөлд авдаг SOL шалгалтад эсхүл Боловсролын зөвлөлөөс баталсан бусад үнэлгээнд тэнцэх замаар таваас доошгүй баталгаажсан кредит цуглуулах шаардлагатай.

Түүнчлэн сурагчид дараах шаардлагыг хангана:

- Ахисан түвшинд тэнцэх, хүндэтгэл, олон улсын бакалаврын эсхүл хосолсон элсэлтийн хичээл дүүргэх; дээд зэргийн чанартай ажил дээр суралцсан туршлага хуримтлуулсан; эсхүл карьерын болон техникийн боловсролын гэрчилгээ авсан.
- Нэг виртуал сургалтыг амжилттай дүүргэсэн.
- Яаралтай анхны тусламж үзүүлж, зүрх-уушгины сэргээх арга (CPR) хэрэглэж сурах, автомат гадаад дефибриллятор (AED) ашиглаж сурах, түүний дотор зүрхний сэргээх массаж хийхэд шаардлагатай ур чадварыг эзэмших дадлага мөн орно.
- Виржиниягийн суурь ур чадварууд болох 5 C: тунгаан бодох, бүтээлчээр бодох, хамтран ажиллах, харилцан яриа ба иргэншил.

Салбар	Шаардлагатай стандарт нэгж кредит	Баталгаажсан кредит Шаардлагатай
Англи хэл (унших болон бичих)	4	2
Математик	4	1
Байгалийн ухаан	4	1
Түүх, нийгэм судлал	4	1
Дэлхийн хэлнүүд	3	Энэ шаардлагыг хангах хичээлүүдэд нэг хэлийн гурван жил эсхүл хоёр хэлийг хоёр жил суралцах хамаарна.
Эрүүл мэнд, Бие бялдрын боловсрол	2	
Дүрслэх урлаг эсхүл мэргэжил, техникийн боловсрол	1	
Эдийн засаг, хувийн санхүү	1	
Сонгон суралцах	3	Энэ шаардлагыг хангах хичээл нь хоёроос доошгүй дараалан сонгон суралцах хичээл байна. Дэлхийн хэлнүүдийн 1 ба 2-р түвшнийг дараалан сонгон суралцах хичээлд тооцохгүй. Учир нь дэлхийн хэлнүүд нь тусдаа шаардлагатай.
Нийт	26	5

Арлингтоны улсын сургууль нь арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг хандлага, иргэншил, нас, хөгжлийн бэрхшээл, жирэмслэлт, гэрлэлтийн байдал зэргээр ялгаварлан гадуурхахыг хориглодог. Энэхүү журам нь сургалт, хөтөлбөр, зөвлөх үйлчилгээ, биеийн тамирын боловсрол, спорт, мэргэжлийн боловсрол, сургалтын материал, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд ижил тэгш хамрагдах боломжийг олгодог. Журмыг зөрчсөн тохиолдлыг Захиргааны үйлчилгээний албаны орлогч даргад (703) 228-6008, эсвэл Хүний нөөц хариуцсан орлогч даргад (703) 228-6110 дугаарт залгаж тус тус мэдэгдэнэ үү.



Arlington  
Public  
Schools